

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-7

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 8-91

1.Хуулийн эцсийн найруулга сонсох	9
2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	9-54
3.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх	54-55
4.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар	55-90
5.Хуулийн эцсийн найруулга сонсох	90-91

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит чуулганы
10 дугаар сарын 25-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 68 гишүүн хүрэлцэн ирж, 54.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Д.Батлут, Х.Баттулга, Б.Бат-Эрдэнэ, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Б.Мөнхсоёл, Н.Наранбаатар, Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, П.Сайнзориг, Ө.Шижир;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баясгалан, Х.Болормаа, Б.Пунсалмаа, Ж.Чинбүрэн, Д.Энхтүвшин;

Тасалсан: Ш.Бямбасүрэн;

Хоцорсон: Н.Алтанхуяг- 01 минут, Н.Алтаншагай- 1 цаг 41 минут, С.Амарсайхан- 11 минут, Х.Баасанжаргал- 02 минут, Ц.Баатархүү- 01 минут, М.Бадамсүрэн- 08 минут, Б.Батбаатар- 06 минут, Н.Батсүмбэрэл- 2 цаг 49 минут, Ж.Бат-Эрдэнэ- 02 минут, Б.Батцэцэг- 21 минут, А.Ганбаатар- 01 минут, Г.Ганбаатар- 01 минут, Д.Ганбат- 30 минут, Л.Гантөмөр- 2 цаг 39 минут, Ц.Даваасүрэн- 07 минут, Т.Доржханд- 20 минут, Д.Жаргалсайхан- 29 минут, Б.Заяабал- 07 минут, Ж.Золжаргал- 13 минут, С.Лүндэг- 20 минут, М.Мандхай- 06 минут, З.Мэндсайхан- 25 минут, Б.Найдалаа- 01 минут, М.Нарантуяа-Нара- 02 минут, Ч.Номин- 07 минут, С.Одонтуяа- 1 цаг 59 минут, О.Саранчулуун- 15 минут, Ц.Туваан- 04 минут, Б.Тулга- 03 минут, Г.Тэмүүлэн- 03 минут, Н.Учрал- 01 минут, Г.Уянгахишиг- 01 минут, Дам.Цогтбаатар- 03 минут, Б.Чойжилсүрэн- 25 минут, Л.Энх-Амгалан-14 минут.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягаас ирүүлсэн албан бичгийг танилцуулав.

Нэг.Хуулийн эцсийн найруулга сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:02/

Уг асуудлыг 10 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төслийг хэлэлцсэн эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Г.Лувсанжамц, О.Цогтгэрэл, Б.Түвшин, О.Номинчимэг, Б.Энхбаяр, Р.Сэддорж, Д.Ганмаа, Ж.Баярмаа, С.Эрдэнэбат, Д.Пүрэвдаваа, Г.Уянгахишиг, М.Мандхай, Б.Батбаатар, М.Бадамсүрэн нарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Сангийн сайд Б.Жавхлан, Боловсролын сайд П.Наранбаяр, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, С.Амарсайхан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, мөн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, С.Эрдэнэбат, Б.Жаргалан, Б.Батбаатар, П.Ганзориг нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн болон “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай”, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Тогтоолын хавсралтад нэмэлт

оруулах тухай”, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлж, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт дээрх хууль, тогтоолын төслүүдийг төсөл тус бүрээр санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65

Татгалзсан: 40

Бүгд: 105

61.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул тус бүрээр санал хураалт явуулахаар тогтов.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 38

Бүгд: 105

63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 38

Бүгд: 105

63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 45

Бүгд: 105

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 43
Бүгд: 105
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн:

1.Байнгын хорооны саналаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 87
Бүгд: 105
17.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Байнгын хорооны саналаар Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 87
Бүгд: 105
17.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Байнгын хорооны саналаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 90
Бүгд: 105
14.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу Засгийн газраас 2024.10.25-ны өдөр Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг танилцуулав.

Д.Амарбаясгалан: Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 41
Бүгд: 105
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.

Уг асуудлыг 12 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 39 минут үргэлжилж, 12 цаг 39 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 15 цаг 09 минутад эхлэв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн талаар санал хураалтыг явуулав.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 52
Бүгд: 106
50.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг “дэмжсэнээр” хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэхээр бичгээр гаргасан саналыг үндэслэн дэмжсэнээр тооцов.

Нийт 105 гишүүнээс 55 гишүүн дэмжиж, 52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж

хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /“Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар/

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны Ажлын албаны дарга О.Нарандэлгэр, мөн хорооны даргын зөвлөх Д.Одгэрэл, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт, Авто замын бодлого зохицуулалтын газрын дарга Ч.Сугармаа, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Артур, Хилийн боомтын захиргааны дарга Б.Батхишиг, Боомтын үйл ажиллагааны хэлтсийн дарга Д.Балдорж, Гаалийн ерөнхий газрын Боомтын хэлтсийн дарга Д.Зоригоо, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Хяналт шалгалтын газрын дарга Т.Нармандах, ахлах зөвлөх Ч.Онончимэг, Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анар нар байлцав.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар мэдээлэл хийв.

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийн төлөөллөөс Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Ж.Золжаргал, А.Ундраа, Б.Батбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл горимын санал гаргаж, Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан тайлбар хэлэв.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан үг хэлж, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан нар тайлбар хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл, Ж.Баярмаа, Р.Батболд, Г.Ганбаатар, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан нар хариулж, тайлбар хийв.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.11-д заасны дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан нар хариулж, тайлбар хийв.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар мэдээлэл хийлээ.

Уг асуудлыг 17 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Хуулийн эцсийн найруулга сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Төрийн өмчийг нийслэлийн өмчид шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./17:07/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, Ш.Мөнхцөөж, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 37 минут үргэлжилж, 126 гишүүнээс 107 гишүүн хүрэлцэн ирж, 84.9 хувийн ирцтэйгээр 17 цаг 07 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өглөөний амар амгаланг айлтгая.

Хуралдааны ирц 54 хувь буюу 68 гишүүн ирцэд цагтаа бүртгүүлсэн байна. Хуралдаанаа эхлүүлье.

Өнөөдөр 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх 4 асуудал байна.

1 дүгээрт, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг сонсоно.

2 дугаарт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

3 дугаарт, Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. Засгийн газраас Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар яаралтай хэлэлцүүлэхээр өргөн барьсан байгаа.

Үдээс хойших нэгдсэн хуралдаан “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно.

Хэлэлцэх асуудалтай холбоотой Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг бас горимын санал гаргахаар бичиг ирүүлсэн. Гэхдээ дэгийн тухай хуулиараа тухайн өдөр чуулганаар хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулахаар горимын санал гаргана гэсэн хуулийн заалт байгаа. Алтанхуяг гишүүнээс ирсэн горимын санал нь өнөөдрийн хэлэлцэх асуудалтай шууд холбоотой асуудал биш учраас горимын саналаар санал хураалгах боломж байхгүй байна.

Бас санал ирүүлж байгаа гишүүд маань яг энэ дэгийн тухай хуулиа сайтар үзэж, яг тэр хуулийнхаа дагуу горимын саналаа гаргаж явахгүй бол яг тэр гаргасан санал хүсэлтийг хэрэгжүүлэх боломж байхгүй байгаа гэдгийг бас зөв ойлгоорой.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу Хууль зүйн байнгын хороо хуулийн эцсийн найруулгыг бэлтгэж, танилцуулахад бэлэн болсон байна.

Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулга тараагдсан байна. Алга байна.

Тэгэхээр эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10.02 цаг

Дараагийн асуудал.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Жавхлан: Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт 5 хуулийн төсөл, 3 Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Хууль тогтоомжийн төслүүдийн талаар товч дурдвал:

1. Хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, төсөв хооронд үе шаттай оновчтой зохицуулалт хийх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд олон нийтийн болон хараат бус хөндлөнгийн хяналтыг өргөжүүлж, сахилга бат, хариуцлагыг сайжруулж, үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлэн боловсруулах үйлдвэрүүдийг татварын бодлогоор дэмжих зорилгоор Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, бүсийн хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан импортыг орлого, экспортыг нэмэгдүүлэх төслийг дэмжих зорилгоор ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

4. Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээл дэх арилжаанд оролцогчдын эрэлтийг нэмэгдүүлэх, жишиг хүүг тогтоох, хоёрдогч зах зээл дэх үнэт

цаасны хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах, олон улсын жишигт нийцүүлэх, үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

6. Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах, байгаль, цаг уурын болон бусад болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг тус тус боловсрууллаа.

Хууль тогтоомжийн төслүүд батлагдсанаар бүтсэн хөгжлийг дэмжиж, хамтарсан Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөгжлийг хурдасгах, хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүд цаг алдалгүй шуурхай, үр дүнтэй хэрэгжих боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Жавхлан сайдад баярлалаа.

Төслүүдийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 5 хуулийн төсөл. Монгол Улсын Их Хурлын 3 тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа явууллаа.

Хууль санаачлагчаас эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгож, төсөв хооронд үе шаттай, оновчтой зохицуулалт хийх, импортыг орлох, экспортыг дэмжсэн татварын бодлогыг хэрэгжүүлэх, мөн Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээл дэх арилжаанд оролцогчдын эрэлтийг нэмэгдүүлэх, 2 дахь зах зээлд үнэт цаасны арилжааг эхлүүлэх, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, олон улсын жишигт нийцүүлэх, нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, бүс орон нутгийн хөгжлийг дэмжих, Ургамал хамгааллын тухай хууль батлагдсантай холбогдуулан төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид зохих өөрчлөлт оруулах зэрэг зорилгын хүрээнд холбогдох хууль тогтоомжийн төслүүдийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хууль тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Засгийн газраас гаргах дотоод, гадаад бондын хэмжээ, зориулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан виртуал бүсэд бүртгэлтэй харьяалалгүй иргэн хуулийн этгээд, ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан хөнгөлөлтөд хамрагдах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Төрийн банкны үйл

ажиллагаанд ногоон хөгжлийг дэмжих тусгайлсан чиг үүргийг нэмэгдүүлж байгаа нь хэр оновчтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдсэн дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй барилгын материал, тоног төхөөрөмжийг гаалийн татвараас бүрэн чөлөөлж байгаа нь үндэсний үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй талаар санал хэлж, бүсчилсэн хөгжлийн бүтээн байгуулалтыг татварын бодлогоор хэрхэн дэмжих талаар асуулт асууж хариулт авсан болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан татварын хөнгөлөлт чөлөөлөлтөд хамрагдах ААН-ийн тоо болон дээрх татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн хөрөнгөөр хийгдэх бүтээн байгуулалтын ажлыг тооцсон эсэх, төрийн захиргааны байгууллагын бүтцэд өөрчлөлт оруулан Ургамал хамгааллын газар байгуулах нь хэр үр дүнтэй эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн хуримтлалын дүн, нийгмийн даатгалын сан болон ЭМД-ын сангийн орлого зарлагын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар Үндэсний баялгийн санд АМНАТ-өөс төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг өөрчилсөн шалтгаан, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хэрэгжилтийг төсвийн бодлоготой хэрхэн уялдуулж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдэд тусгагдсан татварын хөнгөлөлт чөлөөлөлттэй холбоотой зохицуулалт нь Үндсэн хуульд заасан Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд халдсан эсэх талаар асуулт асууж, хариулт авсан өолно.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн төсөлд дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах барилгын материал, тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөхөөр тусгасныг тодорхой болгох, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн хуримтлалын өгөөжийг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн тогтолцоог шинэчлэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ж.Баярмаа нар УИХ татвар тогтоох, хөнгөлөх, чөлөөлөх онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлэх нь зүйтэй гэж саналууд гаргасан болно.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай”, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн бөгөөд ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай”, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батжаргал гишүүнд баярлалаа.

Ажлын хэсэг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Доржсүрэнхорлоогийн Саруул ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгө, удирдлагын хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга гэсэн ажлын хэсэг ирсэн байна.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна.

Яриагаа багасгая, гишүүд ээ. Ирсэн нэрсийн дарааллаар Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр төсөв дээр би үгээ хэлчихсэн. Өөрөөр хэлбэл сум болгонд зардал нэмдэг. Хөрөнгө оруулалтыг тавихгүйгээр зөвхөн 38 төсөл, арга хэмжээ мөнгө олдог, тэр төсөл арга хэмжээн дээр төсвөөр дамжуулж эдийн засгийг тэлэх тэр хөрөнгө оруулалтыг хийж байгаа учраас би энэ төсөв дээр дэмжиж байгаа.

Тэгэхээр ард түмнийхээ үгийг Их Хурал дээр хэлэх боломж гарахгүй байна. Тийм учраас би өөрийнхөө цаг дээр ард түмнийхээ захисан үгээ хэлэхээр шийдлээ.

Тэгэхээр төр, нийгмийн ахмад зүтгэлтэн, нэрт зүтгэлтэн Думаагийн Содном гуай надтай уулзаад энэ 1 дүгээрт нь, ард түмний засаглалыг бий болго оо, ард түмний засаглалыг намын засаглалтай хамтдаа байлгаж байж, төр тогтвортой хүчтэй байна. Энэ тал дээр ажилла аа.

2 дугаарт нь, боловсруулах үйлдвэрээ төрөөс дэмжиж байгуулж байж, эдийн засгаа хүчирхэг болгох хэрэгтэй гэдэг ийм зүйлийг захисан шүү гэдгийг хэлмээр байна.

Сумуудаар явж, багуудаар явж уулзалт хийсэн. Зэрэг сумын Бороо багийн Баяраа гэдэг хүн манай баг 130 өрхтэй, өрх болгон 10 мал, 1300 малыг алдлаа. Нийтдээ 130 сая төгрөгөөр бид нар хохирлоо. Тийм учраас энэ багийн эмчийг цалинжуулах, үржлийн тасгийг сайжруулах энэ тал дээр ХХААЯ ажиллах ёстой гэж захиж байна.

Чандмань сумын Талын булаг багийн Дашзэвэгийн Баттулга 12 сарын 1-ний хөдөөгийн хүүхдийн амралтыг хойшлуулаад 3 сарын 1-нээс 4 сарын 1 болгож, тэр хүүхдүүдийг ер нь малч болгох илүү амьдралд ойрхон байлгах тэр ажлыг хиймээр байна. Энд Боловсролын яам анхаараарай гэж хэлж байна.

Эрдэнэбүрэн сумын Намаржин багийн Сампилын Цэрэнчимэд гэдэг хүн Пүрэвдорж гишүүн ээ, та энэ манай багаас 1 дүгээр байраар гарсан. Манай Ховд аймагт ганцхан Эрдэнэбүрэн сум бол Өөлд сум байдаг. Бид нар адилхан бодол санаатай улсууд. Гэтэл бид нар ингээд таныг 1 дүгээр байраар гаргаад өгч байхад сумын төв дээр 11 дүгээр байраар та орж байна. Энэ яасан бэ гэхээр энэ мөнгө тараалт чинь хэтэрхий их явсан. Сумын төв дээр 1 айлд 2 сая төгрөг өгсөн байна. 1 хүнд сая 200 мянган төгрөг өгч байж энэ сонголт хийгдсэн. Төр их замбараагүй, их муухай одоо энэ сонголт болж байна шүү. Энэ дээрээ анхаараарай гэж хэлж байна.

Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын өндөр настан Ахбай гуай надад үг захисан. Харамсалтай нь энэ үг хэлэх хооронд хөөрхий талийгаач болчихлоо. Тэгсэн ч гэсэн үгийг нь хэлье гэж бодож байна. Тэгэхээр энэ малчны хоршооны энэ асуудал бас нэг зөв биш шүү. Тэр Амарбаясгалан дарга дээр энэ хурал дээр бас энэ асуудлыг нэлээн сайн ярьсан. Тийм учраас энэ Бэлчээрийн тухай хууль болон бусад зүйлүүдийг нарийн сайн зохицуулж байж, асуудлыг шийдэхгүй бол хэтэрхий их тийм, барууны эрчимжсэн аж ахуйг түшиглэсэн тийм хуулиуд ер нь явах гээд байна.

Тийм учраас энэ дээр бас анхааралтай байгаарай гэж захиж байна.

Тэгээд яаж бид нар нэг энэ Их Хурал дээр ард түмнийхээ үгийг дамжуулах юм бэ? Энэ хүмүүсийн үгийг дамжуулж байж, бид нар бас энэ төрд түмний төлөөлөл болох ёстой тэр үүрэг маань бид нар ерөөсөө байхгүй болчихоод байна. Энэ асуудлыг энэ дэгийн тухай хуулиар шийдвэрлэж бас энэ хөдөө орон нутагт ажилласан, тэр ахмадууд, тэр ухаантай хүмүүсийн үгийг төрд дамжуулах нь бидний хамгийн чухал үүрэг шүү. Тэгээд энэ дээр бас урьд нь боломж байдаг байсан, үүнийг байхгүй болгосон одоо эрх баригч нарт үнэхээр харамсаж байна.

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүн үг хэллээ. Ард иргэд, тойргийн сонгогчдоос ирж байгаа санал, хүсэлттэй холбоотой асуудлаар бас тодорхой ажил зохион байгуулж, Байнгын хорооны түвшинд юм уу бас ярьж байх боломж нөхцөлийг нээх боломж бидэнд байгаа.

2 дугаарт, бас сар бүр бүрийн сүүлийн 7 хоногт Засгийн газраас хийх мэдээлэлтэй холбоотойгоор иргэд, сонгогчдын тодорхой саналыг дамжуулж, үг хэлэх тэр нөхцөл боломжийг намын бүлгүүдэд, бүлэггүй намын төлөөллүүдэд бас олгох боломж бас дэгийн тухай хуулиараа байгаа гэдгийг хэлье ээ.

Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууна.

Г.Лувсанжамц: Өглөөний мэнд хүргэе. Төсвийн тухай хуулийг дагаж орж байгаа хуулиуд дээр 2 том чухал хууль өөрчлөлтийг оруулъя гээд орсон байгаа. Эхнийх нь ААНОАТ-ын тухай хууль, хоёрдугаарх нь гаалийн хөнгөлөлтийн талаар зүйлүүд орсон байна.

Өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хороо дээр хурал дээр хоёуланг нь хэлэлцэхгүй гээд унагасан тийм нөхцөл байдал, мэдээлэл авчхаад сууж байна л даа. Үүнийг яагаад гишүүд дэмжихгүй байгаа, яагаад Байнгын хороо дээр үүнийг дэмжихгүй байгаа гэдэг дээр их эргэлзээтэй санал төрж байна. Манай улс бүс бүсчилсэн хөгжлийн реформ хийнэ гээд 6 бүсээ тэргүүлэх чиглэл, салбар, жишээлэх юм бол эрчимжсэн мал аж ахуй, соёлын өв дагасан олон улсын аялал жуулчлалын бүс гэх мэт экспортыг дэмжих, гаднаас жуулчдыг оруулж ирэх, валютыг оруулж ирээд төгрөгийн ханшийг чангаар өндөр барих боломжтой, тогтвортой барих боломжтой ийм төслүүдийг дэмжих ёстой гээд үйлдвэрлэлд зориулсан бүхий л тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлнө өө гэсэн зүйл заалт орсон байгаа.

Манай бүсүүд маань бүсийнхээ төв дээрээ хаана үйлдвэрлэлээ ямар үйлдвэрлэлээ хийх ёстой вэ гээд хөрөнгө оруулалтаа хийх ёстой гээд Шинэ хоршоо хөдөлгөөнөөр хөнгөлөлттэй зээл олгож байгаа шүү дээ. Энэ зээлтэйгээ зэрэгцээд хөнгөлөлттэй буюу гаалийн татвараас хөнгөлөлттэй үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдаж авах юм бол манай бүсүүд үйлдвэр хөгжөөд, орлого нэмэгдээд, манай малчид маань давхар орлоготой болоод, нийгэм, эдийн засгийн хувьд ч гэсэн сайжрах хандлага харагдах тийм зүйл байгаад байгаа юм. Өнөөдөр ингээд хэлэлцэх эсэх асуудлаар ингээд санал хураах гэж байгаа болохоор Байнгын хороон дээр дэмжигдээгүй энэ саналыг манай гишүүд маань дэмжээд, бүсчилсэн хөгжлийн реформыг цааш нь эрчтэй явуулахын тулд ААН-үүдийг үйлдвэрлэлд чиглэсэн, экспортод гаргах бүтээгдэхүүнтэй болгох, үйлдвэрчин Монгол Улсыг бий болгоход энэ төслүүдийг дэмжиж өгөөд явуулаасай гэсэн бодолтой байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн гишүүн хариулъя.

Ц.Даваасүрэн: Тийм. Өчигдөр Байнгын хороогоор энэ 2 татварын хуулийг хэлэлцэхэд бас гишүүд дэмжээгүй нэг тийм буруу ойлголт бас гарсан гэж би ингэж бодоод байгаа юм. Тэр боловсруулах үйлдвэрлэлд чиглэсэн үндсэн хөрөнгийн зориулалттай тоног төхөөрөмжийг татвараас, гаалиас чөлөөлье л гэж байгаа асуудал шүү дээ. Их Хурал тэгж л шийддэг. Тэгэхээр үйлдвэрлэлтэй байя, боловсруулах үйлдвэртэй байя гэвэл бид нар үүнийг Их Хурал ингээд л шийдэх ёстой. Тэр энд Их Хурлын үндсэн эрхэд халдаж байгаа юм байхгүй. Их Хурал ийм төхөөрөмж, тийм төхөөрөмж байна гэдгийг нь Их Хурал яриад байвал энэ чинь бас утгагүй юм болно шүү дээ.

Тийм учраас угаасаа Их Хурлын түүхэндээ бид нар ийм зориулалтын ийм зүйлийг чөлөөл гээд ингээд л яачихдаг. Зүгээр гишүүд жагсаалтыг ингээд өөрсдөө баталъя гээд байгаа учраас би яах вэ, энэ хуулиуд хэлэлцэгдсэний дараа тэр ААНОАТ-аас чөлөөлж байгаа тэр бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн гэдэг нэлээн ерөнхий байгаа юм. Үүнийг харин эргэж авч үзээд, энийгээ нэлээн нарийвчилж өгөөд, жагсаалтыг нь яах вэ, Их Хурал баталдаг л больё. Манай шинэ гишүүд зав ихтэй байгаа. Тэгээд Их Хурал баталдаг больё гээд байгаа юм шиг байна лээ. Түүнээс бид нар түүхэндээ ингээд жагсаалтыг бол баталдаггүй л байсан л даа. Ер нь бол. Ерөнхийд нь ийм татварыг чөлөөлье гээд л шийдвэр гарчихдаг.

Тэр жагсаалтыг нь Засгийн газар хийгээд л явдаг байсан. Зүгээр гишүүд маань Их Хурал дээрээ хийе гээд байгаа юм шиг байна лээ.

Тийм учраас хэлэлцэх эсэх нь санал хураалт явахаар, хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, тэгээд яах вэ, Их Хурал дээрээ татаад л авъя. Ер нь зүгээр үйлдвэрлэлийн чиглэлийн үйл ажиллагааг бид нар дэмжих ёстой юу гэвэл дэмжих ёстой. Халамж дэмждэг байж болохгүй ээ. Монголын төр. Халамж гээд л тэгэхээр л нөгөө улс төрийн санал авах нь бодогддог юм уу, дэмжээд байдаг. Үйлдвэр гээд тэгэхээр л татгалзаад байдаг Их Хурал байж болохгүй шүү дээ.

Тийм учраас үйлдвэрлэлийг дэмжих юмыг хийж өгөхгүй бол болохгүй. Тэгэхгүй бол Хятадын зах зээлтэй манай үйлдвэрлэгч нар өрсөлдөж чадахгүй. Тэгээд бид нар импортын татвараар хамгаалах ёстой. Тийм учраас энэ татварын асуудал дээр хэдүүлээ жоохон анхааралтай хандахгүй бол нэг жоохон буруу зөрүү ойлголт явчих шиг болно лээ. Өмнө нь ийм л байсан. Одоо яах вэ, жагсаалтаа баталдаг болъё гэж байгаа бол баталж болно. Хэдүүлээ яах вэ, нэг батлаад л үзье. Тэгэхдээ үргэлж жагсаалт ингээд л гарахаар бид нар баталдаг болно гэсэн үг шүү дээ. Хүнд суртал нэмэгдэнэ, тэр татварын байгууллагаар явж байгаа ААН-үүдийн хүнд суртал нэмэгдэнэ. Их Хурал руу нөгөө шийдвэр нь гарах гэдэг шат дамжлага нэмэгдэнэ. Ийм л зүйл болох юм байгаа юм. Тэгээд юу ч гэсэн хэдүүлээ хэлэлцээд явъя. Тэгээд үүнийг нь шийдэж өгсөн нь дээр. Энэ бизнес эрхлэгч нартаа энэ татварын асуудлыг.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт өгөх хүн байгаа юу? Алга байна.

Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Саяын Лувсанжамц гишүүний асуулттай Даваасүрэн гишүүний юутай давхацчихлаа. Тэгэхээр асуух юм байхгүй.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын парламентын сонгуулийн үр дүнгээр хамтарсан Засгийн газар байгуулагдсан. Хамтарсан Засгийн газрын оролцогчид нь нэг нь татвар өндөр байж болно, халамж өндөр байж болно, төрийн оролцоо өндөр байж болно гэдэг нам. Нөгөө талд нь татварыг багасгая, төрийн оролцоог багасгая гэдэг үзэл баримтлал бүхий ингээд эсрэг тэсрэг намууд нэгдсэн. Энэ хамтарсан мөрийн хөтөлбөр гараад үндсэндээ 100 дахь хоногууд нь үргэлжилж байх шиг байна.

Тэгэхээр эндээс энэ хамтарсан Засгийн газрын оруулж ирж байгаа анхны төсөв, 25 оны төсвийг бид бүгд хэлэлцэж байна л даа. Энэ төсөв дээр үндсэндээ ингээд харахад асар их тэлэлттэй. 20 гаруй их наядын байсан зарлагатай төсөв 35 их наядын зарлагатай ийм төсөв орж ирээд бид бүгд хэлэлцэж байна. Уг нь энэ намуудын мөрийн хөтөлбөр дээр тус бүрдээ төсвийн зарлагыг дотоодын нийт бүтээгдэхүүнүүдийн 40 шахчихсан байгаа харьцааг 25 руу оруулна гэж МАН-ын мөрийн хөтөлбөр дээр цагаанаар хараар, АН-ын мөрийн хөтөлбөр тэр яг л энэ утгаараа л байгаа. Яг л энэ утгаараа л байгаа. Зүй нь бид нар яг энэ амлалтынхаа дагуу явсан бол явсан бол төрийн оролцоо асар багасах ёстой болно. Төсвийн зардал асар багасах ёстой болно. Үүнийг дагаад татвар багасах ёстой болно. Үүнийг дагаад төрийн албанд бид нар иж бүрэн шинэчлэлийн бодлого оруулж ирэх ёстой байсан. Нөгөө зардал багасаж байгаа учраас, зарцуулалт багасаж байгаа учраас

төрийн албанд асар том шинэчлэл үүний цаана хийгдэх ёстой, төсвийн зардлын асар том шинэчлэл энэ удаагийн төсөв дээр уг нь ард түмэнд амласан амлалтын дагуу ийм л төсөв бид нар уг нь орж ирж өнөөдөр хэлэлцэж байх ёстой. Гэтэл эсрэгээрээ. Гэтэл эсрэгээрээ асар их тэлэлттэй ийм төсвийг өнөөдөр бид нар ингээд энд хэлэлцэж байна.

Ер нь бол татвар их байна гэдэг чинь төрийн зохицуулалт л их байна. Ард иргэдийн, нийгмийн эдийн засгийн бүхий л асуудлуудыг бид нар зохицуулна л гэсэн нэг ийм л утга санааны хүрээнд энэ төсөв орж ирж байна л гэж ойлгож байгаа.

Тэгэхээр би Сангийн сайдаас зүгээр яг тэр мөрийн хөтөлбөртэй холбоотой зүйлийг л асуух гээд байна л даа. Мөрийн хөтөлбөр дээр 24-28 онд төсвийн зарлагыг засагт хамтарсан намууд 25 хувь болгоно гэсэн яг ийм заалтууд байгаа шүү. Энэ дараа дараагийн төсвүүд дээр яаж төсөвлөлттэй байгаа юм. Жишээ нь 26 онд хэд болох юм, 27 онд хэд болох юм, 28 онд хэд болох, ямар төсөөлөл байгаа юм. Үүний цаана чинь бид бүгдийн нөгөө нэг ард иргэдэд амладаг улс төрийн амлалтуудаа бид нар ингэж орхиод, эрх бариад орхиод, нэгдэж нийлчихсэн учраас юу ч хамаагүй гээд ингээд бид нар цааш бас явж болохгүй шүү дээ. Тэгэхээр үүний цаана ямар бодлого чиглэл, төсөл төлөвлөгөө, тооцоо тэр 25 гэдэг тоотой холбож та тайлбарлаж өгөөч ээ? Энэ өөрөө бас тийм жижиг биш үүний цаана зөвхөн энэ тооны цаана асар олон тэр үр ашиггүй хөрөнгө оруулалт, оновчлолгүй халамжийн бодлогууд, олон олон зүйлүүд үүний цаана агуулагдаж байгаа байх л гэж бодож байна.

Тэгэхээр тэр асуултад та нэг хариулт өгөөч.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Гишүүний үндсэн суурь үзэл баримтлалтай санал нийлж байна. Ер нь төсөв дотоодын нийт бүтээгдэхүүний харьцааг бид богино хугацаанд өөрчлөх боломж маш хязгаарлагдмал. Шат дараатай хийхээс өөр арга байхгүй. Гол яг том агуулгаараа өөрөөр хэлбэл хувийн сектор, баялаг бүтээгч, гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нарыг дэмжих л ийм л бидэнд зам байгаа, өөр сонголт байхгүй. Тэгж байж, дотоодын нийт бүтээгдэхүүн дэх хувийн секторын төр, хувийн хэвшлийн түншлэлийн үр өгөөж, бүтээмжийг нь дээшлүүлэх юм байгаа юм. Тэгэхийн тулд төр юуг нь хариуцаж яаж туслах вэ гэвэл ерөөсөө л дэд бүтэц, зам тээвэр, эрчим хүч.

Тийм учраас саяхан сар гаруйн өмнө баталсан ирэх 4 жилийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн ерөөсөө гол суурь нь ерөөсөө л энэ байгаа. Ерөөсөө л хувийн хэвшлийг дэмжих, татварын бодлогоор дэмжих, дэд бүтцээр нь дэмжих. Тийм учраас 25 оны төсөв маань ерөөсөө 100 хувь энэ рүү чиглэж байгаа юм. Эхлүүлсэн төсөл, хөтөлбөрүүдээ бушуухан дуусгая. Шинээр эхлүүлэх боломж, орон зайн дээрээ дэд бүтэц дээрээ онцгой анхааръя. Ялангуяа эрчим хүч, зам тээвэр дээрээ.

Эрчим хүч, зам тээврийн үзүүр дээр төрийн үйлдвэр баригдахгүй, төрийн байшин баригдахгүй. Тэнд хувийн хэвшлийнхэн, үйлдвэр, худалдаа, аялал жуулчлал, боомт энэ бүх боломжуудаа л тэдэнд зориулж байгаа гэсэн үг. Тийм учраас дотоодын нийт бүтээгдэхүүн дэх хувийн сектор хөрөнгө оруулагч нарын орон зайг баялаг бүтээх, өгөөжийг нь дээшлүүлэх энэ чиглэл рүүгээ л бид нар явж байгаа. Ийм л төсөв байгаа юм. Тийм учраас таны тавьж байгаа шаардлага бас зорилт, энэ бүх юм төсөвтөө нийцэж байгаа гэж хэлж болно.

Мөн 25 оны төсөв дээр бид нар бүр тусгай шаардлага дотроо төсөв доторх урсгал зардлыг 30 хувиас хэтрүүлж болохгүй шүү гэдгийг бүр хуулийн заалт оруулсан. Одоогоор 25 оны урсгал зардал 27 хувьтай байгаа. Нийт зардал биш шүү. Нийт зардал дотор урсгал зардал нь ямар ч байсан 27. Ингээд төлөвлөж байгаагаар цаашаа энэ төсвийн үр өгөөжүүд энэ төлөвлөснөөр явбал мэдээж хувийн сектор дээр дэд бүтцээр дамжаад тэдний үр өгөөж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх дотоодын нийт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх тэр боломжууд нь илүү нэмэгдээд явна. 4 жилийн эцэст ямар ч байсан зорьсон зорилгодоо хүрнэ. 30-аас доош, 25-аас доош шат дараатай очих зорилго руугаа явцгаана гэж хариульъя.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Өнөөдөр төсвийн зарлага дотоодын нийт бүтээгдэхүүнд 37, 38 хувь түүхэн дээд хэмжээндээ л байгаа. Үүнийг дагаад татварын ачааллын тухай ярьдаг. Зарим хүмүүс манайх хувь процентоороо татвар өндөртэй улс биш шүү дээ гэж зарим улс төрчид, судлаачид ч бас хэлдэг. Би бол үүнтэй санал нийлдэггүй. Бид нар хувь процентын тогтоосон татвараас гадна газар зүйн их өндөр татвартай улс. Монголын бизнес эрхлэгчид. Газар зүйн асар өндөр татвартай. Бид нарын байршил далай тэнгисээс хол тээвэр ложистикийн энэ асар хүндрэлтэй нөхцөлд буюу өрсөлдөх чадварт энэ чинь энэ манай газар зүйн татвар маань өөрөө асар өндөр ийм нөлөө үзүүлдэг ийм улс орон. Тэгээд яг тэр Засгийн газрын мөрийн хөтөлбөрт дахиад дээрээс нь хамтарсан Засгийн газарт орсон намуудын мөрийн хөтөлбөрт тус бүрд нь суусан тэр асар чухал амлалт яагаад эсрэгээрээ яваад байгаа вэ гэдэг дээр бас цаашид бас би байнга нэхэж ярих болно гэдгийг л төгсгөлд нь хэлье ээ.

Д.Амарбаясгалан: Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууя.

Б.Түвшин: Өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад баялгийн сантай нэг 2 асуудлыг хэлье гэж бодож байна. Баялгийн сан дээр байж байгаа 6 орчим их наяд төгрөг бол өнөөдөр Төрийн сан дээр буюу Монголбанк дээр ямар ч өгөөжгүйгээр байж байгаа гэж ингэж ойлгож байгаа. 50 орчим тэрбум төгрөгийн өгөөж орж ирсэн. Одоо энэ удаагийн төсөв дээр бас зарим хуульд өөрчлөлт оруулж байж, түүнийг бүртгэх тухай асуудал ярих юм байна гэж ингэж ойлгогдсон. Цаашдаа Сангийн яам өөрөө үүнийг гадаадад ч байдаг юм уу, валютаар байршуулж байж жинхэнэ эрсдэлийн сан болгохгүй бол Монголдоо дотооддоо ингээд байж байгаа нь өөрөө эргээд энэ сангийнхаа утга учрыг алдагдуулаад, тэр тусмаа үндэснийхээ валютаар байж байгаа нь үүнийг эрсдэлд оруулж байна гэж үзэж байна. Энэ дээр тэгээд яаж байршуулах талаар Сангийн сайдыг нэг тодорхой хариулт өгөөч гэж хүсэх байна.

2 дугаарт, НДШ. Нийгмийн даатгалын санг 4,5 их наядын алдагдалтай гэж яриад байгаа боловч яг үүнийг чинь цааш нь задлаад үзэхээр төрөөс нийгмийн даатгалыг нь даах, тэгээд тэр хүмүүсийн төлбөр, түүний тэтгэвэртээ гарсных нь дараа олгож байгаа зардлуудыг нь хасаж тооцохгүйгээр үүнийг тэгж тооцох боломжгүй байгаад байгаа юм. Нийгмийн даатгал бол өнөөдөр Монголын бизнес эрхлэгчдийн хамгийн том ачаалал болчихсон.

Тийм учраас яг энэ нийгмийн даатгалын сангаас төрөөс даах хүмүүст ноогдох тэтгэврийн хэмжээ нь хэд байна вэ. Хэдэн төрлийн ямар ажлын, мэргэжлийн хүмүүсийн тэтгэвэр, тэтгэмж яг энд орж яваад байна вэ. Энэ нь нийгмийн даатгалын сангийн зарлагынхаа хэдэн хувь, тэр алдагдлынх нь хэдэн хувь болж байна вэ гэдгийг бодож байж нийгмийн даатгалын санг бие даалгах, эс үгүй бол нийгмийн

даатгалын шимтгэлийн ачааллыг бууруулах тухай энэ судалгааг хийх хэрэгтэй байна. Ер нь яах вэ, өчигдөр Сангийн яамныхантай ярьж байхад тэр нийгмийн даатгалын санг бие даалгах тухай ярьж байсан. Энэ судалгаа шинжилгээнүүдээ хийж байгаад төрөөс даах зардлуудыг нь төрийн төсөв дээр нь тусад нь салгаж тавьж байж, энэ цаашдаа нийгмийн даатгалын санг салгах тухай бодлогыг бид нар бодох шаардлагатай байна гэдгийг бас хэлье. Энэ талаар Сангийн яамны үзэл баримтлалыг асууя.

3 дугаарт, Эрүүл мэндийн даатгалын сан бас ялгаа байхгүй. Бас л 2,5-тай, 1,2 их наядыг нь төрөөс санхүүжүүлж байгаа гэж байгаа. Энд төрийн үндсэн чиг үүрэг болох анхан шатны тусламж дэмжлэгийн буюу тэр гүйцэтгэлийн үнэлгээний цалингийн зардлууд бас орсон байгаа. Тэгэхээр яг энд Эрүүл мэндийн даатгалын сан сангаас яг тогтвортой цалингийн сангийн зардлууд хэд зарцуулагдаад байна вэ? Төрөөс даах ёстой үндсэн үйлчилгээнүүд энд хэдэн хувь байна вэ гэдгийг яг тодорхой тоогоор гаргаж ир. Цаашдаа Эрүүл мэндийн даатгалын сан санг ер нь бие даалгах ямархуу бодлого үзэл баримтлал барьж байна вэ?

3 дугаарт, өнөөдөр урсгал зардлын тухай ярьж эхэлж байна. Урсгал зардлыг хасна гэдэг бол үнэндээ маш том асуудал. Энэ бол тийм нэг дор нь хасчхаж бас болохооргүй асуудал байна. Гэхдээ хамгийн энгийн алхмуудыг хиймээр байгаа юм. Өнөөдөр манай Монгол Улс хаа сайгүй барилга барих хүсэлт тавьж байна. Сум болгон хүүхдийн ордон, ахмадын ордон, пионерын ордон, өөр юуны ч байдаг юм. Тэгээд удахгүй эргээд энэ байшингуудынхаа харуул хамгаалалт, арчилгаа цэвэрлэгээ, их засвар гээд явж байна. Ерөөсөө энэ төрийн том данхайсан бүтцийг шийдэхийн тулд 1 дүгээрт, хүний орон тооноос гадна энэ байшин савны асуудлыг зүгээр сандал, ширээгээр нь шийдчихмээр байгаад байгаа юм. Бүх газрууд, яам, Тамгын газрууд нь дээрээ тус тусдаа байж болно. Яг орон нутгууд руу ялангуяа татаас авдаг аймаг, сумууд руу үүнийг бол хүн болгоныг нь тодорхой нэг цөөхөн хэсэг байшингуудад суулгахгүй бол энэ төрийн хийж байгаа данхайсан байшин савтай холбоотой ашиглалт, харуул хамгаалалт, үйлчлэгч, цахилгаан, дулааны зардлууд данхайгаад байна.

Ийм учраас энэ дээр нэг тод тодорхой бодлого гаргаж ирээд энэ зардлуудыг 20-30 хувь хэмнэх боломжтой байна гэж үзэж байна. Энэ дээр Сангийн яамнаас ирээдүйд ямар бодлого явуулах гэж байна? Ер нь энэ байшин, сав, ашиглалттай холбоотой зардлуудыг шийдэх хэрэгтэй байгаад байгаа юм. Өнөөдөр тэр бас яриад байгаа шүү дээ, мэд ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Түвшин гишүүнд 1 минут нэмж өгье.

Б.Түвшин: Өнөөдөр мэдээлэл өгөх төв гээд 10, 20 их наядын төвүүдийг сум дээр барьж эхлээд байдаг. Гэтэл сумын Соёлын төвийн ашиглалт дотор чинь тэр ахмад, хүүхэд, залуучууддаа ашигласан зарцуулсан цаг байхгүй, ашиглалт багатай байж байдаг.

Дээрээс нь зарим аймгууд сургууль, цэцэрлэг ч үгүй гэр галлагаатай байж байхад зарим сумуудад Мэдээлэл өгөх төв гээд ингээд шинэ байшингууд барьж байдаг. Тэгээд үүнийг ямар бодлогоор, яаж цэгцтэй болгож оруулж ирэх вэ? Ер нь энэ урсгал зардал жилээс жилд өсөж байна. Өнөөдөр нийт төсвийн орлогын 77 орчим хувийг урсгал зардал руу гаргаж байна. 20-30 гаруй төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Төсөл хөтөлбөрүүдийн зардал нь давхцаж байна.

Дээрээс нь энэ төсөл, хөтөлбөрүүдийн үр өгөөжийг тодорхой хугацаагаар давтамжтайгаар гаргаж харуулахгүй, олон жил үргэлжилж байгаа төсөл хөтөлбөрүүд маш олон байна. Яг энэ тал дээр Сангийн сайд болон Сангийн яамныхан нэг тодорхой бодлого шийдвэртэй хариу өгөөч гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя. Энэ микрофон чангалахгүй бас танхимд сул сонсогдоод байна гээд гомдол ирж байна. Техникийн албаныхан энэ дээр анхааръя. Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Түвшин гишүүний асуултад хариулъя. Баялгийн сан маань ер нь цаашид улам арвижна. Хоёрхон жилийн дотор гэхэд бас чамгүй хуримтлал бий болчихлоо.

Тийм учраас энэ Баялгийн сангийн энэ хуримтлалыг цаашид найдвартай, хөрвөх чадвартай бас ингээд өсөж байдаг, баяжиж байдаг хэлбэрээр хадгалах нь хамгийн чухал. Тэгэхдээ бидэнд бас гашуун түүх байгаа. Олон сангуудаа энэ өгөөжтэй байлга гэж айлгаж туусаар байгаад, хамгийн өндөр өгөөж амласан банканд аваачиж хадгалаад, тэгээд түүндээ хууртагдаад алддаг, маш олон түүхтэй. Тийм учраас олон улсын стандарт нэг барьдаг ийм юу байдаг, ер нь. Юу вэ гэхээр ийм төрийн сангийн чөлөөт үлдэгдлүүдийг 1 дүгээрт, найдвартай байлгах ёстой. 2 дугаарт, хөрвөх чадвартай байх ёстой. Энэ 2 нөхцөл бүрдсэний дараа өгөөж ашиг хайж болно гэдэг ийм стандарт руугаа бид шилжсэн. Өөрөөр хэлбэл 1 дүгээрт, өгөөж биш шүү, найдвартай байж байх ёстой. Энэ зарчмаараа Баялгийн сангийн сангууд маань одоогоор төв банк дээрээ байгаа бүгд, 1-д.

2-т, тэр валютаар хадгална гэдэг чинь бас 2 талтай шүү. Бид үндэсний мөнгөн тэмдэгтдээ итгэхгүй, валют руу ингээд шилжээд байх юм бол нийгэм тэр чигээрээ, баялаг бүтээгч нар бүгд тэр чигээрээ яг үүнийг л дагаад явчихна. Ийм хөрвүүлэлтийг бид дийлэхгүй.

Тийм учраас эдийн засгаа өөрөө тогтвортой байлгах, үндэсний мөнгөн тэмдэгтээ худалдах худалдан авах чадварыг нь нэмэгдүүлэх, найдвартай байлгах энэ чиглэл рүүгээ л бодлого явах ёстой. Валют руу байршуул, доллар ав гэж битгий шахаарай.

Нийгмийн даатгалын сангийн хувьд бид 34 жилийн хугацаанд ер нь их буруу явж ирсэн, буруу явж ирсэн. Сонгуулиас сонгуульд энэ олон попорсон ийм амлалт, энэ бүгдийн эцэст Нийгмийн даатгалын сан маань төрөөс гаргасан шийдвэрийн дагуу маш их төрөөс даадаг ийм зардал ихтэй болсон. Үүнээсээ болж бид нар алдагдал гэж яриад байгаа юм. Одоо алдагдал бол тийм үйл ажиллагааны алдагдал биш юм байгаа юм шүү дээ, энэ. Төрөөс гаргасан олон шийдвэрүүд, хөнгөлөлтүүдийнхээ үр дүнд л ийм алдагдал хуримтлагдчихаад байгаа юм.

Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилье гэвэл ерөөсөө энэ өмнө нь гаргасан энэ шийдвэрүүдээсээ л одоо зогсоох хэрэгтэй байгаа юм. Зогсоох хэрэгтэй. Төрөөс даадаг, эрт тэтгэвэрт гаргадаг, нөгөө 7 жил энэ байсныг нь 5 жил болгочихсон энэ бүх шийдвэрүүдээ л өөрчлөх хэрэгтэй. Тэгэх юм бол бас богино хугацаанд 20, 30 жилийн дараа бид хуримтлал руу шилжих энэ нийгмийн даатгалын тогтолцоог хугацааг нэг жоохон наашлуулах ийм боломжууд гарч ирнэ. Ийм тогтолцоотой байгаа.

Тэгээд төрөөс даадаг НДШ-үүдийн төрлүүд, дүн хэмжээг манайхан нэмээд хэлээдхээрэй.

Эрүүл мэндийн даатгалын сан бол энэ Нийгмийн даатгалын сангаасаа арай өөр шүү. Нийгмийн даатгалын сан маань ингээд хуримтлагдаад явж байдаг. Эрүүл мэндийн даатгалын сан бол тухайн жилдээ тэг үлдэгдэлтэй гарах ёстой, бүгдийг нь зарцуулаад дуусгах ёстой, ийм сан байгаа юм. Одоогоор шимтгэлээр бүрдэж байгаа төрөөс ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Тийм, төрөөс дааж байгаа ер нь бол ер нь их ойролцоо нэг 50, 50 хувьтай байна. Ирэх жил 2,5 их наяд байгаа. 1,3 нь төрөөс, 1,2 нь шимтгэлээр ийм байгаа. Энэ ЭМД-ын сангийн талаар зарцуулалт, зорилго, цаашдын энэ бодлого энэ юмны талаар сайд илүү дэлгэрэнгүй хариулах болов уу гэж бодож байна.

Урсгал зардалтай тантай санал нийлж байна. Урсгал зардлыг хасна гэдэг боломж маш хязгаарлагдмал, нэмэхгүй байх хэрэгтэй. Урсгал зардлаар бий болгож байгаа дотоодын нийт бүтээгдэхүүний өгөөж, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг дэмжих тэр коэффициентийг л бид нар илүү болгох ёстой. Тэгж байж бид нар тэр харьцаагаа багасгах ийм чиглэл рүүгээ л бодлого маань явна.

Дээрээс нь та тэр нөгөө юу ярилаа. Нийтлэг үйлчилгээний зардлуудыг. Нийтлэг үйлчилгээний зардлыг заавал тангараг өргөсөн төрийн албан хаагч хийгээд байх шаардлагагүй ээ. Энд бид нар шилжилт хийх ёстой. Хувийн хэвшлээс үйлчилгээ худалдаж худалдаж авах замаар энэ зардлыг бууруулах, энэ төрийн албан хаагч нарын тоог бас өсгөхгүй, нэмэхгүй байх энэ бодлогын шилжилтүүдийг хийж байгаа. Өмнөх 4 жил бас үүнийг бид нар туршиж байсан. Бас нэг тийм амжилттай үр дүнтэй болоогүй. Цаашдаа үүнийг ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тодруулга авчихсан даа, минутаа авчихсан. Түвшин гишүүн тодруулга 1 минутаа уг нь авчихсан. 1 минут тодруулга өгье.

Б.Түвшин: Баярлалаа. Тэгэхээр Жавхлан сайд аа, энэ Баялгийн сан валютаар байна гэдэг нь дан аль нөгөө улсын валютын тухай хэлж байгаа биш. Энэ бол манай Монгол Улсад инфляцын эрсдэл болоход эндээс хамгаалах, инфляцаас эрсдэлээс хамгаалсан тархайн байршуулах тухай ярьж байгаа. Тэгэхээр энэ эрсдэлийн менежментийн тухай ярьж байна гэдгийг та бас ойлгож байгаа байх.

Нөгөө талаараа өгөөжтэй байх ёстой гэдэг нь дотоодын аль нэгэн чанар муутай банканд байршуулаад явчихсан тэр өвдөлт байгаа л байх. Гэхдээ үүнийг чинь гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар байршуулдаг мэргэжлийн байгууллагуудаар байршуулахгүй бол дотооддоо энэ их хэмжээний төгрөг нь байж байгаа нь бол эрсдэлтэй юм гэдэг талаас нь ярьж байгаа. Та өөрөө сайн банкир учраас энэ талаар сайн ойлгож байгаа байх.

Тэр нийгмийн даатгалын асуудлыг тусдаа гаргая гэдэг дээр санал нийлж байгаад их баяртай байна. Харин төрөөс даадаг зардлуудыг нь тусад нь салгаж байж, үүнийг бие даалгаж, иргэд, бизнесменүүд дээр очиж байгаа ачааллыг нь буулгахгүй, зөв ярьдаг, зөв тогтолцоо руу хэдүүлээ тэгвэл хамтраад шилжье.

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууна.

О.Номинчимэг: Бүгдэд энэ өглөөний мэндийг хүргэе. Нэг 3 асуулт байна. Төсөв дагасан хуультай холбоотойгоор.

1 дүгээр асуулт. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль. Тэгээд өчигдөр яах вэ, бас Төсвийн байнгын хороон дээр яригдаад дэмжигдээгүй юм байна. Гэхдээ ер нь бид бүсчилсэн хөгжлөө дэмжихийн тулд зарчмын хувьд дэмжиж байгаа боловч энэ хуулийг боловсруулж орж ирж байгаа Засгийн газар, Сангийн яам бас энэ танилцуулга, хуулийн нарийвчилсан зохицуулалт хоёроо ижил түвшинд тийм ээ, энэ утга санаа нь туссан түвшинд яг зорилтот хүрээндээ байгаа эсэхэд бас жоохон хянуур хандах хэрэгтэй юм уу гэж бодож байна. Энэ Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд ер нь Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлээд боловсруулах үйлдвэрийг дэмжих, нөгөө томоохон төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтуудаа дэмжих зорилгоор гаалиас 100 хувь чөлөөлж байгаа.

Тэгээд энэ хуулийнхаа төслийн хамгийн танилцуулгын сүүлд бол дотоод үйлдвэрлэлээс хангах боломжгүй, импортоор оруулах барилгын материал, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлөхөөр тусгалаа гэсэн байгаа. Тэгээд энэ хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийг харахаар ерөөсөө л 38.4 дээр боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэх тоног төхөөрөмжийн бүрдлийн импортын бараа гэж байгаа юм. Чөлөөлөгдөх маань. Тэгээд яг энэ дээр боловсруулах үйлдвэр гэхээр яг бүсчилсэн хөгжлийн хүрээндээ энийгээ нарийвчилж болоогүй юм уу. Бүсчилсэн хөгжилдөө яг хаанаас хаана баригдаж байгаа гэдгээр нь энэ юмаа нарийвчилж, энэ татварынхаа юугаа чиглүүлэхгүй бол гаалийн татвар дээр хийдэл гарах вий дээ гэсэн ерөнхий байдлаар тусгачихаар ийм болгоомжлол байгаа юм.

Тэгэхээр үүнийг яг боловсруулах үйлдвэрээ та бүхэн яаж, ямар түвшний гэж харж байгаа юм? Эцсийн бүтээгдэхүүн гарна гэж байгаа юм уу? Дундын бүтээгдэхүүн гарах, дундын бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр ч гэсэн үүнд хамаарах юм уу?

2 дугаарт, энэ танилцуулга дээрээ бичсэн барилгын материал ч гэсэн гаалийн татвараас 100 хувь чөлөөлөгдөх гээд байна уу, эсвэл хууль дээрээ бичсэнээрээ зөвхөн тоног төхөөрөмж юм уу. Үүнийг нэг тодруулж өгөөч гэж хүсэж байна.

2 дугаар асуулт. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл орж ирсэн. Энэ дээр тогтоолын төслийн 2 дугаарт, 2.1 дүгээр ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийг Хөшгийн хөндийд нүүлгэх талаар ТЭЗҮ, ингээд нийгмийн асуудал, холбогдох урсгал зардлыг, хөрөнгийг шийдвэрлэж, нүүлгэн шилжүүлэх ажлыг Засгийн газарт чиглэл өгч байгаа юм.

Тэгээд энэ дээр би энэ холбогдох сайд нараас асуумаар байна. Боловсролын сайд ч гэсэн. Энэ Хөшигийн хөндий рүү энэ сургуулийг нүүлгэж байгаагийн ач холбогдол нь юу юм? Ер нь бид нар Хөшигийн хөндийг ямар концепцтой хот болно гэж бид нар төсөөлж байгаа юм. Бид нар хот барихдаа бүх юмыг л тийшээ шаваад тавьчихгүйгээр энэ маань өөрөө аялал жуулчлал, эсвэл ай тигийн чиглэлийн байх юм уу, эсвэл том конференс хийдэг юу гэдэг юм тийм ээ? Дайраад гардаг ийм концепцтой хот байх юм уу? Энэтэйгээ энэ тогтоол дээр орж байгаад Механик тээврийн сургуулийг ийшээ нүүлгэх ажил хэр уялдаж байгаа юм бэ? Хөшигийн

хөндийн бас хот байгуулах ажлын хэсэг энэ дээр концепц гаргаад бас явж байгаа байх. Түүнийг тодруулмаар байна.

3 дугаарт, Засгийн газрын энэ чиглэл өгөх тухай төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал менежментийг сайжруулах талаар нэлээн хэдэн бас заалтууд орсон байна. Үүнийг үндсэндээ дэмжиж байна. Бидний хувьд энэ төрийн өмчийг бизнесийн оролцооноос, зах зээлээс хязгаарлах төрийн өмчийн оролцоог, Төрийн өмчит компанийн оролцоог, хувийн хэвшилдээ орон зайг нь нээж өгөх, чөлөөт эдийн засгийг илүү сайжруулах, дэмжих гэсэн энэ асуудал маш тулгамдаж байгаа. Тэгэхээр яах вэ, энэ нөгөө тогтоол Засгийн газарт чиглэл өгч байгаа чухал чухал асуудлууд байна. Ялангуяа үр дүнгээ тайлагнах энэ төрийн өмчит компаниудыг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах тийм ээ, мөн төрийн өмчит хуулийн этгээдийг хувьцааг биржээр зарах, хувьчлал хийх энэ хурал юу асуудлуудыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр байгаа юм.

Тэгэхээр гол нь асуудал энэ зөв ажил боловч та бүхэн хугацааг нь хэлээд өгөөч. Хэдий хүртэл та бүхэн маань үүнийг хийнэ гэж төлөвлөж байгаа юм? Бид нар 4 жилийг мэдээж яахгүй. Үүнийг ойрын хугацаанд нэн яаралтай хийх гэж байгаа учраас Засгийн газрын ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя. Дараа нь Боловсролын сайд Наранбаяр.

Б.Жавхлан: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Юуны өмнө гишүүдээс уучлалт хүсье гэж. Ер нь ингээд сүүлийн 2, 3 хоног өдөрт 4-5 Байнгын хороо дамжаад явж байгаа учраас нөгөө дараагийн Байнгын хороон дээрээсээ бас жоохон хоцроод, мэдээллээ дутуу өгөх ийм асуудлууд гараад байгаа учраас уучлалт хүсэж байна.

Тийм учраас өчигдөр Төсвийн байнгын хороон дээр бас нэг ийм явдал боллоо. Тэгэхээр энэ удаагийн төсөв дагасан 2 татварын шинэчлэл байгаа. Нэг нь ААНОАТ, нөгөөдөх нь гаалийн албан татвар. 2 өөр хууль байгаа шүү.

ААНОАТ нь яг газар зүйн байрлалын хувьд бүсчилсэн хөгжлийнхөө суурь үзэл баримтлал дээр суурилсан, бүс бүсээр ялгаатай татварын бодлого, тэргүүлэх чиглэл энэ бүх юман дээрээ суурилоод, мөн бүс бүрээр бие биеийгээ кластерлаж дэмжиж хөгжих. Үүнийг дэмжсэн ялгаатай бодлогын суурийг энд оруулж ирсэн байгаа.

Гаалийн татвар үүнээсээ өөр шүү. Газар зүйн байрлалын хувьд бүсчилж хязгаарлагдахгүй, улс орон даяар энэ гаалийн татвар үйлчлэх юм байгаа юм. Өөрөөр хэлбэл, бид халамжаас хөдөлмөр лүү, импортлогчоос экспортлогч руу, түүхий эдээс эцсийн бүтээгдэхүүн рүү гэж 30 жил ярьж байгаа юм. Одоо баялаг бүтээгч, үйлдвэрлэгч нар Худалдаа аж үйлдвэрийн танхимд 30 жил энэ татварын зохицуулалтыг хүлээж байгаа.

Тэгэхээр боловсруулах шатны, эсвэл боловсруулах шатыг ахиулах технологийн тоног төхөөрөмжийн гаалийн албан татварыг салбар харгалзахгүйгээр газар зүйн байрлал харгалзахгүйгээр, том, жижиг үйлдвэрлэл харгалзахгүйгээр үүнийг бүрэн чөлөөлж байгаа, бүрэн чөлөөлж байгаа. Энэ боловсруулах шатанд хувьсгал хийх, томоохон шинэчлэл авчрах ийм зохицуулалт орж ирж байгаа юм.

Тийм учраас энэ талаас нь гишүүд маань дэмжээд өгөөрэй.

Үндсэн хөрөнгө гэж үг орсон байгаа. Тэр нь энэ нөгөө нэг яг нөгөө хийдлээ арилгах ийм гаалийн зохицуулалт юм байгаа юм. Эрсдэлээ хаасан. Өөрөөр хэлбэл худалдааны зориулалтаар орж ирэх ч юм уу, эсвэл реэкспортоор зориулж оруулж ирэх ийм тоног төхөөрөмж, ийм хөрөнгүүдийг гаалиас чөлөөлөхгүй. Яг орж ирээд үйлдвэр дээрээ суурилагдаад, бүтээгдэхүүн гаргахад оролцож байгаа тэр хөрөнгүүд үндсэн хөрөнгүүдэд бүртгэгдээд яг технологийн нэг хэсэг болох ёстой. Түүний дараа үүнийгээ чөлөөлдөг ийм Си дигийн зарчмаар явж байгаа ийм зохицуулалт юм байгаа юм шүү.

Барилгын материал энд хамаарахгүй. Өөр зохицуулалтаар явна. Бусад нь өөр сайдуудаас асуулаа, тийм ээ.

Номинчимэг гишүүнд баярлалаа. Ер нь ялгаатай 2 гол асуудал маань яг ийм л юм байгаа юм.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Цэдэнпилийн Даваасүрэн гишүүн нэмж хариулъя.

Ц.Даваасүрэн: Энэ татварын зүйл дээр би дахиад та бүгдэд тодруулж хэлэхэд энэ чинь ингэж байгаа юм. ААНОАТ-ын хувьд бүсчилсэн байдлаар импортыг орлох, экспортыг дэмжих үйлдвэрлэлийг л чөлөөлье гэж байгаа шүү дээ. Энэ зөв шүү дээ. Бид нар зөв, тэгж байж валютын нөөцөө хамгаална.

Тэгэхдээ харин би гишүүдийн хэлж байгаа дээр нэг саналтай, нэг байна. Яг аль салбар юм гэдгийг нь зааж өгье. Оёдлын гэх юм уу, хөдөө аж ахуйн гэх юм уу, барилгын материалын үйлдвэр гэх юм уу. Үүнийг нь харин зүгээр тодотгож өгөх хэрэгтэй байх. Гааль дээр ч гэлээ гэсэн, боловсруулах дээр ч гэсэн ямар чиглэлийн үйлдвэр байх юм гэдгийг нь тодотгож өгье гэж байгаатай би санал нэг байна.

Тийм учраас хэдүүлээ хэлэлцэхээ дэмжээд, харин эхлээд аль салбараа дэмжих юм, аль салбарынхаа тэр экспортыг дэмжих татварыг нь чөлөөлөх юм, аль бүтээгдэхүүн импортыг орлох бүтээгдэхүүнийг дэмжих юм гэдэг юмнуудаа Их Хурал шийдэж өгье. Энэ зөв байх. Тэгж тодотгож л өгье. Түүнээс биш энэ экспортыг дэмжье, импортыг орлох бүтээгдэхүүн дэмжье гэж байхад ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Даваасүрэн гишүүн гүйцээж хариулъя.

Ц.Даваасүрэн: Тийм учраас бид нар валютын нөөцөө тогтвортой байлгах юм бол импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж байвал тэр бизнес эрхлэгчийг дэмжих ёстой. Экспорт шинэ бүтээгдэхүүн гаргаж байгаа бизнес эрхлэгч байх юм бол түүнийг дэмжих ёстой. Тэгж байж бид нар эдийн засгийнхаа хөгжлийг өөд нь татна, валютын нөөцөө тогтвортой байлгана. Тийм учраас энэ татвар зарчмын хувьд зөв үү, зөв. Зүгээр бид нар харин тодотгож өгье гэж байгаа дээр саналгүй байна. Тэгэхээр тэр жагсаалтыг нь Их Хурал өөрсдөө ингээд батлаад өгдгөөр тогтоод явчихъя.

Боловсруулах үйлдвэр дээр ч гэлээ гэсэн бид нар ер нь түүхий эд гаргаж байхынхаа оронд бид нар боловсруулж гаргаж байж л энэ чинь нэмүү өртөг шингээж байж бид нар ашигтай болно шүү дээ. Тэгэхгүй боловсруулах үйлдвэрийг нь дэмжье гээд тэгэхээр нь өө дэмжихгүй гээд Их Хурал нь сууж байж болохгүй. Тийм учраас

хэдүүлээ тэр энэ унагасан байгаа энэ 2 татварын асуудлыг анхааралтай хандахгүй бол энэ дээр харин нэг жоохон нэг тийм буруу ойлголт явчав уу. Би бүр гайхаад байгаа юм. Боловсруулах үйлдвэрийг бид нар үйлдвэрийг дэмжих ёстой шүү дээ. Халамжийг биш. Үйлдвэрлэл ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Пүрэвсүрэнгийн Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Энэ Хөшигтийн хөндийд, Хөшигийн хөндийд их сургуулийн хотхон байгуулах ийм төлөвлөлттэй явж байгаа. Тэнд 500 га газар Боловсролын яамны нэр дээр аваад, түүн дээр олон улсын инженерийн сургуулийн төлөвлөлт явж байгаа. БНХАУ-тай хамтарсан ӨМӨЗО. Түүний зэрэгцээ энэ авто механикийн инженерийн сургуулийг нь ШУТИС-ийн харьяанд байдаг энэ сургуулийг шилжүүлэх, тэнд нь шинээр төлөвлөлт хийх, ТЭЗҮ-г нь боловсруулах 800 сая төгрөгийн төсөв суусан байгаа. Тэнд нэг тийм хотхон хэлбэрээр, кампус хэлбэрээр ийм инженерийн сургуулиуд, байгалийн ухааны чиглэлийн сургуулиудыг төвлөрүүлэх ийм төлөвлөлттэй байгаа. Хөшигтийн хөндийн захиргаатай нэг ярилцаад явж байгаа. Дундын менежментийн бас төв гэж бий. Энэ их, дээд сургуулиудын ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууя.

Б.Энхбаяр: 2025 оны төсвийг дагуулж орж ирсэн ААНОАТ-ын тухай хууль, Гаалийн албан татварын тухай хуулиуд өчигдөр Төсвийн байнгын хороон дээр хэлэлцэх шаардлагагүй гэж дэмжигдсэн байдаг. Энэ саналыг гаргасан хүн нь би байдаг юм. Яагаад ийм санал гаргасан гэхээр энэ ковидын нөхцөл байдалд энэ Улсын Их Хурал өнгөрсөн 4 жилийн хугацаанд Засгийн газарт бүх эрхээ шилжүүлсэн байдаг юм. Төрийн албаны хууль үйлчлээгүй, шалгалтгүйгээр хүн томилж болно. Төсвийн хууль хамаагүй, төсөв дотроо сайд нар дураараа зарцуулж болно. Хуулийн тодорхой үйлчлэлүүд зогсож байсан. Тэгэхээр үндсэндээ Засгийн газар давхар хууль тогтоогчийн ажлыг хийж байсан. Энэ бол онцгой нөхцөл байдал байсан. Шийдвэр гаргах, парламент хуралдаж, хэлэлцэх тэр нөхцөл байдал байхгүй.

Тэгээд 2 жил ингээд сурчихсан чинь сайд нар нь ч, агентлагууд нь ч, төрийн албан хаагчид нь ч бүр түүндээ дадчихсан. Тэр нь дотуур нь хулгай хийчихсэн. Одоо ердийн горимоор ердийн хуулийн хана хэрэмд ороод ирэнгүүт байж чадахаа болиод эхэлж байгаа юм. Тэгээд энэ нь өнгөрсөн 23, 24 онд анзаарагдаж байсан. Одоо энэ төсөв дагасан хууль дээр бас анзаарагдаад байгаа юм. Бүгд л улс орноо хөгжүүлэе гэсэн сайхан сэтгэлтэй шүү дээ. Жавхлан сайд, Даваасүрэн сайд бид 3 ярих юм бол аль нэг нь илүү их эх орондоо хайртай гэж ингээд эрэмбэлэх юм байхгүй.

Гол нь энэ сайхан сэтгэлийг ашиглаад, хуулийн хулгай хийгээд байгаа нь асуудал байгаад байгаа юм. ААНОАТ-ын хуульд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн, импортыг орлох, экспортыг орлох төсөл дээр 90 хувийн татварыг Засгийн газар жагсаалт гаргаж байгаад чөлөөлнө гээд байгаа байхгүй юу. Одоо ярьж байна шүү дээ, сая. Сангийн сайд бол энд барилгын материал орохгүй гэж амаараа хэлээд байгаа байхгүй юу. Энэ хууль дээр нь байхгүй байгаад байгаа. Даваасүрэн Байнгын хорооны дарга энэ дээр энэ нь орохгүй тэр нь орохгүй гэдгийгээ ярья гээд байгаа байхгүй юу. Одоо бид энэ байдлаар ингээд батлах юм бол ийм 2 асуудал үүсээд байгаа юм.

1 дүгээрт, Сангийн сайд хэний юуг чөлөөлөхийг Сангийн сайдын дур зоргоор хамаарч шийдэх гээд байгаа байхгүй юу. Энэ бол авлига болно.

2 дугаарт, үүнийг Засгийн газар шийднэ гэдэг нь Үндсэн хууль зөрчөөд байгаа юм. Татвар чөлөөлөх эрх чинь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх байхгүй юу. Хэнтэй ч хуваалцдаггүй бүрэн эрх байхгүй юу. Одоо энэ эрхээ ингээд Засгийн газарт өгчхөж байгаа байхгүй юу. Бүсэлсэн хөгжлийг дэмжих гэдэг ганц гоё нэртэйгээр юуг чөлөөлөх юм, ямар хугацаагаар чөлөөлөх юм, хэнийг чөлөөлөх юм, хэдэн тэрбум, их наядыг чөлөөлөх юм гэдэг бүү мэд. Харанхуй тоотой ийм зүгээр ганц заалтаар л эрх өгчхөж байгаа юм.

Гаалийн албан татвар мөн адилхан. Боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 100 хувь чөлөөлнө. Энэ юу юм. Боловсруулах үйлдвэр гэдэг. Сүүний үйлдвэр байгаа юм уу, тарганы үйлдвэр байгаа юм уу, энд нефть орох уу. Шатахуун импортлогчид орох уу Жишээлбэл. Барилгын материал орох уу. Энэ. Энд юу орохыг Сангийн сайд юм уу, 1 гаалийн байцаагч мэдэх гээд байгаа байхгүй юу. Үүнийг тайлбарлаад. Энэ чинь авлига гэсэн үг, за юу. Би чамайг 100 хувь чөлөөлөх үү, 100 хувь чөлөөлөхгүй гэдэг гаалийн 1 байцаагчаас мэдэгдэх гээд байна. Тэгэхээр энэ чинь авлига болно. Тэгээд үүний цаана хэдэн 100 тэрбум төгрөгийн юм яригдаад байгаа байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Даваасүрэн дарга хариулъя.

Ц.Даваасүрэн: Тийм учраас яах вэ, ингээд татварын хувиа хөнгөлж, чөлөөлж байгаа Их Хурлынхаа эрх нь эндээ хадгалагдаж байгаа юм. Өмнө нь нефть бүтээгдэхүүн дээр Их Хурлын эрхийг Засгийн газар шилжүүлчихсэн байхгүй юу. Тухай бүрд нь Засгийн газар дээрээ орж ирж байгаа нефть бүтээгдэхүүнийг тэглэх, тэглэхгүйгээ шийднэ гээд. Түүнийг бас хольж ойлгож болохгүй. Тэр Засгийн газарт бид нар эрхээ өгчихсөн, тийм юм болсон.

Энэ удаад харин зүгээр хувиа Их Хурал тогтоож байгаа. Гэхдээ Энхбаярын хэлээд байгаа тэр үнэн. Ямар салбарт байх юм, ямар чиглэлд бид нар тэргүүлэх ач холбогдол өгөх юм гэдгээ Их Хурал нь шийдэж өгч байж тэр тухайн салбарын экспортыг дэмжих, импортыг орлох бүтээгдэхүүнүүд нь чөлөөлөгдөх ёстой.

Тийм учраас би Их Хурлын гишүүдтэй санал нэг байгаа нь одоо ингээд энэ экспортыг дэмжье, импортыг орлоё гэж байгаа дээр бид нар татгалзаж болохгүй, шийдэж өгөх ёстой. Бизнес эрхлэхэд шийдэж өгөх ёстой. Тэгэхдээ харин тэргүүлэх чиглэлээрээ аль бүсэд жишээлбэл хангайн бүс хөдөө аж ахуй гэж байгаа бол хөдөө аж ахуйн чиглэлийн экспорт, импортыг дэмжих дотор нь яг юу байх юм. Арьс шир нь байх юм уу, сүү, сүүн бүтээгдэхүүн нь байх юм уу. Үүнийг харин Их Хурал зааж өгөх хэрэгтэй.

Тийм учраас би хэлэлцээд явъя. Тэгээд гаргахдаа аль салбараасаа эхлэх вэ, алинд нь тэргүүлэх ач холбогдол өгөх вэ гэдгээ шийдээд явах нь зөв байх гэж. Боловсруулах үйлдвэртээ ч гэсэн аль боловсруулах үйлдвэр дээр байх вэ гэдгээ бид нар тийм, валютын нөөцөө алдаад байгаа юмнууд дээрээ бид нар татварын бодлогоор зохицуулалт хийх ёстой шүү дээ, төр байгаа юм болбол. Тийм учраас үүнийг гишүүд маань нэлээн ялгаж салгаж олоод, зүгээр тэр айхтар үгнүүдээр айлгах биш, хэдүүлээ ухаалаг хандаад энэ алхам зөв үү, зөв. Тэгэхдээ тэгж ерөнхий байж болохгүй.

Тийм учраас яг аль чиглэлийн ямар салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд тэргүүлэх ач холбогдолгүйг Их Хурал өөрөө шийднэ хэлэлцүүлгийн явцад. Тэгж байж энэ хууль гарна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Энхбаяр гишүүний асуултад нэмж мэдээлэл өгье. Үндсэн хуулиар Улсын Их Хурал бодлогоо гаргаад, тодорхойлоод, Засгийн газар хэрэгжүүлээд, хариуцлагаа хүлээгээд ингээд явдаг. Энэ зарчмаар 34 жил л энэ татварын бодлого өөрөө явж ирсэн байгаа. Энэ хүрээнд байгаа гэдэгт би итгэлтэй байна.

ААНОАТ-ын хувьд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг бид нар энэ жилийн 5 сард баталсан. Засгийн газрын тогтоолоор баталчихсан байгаа.

Дээрээс нь бүсчилсэн хөгжлийн суурь баримтлалыг бид энэ 4 жилийнхээ Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг мөн Улсын Их Хурлаар баталчихсан байгаа. Аль бүс нутаг тэргүүлэх чиглэлийн салбар нь аль нь юм, яаж хоорондоо кластерлаж хөгжих юм гэдгийг Их Хурлаар аль хэдийн баталчихсан байгаа.

Цаашдаа ч мөн Засгийн газарт өгсөн чиглэлийн дагуу Засгийн газар дээр энийгээ хариуцсан бүхэл бүтэн институт, сайд, яам, Шадар сайд томилогдоод үүнийг Улсын Их Хурлын гишүүдийн мөн оролцоотойгоор бүс бүсийнхээ энэ хөгжлийнхөө схемүүдийг гаргаж ирээд, эндээ чиглэсэн салбар салбараар нь энэ ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж өгье. Нэмж хариулъя.

Б.Жавхлан: Боловсруулах чиглэлийн хувьд өмнө нь ингээд салбар салбараар нь сугалаад, хөнгөн аж үйлдвэр ч гэдэг юм уу, Жижиг, дунд үйлдвэрлэл ч гэдэг юм уу сугалаад, технологийн энэ тоног төхөөрөмжүүдийг гаалийн албан татвараас чөлөөлсөн маш олон шийдвэрүүд байгаа. Энэ удаа тэгж салбар харгалзахгүйгээр нийтэд нь тухайн аж ахуй нэгжүүдийг жижиг, том гэж харгалзахгүйгээр, харгалзахгүйгээр шүү. Түүн дотор бүх төрлийн чиглэлийн боловсруулах үйлдвэрүүд орно. Тэр нь гаалиар орж ирээд, суурилагдаад, бүтээгдэхүүн гаргаад, яг үйлдвэр болоод үндсэн хөрөнгө дээрээ бүртгэгдээд, ингээд тайлангаа өгсний дараа татвараас чөлөөлөгдөөд явдаг Оюу си ти-ийн нийтлэг олон улсын стандарт зарчмаараа явах юм.

Тийм учраас түүн дээр хийдэл гаргах, үүнийг нь хянан шалгах нь бол дараагийн процессын асуудал юм. Тийм учраас Даваасүрэн гишүүн болон бусад гишүүд ярьж байна. Энхбаяр гишүүний ч ярьж байгаа Их Хурал дээр илүү их тодруулъя. Зарим салбаруудыг нь хязгаарлах, жишээ нь юу гэдэг юм, зэр зэвсэг, тамхи хориотой бараанууд, архи тамхины үйлдвэрлэл. Энэ юмнуудыг хязгаарлах зүйлүүд ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ринчинбямбаагийн Сэддорж гишүүн асуулт асууна.

Р.Сэддорж: Төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдуулан асуух асуулт байгаа юм. Бусад худалдан авалтын мэдээллээ ил тод зарлачихдаг. Гэтэл гуравдагч этгээдтэй гэрээ байгуулагдуулахад үнэ ханш тохиролцох үед хүндрэл үүсэхгүй юү? Хамаг өмнөх байгуулсан үнийн мэдээллээ зарлачихдаг. Дараа нь үнээ арай ихэсгэх эсвэл багасгах тохирох асуудал үүсэхэд өмнө нь үнэ ийм байсан гээд нэмж ч болохгүй асуудал үүсэх юм биш биз дээ гэсэн ийм асуулт байгаа юм.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой этгээд хуулийн этгээд Шилэн дансны хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар мэдээллээ ил тод болгоно гэж төсөлд заасан байна. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцлийн мэдээллийг ил тод болгохоор тухайн компани дахиад гэрээ хэлцэл байгуулахад сөрөг нөлөө гарах магадлалтай юу? Ер нь Монгол Улсын хүн амын хувьд цөөн нь их цөөхнөөс шалтгаалаад энэ сонирхлын зөрчил гэдэг асуудлыг тодорхойлоход бэрхшээлтэй байдаг. Үнэхээр хууль баримтлаад гэрээ хийгдсэн байхад сонирхлын зөрчил орсон байна гэдэг асуудал яригдах боломжтой. Үүнийг яаж харж байгаа бол оо гэсэн ийм асуулт байна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Төсөв дагаж байгаа, төсвийн хууль дагасан хуулиуд дотор энэ ЗГХЭГ-аас төрийн өмчийн үйлдвэрийн газрууд дээр авах зарим арга хэмжээнүүдийн талаарх тогтоол байгаа. Тэр талаар холбогдож асуулаа гэж би ойлголоо шүү, уучлаарай. Түүн дотор энэ бол яг нийгмээс шаардаж байгаа Улсын Их Хурлын гишүүд, улс төрчдөөс байнга шаарддаг л ийм зүйлүүд, аль болох ил тод байлгах, олон нийтийн мэдэх эрхийг нь тавьж өгөх, олон нийтийн хяналтыг нь сайжруулах, өөрөөр хэлбэл хамгийн ардчилсан, үр дүнтэй хяналт бол олон нийтийн хяналт байдаг. Харин тийм учраас төрийн өмчийн ч бай, төсвийн байгууллагууд ч бай, бүгд энэ зардал хөрөнгө оруулалт тал дээрээ нийтэд ил тод байх ёстой. Түүнийг нь бүр ингэж хуульчилж өгье өө л гэдэг ийм асуудлууд байгаа.

Гэрээ хэлэлцээрийн эрсдэлийн асуудлууд арай тусдаа. Энэ өөр хяналт шалгалтаар болон төрийн өмчийн үйлдвэрийн газрууд, хариуцсан яам, төрийн байгууллагууд энэ эрсдэл дээрээ илүү онцгой анхаарч явах ёстой, нэлээн тийм деталь асуудал явлаа даа. Тийм, гэрээ хэлэлцээрүүдийн үнэн дээр эрсдэл гарах уу.

Д.Амарбаясгалан: Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууна.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу, бүгдээрээ. Энэ маш товчхон тэгэхдээ ач холбогдолтой асуулт гэж бодож байна. Бид нар ер нь ингээд хараад байхад юу хууль, дагалдах хууль гээд төсөвтэйгөө хамт зэрэг авч хэлэлцээд байна аа? Ууланд логик дэс дарааллаараа бодоход эхлээд хуулиа оруулж ирчхээд, тэгээд дараа нь төсвөө баталдаг, явдаг нь зөв юм шиг санагдаад байгаа юм. Энэ тал дээр асуулт асууя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Тийм, яах вэ, Ганмаа гишүүний асуултад хариулъя. Бусад органик хуулиудын хувьд ерөнхийдөө тийм зарчим бариад явдаг л даа. Харин төсөв бол яг тухайн жилийнхээ төсөв, тухайн жилдээ үйлчилнэ. Мөн дагасан хуулиуд тухайн жилдээ ч үйлчилнэ, мөн цаашдаа дараа дараагийн төсвийн хуулиуд дээр ч үйлчлэх ийм зохицуулалттай хуулиуд бас орж ирдэг. Мөн тухайн жилдээ төсөвтэйгөө уялдаад нэг жил үйлчлэх ч ийм хуулиуд орж ирдэг ээ. Тэгэхдээ аль болох бас таны саяын ярьж байгаа тэр логик дарааллын хувьд юу тэгж явахыг л хичээнэ л дээ.

Тийм учраас зүгээр тухайн жилийн төсвийн бодлоготой уялдаж байгаа ийм хуулийн зохицуулалтуудыг цуг өргөн бариад, үйлчлэх хугацааг нь цуг эхлүүлээд хойно урдаа орохгүй эхлүүлээд явах ийм зарчмаар энэ удаа орж ирчихсэн байгаа, тийм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн нэмж хариулт өгнө.

Ц.Даваасүрэн: Тийм, Гангамаа гишүүний хэлж байгаа зөв, зөв л дөө. Бид нар яг тэр дарааллаар явж байгаа. Эхлээд дагасан хуулиудаа баталж байж бид нар төсвөө батална. Тэгэхгүй бол нөгөө татвараас гэдэг юм уу, ямар нэгэн юмаа дагасан хуулиа баталж чадахгүй болчихвол нөгөө дараа нь нөгөө төсөв чинь хэрэгжихгүй болчих байхгүй юу. Тийм учраас бид нар эхлээд ингээд дагасан хуулиудаа батлаад, төсвийн хүрээнийхээ мэдэгдлийг батлаад, түүний дараа бид нар төсвөө батална. Тэгэхгүй бол нөгөө төсвөө эхлээд баталчихвал, дагасан хууль чинь батлагдахгүй болчихвол тэр орлого дээр чинь асуудал үүсэх юм энэ тэр гарч болно. Болзошгүй.

Тийм учраас яг тэр логик дэс дарааллаар явж байгаа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулт өгье.

Б.Жавхлан: Тийм, өргөн барьснаас хойш яг батлах дараалал бол саяын Даваасүрэн гишүүний ярьж байгаа яг мэдээлэл шүү. Тийм, харин нэг ийм ерөнхий заалтууд байдаг юм Ганмаа гишүүн ээ. Татварын ерөнхий хууль дээр жишээ нь ингэж байгаа. 4.2 татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь хэмжээ болон татварын суурийг бууруулахтай холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулаад, ингээд өргөн барих ийм хуулийн заалттай байдаг. Өргөн барьснаас хойш батлах дарааллыг нь сая Даваасүрэн дарга хэлчихлээ. Тийм.

Д.Амарбаясгалан: Ганмаа гишүүн тодруулж асууя.

Д.Ганмаа: Баярлалаа. Сайхан тодруулга өгч байгаад. Өнөөдөр хэлэлцэж байгаа энэ дагалдаж орж ирсэн хуулиудад сая Жавхлан сайдын аль аль нь ороогүй гэж ойлголоо. Зөв үү?

Д.Амарбаясгалан: Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Тийм, бид 5 хууль, 3 тогтоол өргөн барьсан байгаа. Өчигдөр Төсвийн байнгын хороон дээр хэлэлцэх эсэх асуудал санал хураагаад 2 нь, 3 тийм ээ, 3 хууль нь дэмжигдээгүй. Тэгээд энэ удаа Улсын Их Хурал дээрээ орж ирээд хэдүүлээ энийгээ хэлэлцэх эсэхээ дэмжээд, засаж найруулах юмаа ажлын хэсэг дээрээ дараа дараагийнхаа хэлэлцүүлгүүд дээрээ сайжруулаад явъя. Тийм.

Д.Амарбаясгалан: Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Би бас өчигдөр Төсвийн байнгын хороон дээр орж бас саналаа хэлсэн л дээ. Энэ ААНОАТ-аас чөлөөлөх энэ хуулийн заалтыг дэмжихгүй байгаагаа, хэлэлцэхгүй байх нь зүйтэй гэдэг ийм байр суурийг илэрхийлсэн. Тэгээд яагаад гэхээр ер нь түрүүн Энхбаяр гишүүнтэй санал нэг байгаад байгаа. Одоо нөгөө бид нар чинь энэ Үндсэн хуульд заасан институцийнхээ түвшинд чек балансаа хадгалж явах ёстой, хяналт тэнцэл. Тэгэхээр энэ нөгөө хяналт тэнцэл гэдэг маань ерөөсөө ингээд алдагдах шинж рүүгээ маш эрчимтэй орж байна л даа. Холилдох, ингээд эрхлэх хүрээний бус асуудлаа Засгийн газар нь авах, энэ тэр гээд.

Нөгөө Үндсэн хуулийн 25.1.7-оор татвартай холбоотой татварын бодлогыг УИХ тогтооно оо гээд ингээд бүрэн эрхийг нь олгочихсон байгаад байгаа.

Дээрээс нь Татварын ерөнхий хуулиараа татварыг тогтоох нь шударга байх ёстой гэж байгаа юм. Нэг 4, 5 зарчим байна. Шударга байх ёстой, тодорхой байх ёстой. Өөрөөр хэлбэл ойлгомжтой байх ёстой гээд нэг ийм 4 шалгуурын тэр шударга байх гэдэг энэ шаардлагыг хангахгүй байх вий гэж би санаа зовоод байгаа юм. Яагаад гэвэл энэ чинь нөгөө Монгол Улсын энэ нийгэм чинь бүхэлдээ л харилцан уялдаатай байгаад байна шүү дээ. Тэгээд бид нар чинь нөгөө олон улсад ингээд нөгөө авлигынхаа индексээр дандаа ухралттай. 180 орноос 121-д байж байна. Огцом огцом. 2016 онтой харьцуулбал бараг тавиад байраар ухарчихсан.

Тэгэхээр энэ бүх юм чинь бүгд цаанаа бас харилцан уялдаад байгаа юм. Тэгэхээр жишээлбэл бүх л компаниуд экспортод чиглэсэн, бүх л юу байх вэ дээ, мэдээж экспортод чиглэсэн бүтээгдэхүүн гаргаж байгаа, импортыг орлохыг хичээж байгаа. Тэгэхээр тэр өнөөдрийг хүртэл явж ирсэн компаниуд хамрагдах юм уу гэдэг нэг ийм асуудал байна.

Тэгээд бүс гээд тэгэхээр бүх л Монгол Улс чинь бүхэлдээ л бүс. Улаанбаатар ч гэсэн бүс. Тэгэхээр энэ Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд яах юм гээд. Эдгээр нь тодорхойгүй гэдэг энэ зарчмын дагуу хангагдахгүй байна гэж үзэж байгаа юм.

Шударга гээд тэгэхээр ний нуугүй хэлэхэд тэр жагсаалтыг Засгийн газар гаргана гэхээр бас л идэвхгүй болоод байна л даа энэ чинь. Бид нар өмнөх туршлагаа харахад бас л хаагуур ямар жагсаалт гараад, ямар компаниудад хөнгөлөлт үзүүлээд байдаг нь ингээд л тодорхойгүй явдаг. Тэгээд ний нуугүй шулуухан хэлэхэд Засгийн газрын сайдуудтай ойр дотно, намын шугамаар харилцаа холбоотой ч байдаг юм уу, тиймэрхүү компаниуд нь холбогдоод, тэгээд тэр хөнгөлөлт ямбыг нь эдлээд яваад байдаг ийм мэдээж тохиолдлууд байгаа. Ил далд. Тэгээд үүнийг ерөөсөө хэн ч ярьдаггүй, энэ дээр ямар нэгэн хяналт шалгалт ч явагддаггүй. Ингээд л явсаар л өнөөдрийг хүрсэн.

Тийм учраас яг ийм шалтгаанаар нөгөө шударга байх гэдэг энэ зарчмыг бас хангахгүй болчих вий гэж айгаад санаа зовоод байгаа юм. Түүнээс биш мэдээж нөгөө манай энэ Засгийн газар чинь бүлэг болгонд хувийн хэвшлээ дэмжинэ гээд байгаа гэдэг утгаар энэ мэдээж ААН-үүдийнхээ татварыг хөнгөлж чөлөөлнө гэдэг нь зөв гэж үзэж байгаа. Зарчмын дагуу. Харамсалтай нь шударга бус юм цаана нь нуугдах вий, авлига, хээл хахууль цаана нь нуугдах вий гэдгээс л болгоомжлоод байгаа юм.

Тэгэхээр дээрээс нь нөгөө хяналт тэнцэл гэдгээрээ Их Хурал нь энэ яг Үндсэн хуулийнхаа дагуу яг тэр эрхлэх хүрээнийхээ асуудалд бодлогоо тодорхойлоод, ямар компаниудыг чөлөөлөх юм, яаж хяналт тавих юм, эргээд гэдэг энэ бүрэн эрхээ хэрэгжүүлээд явах нь зүйтэй байх гэж бодсоны үндсэн дээр үүнийг ер нь хэлэлцээд хэрэггүй гэсэн ийм зарчмын байр суурьтай байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн хариулъя. сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулна.

Ц.Даваасүрэн: Би зүгээр Баярмаа гишүүнийг тэр боловсруулах үйлдвэрлэл дэмжье, экспортыг дэмжье, импортыг орлохыг дэмжье гэж байгааг би эсэргүүцээгүй гэж ингэж ойлгож байна шүү дээ. Зүгээр айгаад байгаа зүйл нь ингээд хэтэрхий ерөнхий тавьчихаар үзэмжийн болоод, тэгээд 1 гаалийн байцаагч ингээд л өө энэ чинь хамаарна, дургүйдээ бол энэ чинь хамаарахгүй гээд л ингээд суугаад авлига

үнэртвэл түүнийг нь эвтэйхэн ямар нэг байдлаар хамруулдаг болчих вий гэж болгоомжилж байгаатай би санал нэг байгаа юм.

Тийм учраас бид нар энэ бизнесийн энэ зөв чиглэлийг дэмжье гэж байгаа юман дээр буцааж болохгүй гэж би бодож байгаа юм. Зүгээр оруулаад ирье. Тэгээд харин чиний ярьж байгаа шиг, гишүүдийн ярьж байгаа шиг, хэдүүлээ тэргүүлэх чиглэл нь аль юм, ямар боловсруулах үйлдвэрээ эхэлж бид нар дэмжих юм гэдэг юмнуудаа яриад, тэгээд заагаад өгчихсөн нь дээр байх. Жагсаалтыг нь баталж өгөөд, аль алин дээр нь би жагсаалтыг нь Их Хурал батлаад өгчихье гэж байгаа юм. Аль үйлдвэрлэлээсээ эхлэх юм. Тэгэхгүй бол бүх үйлдвэрлэл гээд бас ингээд байж болохгүй байх. Яг тухайн бүс нутагт аль үйлдвэрлэлдээ тэргүүлэх ач холбогдол өгч байна, түүн дээрээ бид нар яая.

Экспортод бол тэрийн болгон гаргаж чаддаггүй юм даа. Манайхан. Гаргадаг нэг хэдхэн л салбар байгаа шүү дээ. Тэгэхээр экспорт дээр хэдүүлээ сайн бодъё. Зүгээр экспортод гаргаж чадаад ганц 2 доллар оруулж ирдэг хүн хийж чадаж байгаа бол тэр хүн маш сайн хүн. Түүнийг бид нар 2 гараа өргөөд дэмжих хэрэгтэй. Тэгэхдээ даанч харамсалтай нь Хятадын зах зээлтэй өрсөлдөөд экспортод бүтээгдэхүүн гаргаж байгаа хүн ноолуураас өөр манайд манайд нэг их байхгүй болчихоод байна шүү дээ.

Тэгээд хэдүүлээ энэ дээрээ сайн яриад, энэ бизнесийнхээ бас зөв чиглэлд явж байгаа экспортыг дэмжье. Импортыг орлох бүтээгдэхүүн гаднаас орж ирж байгаа бүтээгдэхүүнийг хязгаарлахад бид нар яаж хориг тавих вэ. Импортын татвараар л хориг тавина шүү дээ. Тийм учраас бид нар тэгж хамгаалж өгөх, мөн заримыг нь экспортын чиглэлийнхийг нь дэмжиж өгөх, ийм арга хэмжээ авч байж л бид нар үйлдвэрлэлийг хөгжүүлнэ үү гэхээс биш үүнийг бүхэлд нь буцаачих юм бол тэгээд л өнгөрөө. Дахиад л нөгөө халамжийн, халамжийн улс хэвээрээ л байгаад байна.

Тэгээд хэдүүлээ хэлэлцэхээ дэмжээд, харин тодорхой болгож өгье. Түүн дээр би ёстой санал нэг байна. Ийм ийм энэ салбарт, тэр бүсэд энэ бүтээгдэхүүнээсээ эхэлнэ, ийм ийм бүтээгдэхүүн байна гээд бүр тодорхой. Тэр гаалийн байцаагч бол ингээд үзэмжээрээ хандахааргүй болгож өгье гэж байгаатай би санал нэг байна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж хариулъя. Улсын Их Хурлын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг баталсан Улсын Их Хурлын тогтоол, сар гаруйхны өмнө 2024-өөс 28 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөр дотор энэ бүсчилсэн хөгжлийг маш тодорхой заачихсан байгаа. 6 бүс, нийслэл гээд. Шинээр бүс тогтоох боломж байхгүй. Монгол Улс нэг бүс гэж бас түүн дээр заалт байхгүй, маш ойлгомжтойгоор газар зүйн байрлалаар нь ингээд заачихсан байгаа.

Тэргүүлэх чиглэлүүдийг ч хүртэл тэнд маш тодорхой заачихсан байгаа. Одоо дахиж шинээр түүн дээр зохиох боломж байхгүй. Тэгэх ч шаардлага байхгүй.

Тийм учраас үүнээс цаашаа эндээ хязгаарлагдаад, энэ чиглэлүүд дээрээ илүү их тодорхой дараагийн шатын үйлдвэр, хөрөнгө оруулалт, энэ бодлогуудаа л дэмжсэн ийм л зүйл. Ер нь бодлогоо эндээ тодорхойлоод бусдыг нь тэр татварын байцаагч, гаалийн байцаагч нар ажлаа хийдгээрээ л ингээд явна. Хяналтын функц ажилладгаараа ажиллаад явах юм байгаа.

Д.Амарбаясгалан: Шадар сайд Тогмидын Доржханд нэмж хариулъя.

Т.Доржханд: Баярлалаа. Би энэ дээр бас нэг товчхон байр сууриа илэрхийлээд, үл ойлголцлоо нэг тийшээ болох нь зүйтэй болов уу гэж бодоод байгаа юм. Тэгэхээр нөгөө хувийн секторыг дэмжинэ гээд бүгдээрээ ярьдаг. Тэгээд хувийн секторыг дэмжих үндсэн 2 санхүүгийн арга байгаа юм. Тэр нь нэг бол зээл өгнө. Хөнгөлөлттэй нөхцөлтэй санхүүгийн асуудлыг нь шийднэ. Үгүй бол татварын хөнгөлөлт үзүүлнэ.

Тэгээд бүгдээрээ ингээд хувийн сектороо дэмжинэ, дэмжинэ гэж лоозогнодог мөртөө яг бодит байдлаар ингээд ороод ирэхээр хуулийн зөрчил үүсэх юм байна, итгэхгүй байна, Засгийн газарт итгэхгүй байна, тийм болохоор энийгээ больё гэж болохгүй ээ. Яагаад гэвэл энэ Засгийн газар хамтарсан Засгийн газар юм. 3 намын хамтарсан Засгийн газар юм. Энэ хамтарсан Засгийн газар бүх юмаа ил тод, нээлттэйгээр яриад явж байгаа. Дотроо бас ингээд хяналттай явж байгаа юм. Тэгэхээр бүх юмыг ингээд парламент дээрээ шийднэ. Засгийн газар тэндээ шийдэж болохгүй гэж явж байгаа бол энэ бас маш том муйхарлал шүү. Яах гэж бид нар хамтарсан Засгийн газар байгуулсан юм.

Тэгэхээр үр дүн нь энэ бизнесийгээ дэмжье ээ. Хувийн сектороо дэмжье, татварын зөв бодлого явуулъя .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд ялангуяа алслагдмал аймаг, бүс нутагт үйлдвэрлэл хөгжүүлэе гэхэд татварын дэмжлэг хийлгэх нь зөв өө. Сүүлийн үед анзаарч байхад ерөнхийдөө ААН-ийн, бизнесийн хувийн хэвшлийг дэмжье гэдэг дээр түлхүү яригдаж байх шиг байна. Заал танхимд. Энэ ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийнхээ татварыг хөнгөлнө гээд ярьсан юм чинь яагаад орж ирэхгүй гацаад алга болчхов оо. Тухайлбал гадаадаас ажиллах хүчний төлбөрийг бүгдийг нь хөнгөлье, чөлөөлье гэж байгаа. Тодорхой хэмжээнд хөнгөлөлт чөлөөлөлтүүд нь байгаа.

Нөгөө талаар хэт хөнгөлөөд, чөлөөлөөд ингээд хаячих юм бол энэ үндэсний ажиллах хүч чинь үндэснийхээ ажиллах хүчийг гадаадад гаргаж байгаад оронд нь өөр гаднын ажилчдыг зөрүүлээд орж ирээд татвараас хөнгөлнө гэсэн үг шүү дээ. Гадаадад үүнийг маш болгоомжтой авч үздэг. БНСУ гэхэд жил болгон квотыг нь тогтоогоод Засгийн газар нь тодорхой хэмжээгээр шийдээд явдаг. Тэгэхээр би хэт ерөнхий юм оруулж ирж, сэтгэл хөөрлөөр оруулж ирж байгаад, сүүлд нь энэ алдаанаас болж элдэв янзын асуудалд өртөх вий дээ. Би саяын тэр зарим саналуудтай нэг байна. Хууль дагаж оруулж ирж байгаад ерөнхийд нь хулгай хийх вий дээ. Энэ дээр Засгийн газар маань бас болгоомжлох хэрэгтэй гэдгийг би бас хэлмээр байна.

2 дугаарт, тэр нийгмийн даатгалыг даадаг хүмүүс гээд тэр санг нь тусгаарлах нь зөв өө. Нийтийн сангаас нэг хэсэг нь баахан хөнгөлөгдөж байгаад ингээд энэ сан маань сүүлдээ ингээд хүндрэл учруулаад нийтээрээ ачаалал үүрье гэдэг энэ асуудал өмнө бид нар тулж байсан.

Мөн Эрүүл мэндийн даатгалын сан ч гэсэн мөн ялгаа байхгүй. Төр даадаг иргэд нь хамгийн их үйлчилгээ авдаг, хамгийн багыг төлдөг. Тэгээд эргээд Эрүүл мэндийн даатгалын сан нь өөрөө дийлэхгүй байгаад маш багыг төлөөд, маш их

үйлчилгээг яг ижилхэн авна гэдэг ийм логигоор явахаар чинь санг чинь бас болдоггүй. Бүр Эрүүл мэндийн даатгал чинь эрсдэл учирчхангуут нь нөхөн төлж байгаад үйлчилгээгээ авдаг гэж энэ даатгалын логикт байдаггүй юмыг хүртэл ингээд бид нар явуулж байгаа шүү дээ. Энэ бол аргаа ядсан арга. Тийм учраас иймэрхүү зүйлүүд дээр энэ дагаж орж ирж байгаа хуулиуд дээр анхаарах хэрэгтэй.

Дээрээс нь компани боловсруулах үйлдвэр дээр энэ эрүүл мэндийн зарим чиглэлийн манай 1000 км-ээс 1500 км-ээс имра-д үзүүлэх гэж Улаанбаатарт хэдэн мянгаараа ирж байгаа хүмүүс байгаа шүү дээ. Үүний тоног төхөөрөмжийг оруулж ирээд тэнд нь суурилуулаад, үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүсийнхээ гааль, Нөат, өөр бусад янз бүрийн татвараас нь хөнгөлөх гэдэг юмыг давхар оруулж ирэхгүй юм уу. Ингэх юм бол тэр иргэдэд үзүүлэх үйлчилгээ, давхар нийгмийн, хувийн хүнээс гарч байгаа зардал, өртөг, цаг хугацаа гээд маш олон зүйл дээр бас нэмэлт хөнгөлөлт дэмжлэг болж, боломжтой юм гэдэг зүйлийг бас хэлмээр байна.

Тэгээд Сангийн сайдаас бас асуумаар байна. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэн. Тэгээд үүнийг энэ төсөвтөө тусгасан уу, үгүй юү? Та үүний өмнөх, Байнгын хорооны хурал дээр 3 талт хороо шийдчих юм бол төсөвтөө оруулж ирээд тусгачихна гэж байсан. Тэгээд өчигдөр бас зарим харсан чинь төсөв өргөгдсөн учраас үүнийг энэ удаадаа арай тусгаж амжаагүй нь энэ тэр гэж юм яриад байсан.

Тийм учраас хүмүүс нэг л зүйлийг асууж байна. Үнэхээр ажлын байртай, тогтмол олон ажилтантай, олон хүний аж амьдралыг аваад явж байгаа ААН байгууллагуудыг дэмжих нь зөв өө. Нийгмийн үнэлгээ гэдэг юмыг энэ өндөр хөгжингүй орнууд чинь хийдэг болчихсон юм байна лээ. Тэгэхгүй бол баахан цаасан дээр нэртэй, тендер оруулж ирдэг, тоног төхөөрөмж орж ирээд үр өгөөж нэг цөөхөн хүнд хүртчих юм биш байгаа гэдэг ийм болгоомжлол бас байгаа учраас энэ энэ хууль дээр бас зарим шалгуур, үзүүлэлтүүдийг нь оруулж ирж, ямар компанид, ямар хугацаагаар ажиллах, ямар нөхцөлд вэ гэдгийг нь нарийн зааж өгөх, ингэж оруулж ирнэ гэх юм бол энэ хуулийг, төслийг дэмжихийг дэмжиж байна. Хэт ерөнхийд нь заагаад засаг ерөнхийдөө мэднэ дээ гээд хаячих юм бол энэ тэгээд л мартагдаад эрсдэл учрах вий дээ гэдэг ийм болгоомжлол байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн хариулна.

Ц.Даваасүрэн: Тийм, тийм, Байнгын хорооны хурал дээр ийм саналуудыг гишүүд хэлээд байгаа юм. Тэгээд би гишүүдтэйгээ санал нэг байна. Юуг чөлөөлөх юм, ямар хувиар чөлөөлөх юм гэдэг Их Хурлын онцгой бүрэн эрх. Засгийн газрын гишүүд энэ дээр нэг их маргаад хэрэг байхгүй. Тэгж байгаад юмаа унагаад ерөөсөө хэрэг байхгүй. Тийм учраас юуг чөлөөлөх юм гэдэг чинь Их Хурлын бүрэн эрх байхгүй юу. Тийм учраас эд нарын хэлээд байгаа үнэн. Тэр эрхийг нь авах гэж байгаа бол аятайхан ярилцаад тэгээд шилжүүлж ав. Түүнээс биш ингээд Их Хурлын бүрэн эрхийг шууд Засгийн газар ингээд ингээд суугаад байж бас болохгүй шүү дээ. Юуг чөлөөлөх юм гэдэг чинь Их Хурлын бүрэн эрх байхгүй юу. Хэдэн хувиар чөлөөлөх юм Их хурлын бүрэн эрх. Тийм учраас үүнийгээ харин зүгээр яаж хэдүүлээ хуульдаа зааж өгөх юм. Хуучин бол бүр ингээд бараа бүтээгдэхүүнээр нь жагсаалтаар нь баталдаг байсныг чи, бид мэднэ шүү. Тийм маркийн цемент, тийм маркийн хавтан гээд. Одоо бол харин арай ч бүр тэр нь байхгүй болоод сүүлдээ бүр нийтэд нь ерөнхий юм оруулаад ирчхэж байна шүү дээ, тийм ээ. Энэ чинь бас гишүүдийн хэлээд байгаа, би үндэслэл байна гэж үзэж байгаа учраас хэдүүлээ саяын унагасан 2 асуудлаа хэлэлцье, хэлэлцээд явъя. Хэлэлцэхдээ тэр та нарын

хэлээд байгаа шиг тодорхой тэргүүлэх гэдэг дотор нь яг аль нь юм, аль нь аль ажил үйлчилгээ нь багтах юм, тэр зүйлээ хэдүүлээ ингээд яриад явсан нь дээр байх. Түүнээс биш энэ хуулийг шууд буцаачхаж болохгүй ээ.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Тийм, Даваасүрэн гишүүнтэй санал нийлж байна. Энд ерөөсөө огт маргах асуудал байхгүй шүү, тийм. Эрдэнэбат гишүүний асуултад нэмж мэдээлэл өгье. Засгийн газар дэгийн тухай хууль, Төсвийн тухай хуулиараа шинэ цаглавартай болсон. Энэ жилээс эхлээд. 9 сарын 1-нд ирэх жилийнхээ төсвийг өргөн барьдаг хуультай. 9 сарын 1-нд өргөн барих үеийн хөдөлмөр хөлсний доод хэмжээгээр Засгийн газар төсвөө тооцоолж өргөн барьсан байгаа. Таны яриад байгаа 3 талт хэлэлцээр чинь нэгд өнгөрсөн 7, тэрний өмнөх 7 хоногт болсон шиг санаж байна.

Тэгэхээр одоо нэгэнт өргөн баригдсан хууль дээр Засгийн газар мэдэж засвар хийх ямар ч боломжгүй шүү дээ. Та үүнийг их л сайн мэдэж байх учиртай хүн дээ. Хэрвээ өөрчлөлт орсон, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж байвал хэлэлцэж байх үед яригдах ёстой л ийм зүйл. Мэдээж дараагийн дараа оны төсөв өргөн баригдахад тухайн үед ямар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ байна түүгээрээ тооцооллоо хийгээд л өргөн баригдана.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэбат: Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулиар хэрвээ улсын төсөв батлагдсаны дараа тогтоосон бол түүний дараагийн жилээс гэж байгаа. Одоо улсын төсөв батлагдаагүй байгаа.

Нөгөө талаар үүнийг удаашруулсан шалтгаан бол Засгийн газар 5 сарын 1-ний дотор энэ асуудлаа шийдэх ёстой байсан. Сонгууль юм муу гэж явсаар байгаад бид хэд оройтсон нь үнэн. Гэхдээ хуулиараа бол энэ батлагдсаны дараа 26 оноос. Одоо бол төсөв батлагдаагүй, одоо хэлэлцэж явж байгаа үе байгаа учраас үүнийг та бас өөрөө тэр хуулийг бас тодруулж хараарай гэдгийг хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууна.

Д.Пүрэвдаваа: Энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Ялангуяа туршлагатай парламентч Даваасүрэн даргаас бас асуумаар байна. Ер нь энэ хууль тогтоомжийн хуулийн дагуу энэ хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой асуудлууд ер нь өнгөрсөн Таны 5 удаа сонгогдоход ер нь дандаа ингэж хууль дагаж орж ирдэг юм уу, эсвэл тусдаа хэлэлцэж явах нь зүйтэй байдаг юм уу? Туршлагаас.

Тэгээд өнөөдөр энэ хэлэлцэгдэж байгаа асуудлууд дээр энэ бүсчилсэн хөгжлийн бодлогын бичиг баримт Улсын Их Хурлаар хэдэн онд батлагдсан юм бэ? Тэгээд өнгөрсөн 8 жил энэ юмаа анхаарахгүй юугаа хийж байсан юм бэ? Шалтгаан нь юу байгаа юм бол, 1 дүгээрт.

Дараагийнх нь зүйл энэ дандаа л нөгөө хөнгөлөлт, 5 жилийн хугацаанд 90 хувь гээд. Яагаад 3 жил биш юм, яагаад 8 жил биш юм, 80 хувь биш юм, 70 хувь биш юм, 90 хувь юм. 100 хувь чөлөөлнө өө гээд том ААН-үүд гээд энэ танилцуулга нь аягүй бүрхэг. Тэгээд энэ ажлын хэсгийнхнээс асуух гээд байгаа юм. Одоо ямар нөхцөл дээр байсан юм. Тэр өмнө нь энэ та бүхэн 8 жил төр барихдаа жишээгээр

энэ чинь дандаа л сайн сайхан юм ярьж оруулж ирдэг шүү дээ. Та бүхэн ЖДҮ-ийн сан тонож байхдаа бид нар тононо оо гэж ингэж оруулж ирээгүй байх. Хөгжлийн банк тонож байхдаа бодвол сайхан л зүйл ярьж байсан. Нөгөө сэргэлтийн бодлого, Алсын хараа гээд. Тэгээд мэдээж энэ чинь бид нар аягүй гоё юм санаачлаад байна гээд.

Тэгээд өмнө нь бодвол адилхан л ийм гоё юм л санаачилна гэж байгаад л нөгөөдөх нь хулгай болж хувирсан. Сэтгүүлчид болон би энэ иргэнийхээ хувиар асуухад тэр 16 оноос 20 онд чинь нөгөө ЖДҮ-ийн асуудал яригдаж байсан. 20-24 онд нэг нүүрсний асуудал яригдаж байсан. 24-28 онд хөнгөлөлт эдэлнэ гэхээр та бүхэн маань өөрсдөө нөгөө тэр анхандаа ЖДҮ байсан улсууд маань томорсоор томорсоор Ардын намынхан маань хөнгөлөлт эдлэх шатдаа очиж байгаа юм уу гэж харж байгаа байхгүй юу. Үндсэндээ хэвлэл мэдээллээр гарчихсан шүү дээ. МАН-ыг санхүүжүүлэгч компаниудын жагсаалт гарсан шүү дээ. Хэд нь өнөөдөр тэгээд хөдөө үйл ажиллагаа явуулаад байгаа юм. Яг хотод өнөөдөр том гэдэг нь хэд байгаа юм? Та нэг 5 жишээ дурдаач. Яг өнөөдөр 20 хувийн зээл аваад тийм ээ, хөдөө орон нутагт энэ хөнгөлөлтөд хамрагдах зайлшгүй бид нарын халамжид хамрагдах ёстой нэг 5 том компанийн жишээ татаач. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Даваасүрэн дарга хариулъя.

Ц.Даваасүрэн: Тэгээд Пүрэвдаваа гишүүний эхний асуултад хариулъя. Тэгээд төсөв чинь өөрөө орлого, зарлага 2. Орлого чинь өөрөө татвартай уялдаатай эд байгаа байхгүй юу. Тийм учраас тухайн жилийн орлогыг тогтооход Татварын хууль заавал хөндөгдөнө. Жишээлбэл, энэ 2 орж ирж байгаа Татварын хуулийг хэрвээ бид нар унагачих юм бол үүнээс орж ирэх татварыг хасчихсан байгаа шүү дээ. Магадгүй татвараа нэмэх тохиолдолд жишээлбэл архи, тамхи дээр гэдэг юм уу, орлогыг нь авъя гээд татвар нэмчихсэн байгаа бол төсвөө дагуулаад л өргөн барь. Яагаад гэвэл төсвийн орлогыг бүрдүүлэхэд татвар өөрөө чиглэдэг учраас. Тийм учраас төсөв дагаж Татварын хуулийн өөрчлөлтүүд орж ирсээр ирсэн. Зүгээр өнгөрсөн хугацаанд нэг баримталдаг юм бол татварыг хувь гишүүн санаачлахаа больё л гэж.

Тийм учраас бид нар ер нь сүүлийн парламентуудад хувь гишүүн татварын асуудал барьж орж ирэхийг үндсэндээ зарчмын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулиараа ч тэр, ер нь ёс суртахууныхаа хүрээнд бас ойлголцоод ингээд явж байгаа. Хувь гишүүн бол Татварын хууль санаачлахгүй байгаа. Зүгээр тэр экспортлогч, үгүй ээ, тэр хулгай хийсэн нөхөд экспортлогч болчихсон байгаа бол сайн л байна, зүгээр. Харамсалтай нь тэгж экспортлогч болсон юм байхгүй байх. Зээлээ төлж чаддаггүй л юм байна лээ шүү дээ.

Ахиад ер нь тэр нөгөө нэг Хөгжлийн банкны зээл авсан нөхдийг дахиад нэг үзэх хэрэгтэй. Тэр ЖДҮ-г нь ч гэсэн үзэх хэрэгтэй. Экспортлогч болж чадаж байгаа улс уу, чадахгүй байгаа байхгүй юу. Хамгийн гол нь. Зээлээ төлөхгүй байгаа байхгүй юу. Тэр нь л асуудал.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Энэ жилийн 6 дугаар сард Улсын Их Хурлын 64 дүгээр тогтоол Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг баталсан. Ийм зүйл байгаа. Сар гаруйн өмнө Засгийн газар өргөн барьсны дагуу

Улсын Их Хурал 24-28 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөр, төлөвлөгөөг баталсан. Энэ мөн л бүсчилсэн хөгжил дээр суурилагдсан ийм бодлого байгаа шүү.

Энэ татварын хөнгөлөлт чөлөөлөлтүүд бол баялаг бүтээгчид, хувийн хэвшлийг дэмжиж байгаа л ийм л асуудал. Зээл тусдаа. Энэ татварын асуудал татварын бодлогоор бүсчилсэн хөгжлийн хүрээнд тэргүүлэх чиглэлийн салбаруудаа дэмжих, хөгжүүлэх хамгийн том хөшүүрэг боломж нь өөрөө энэ юм байгаа юм. Бид бүгдээрээ үүнийг дэмжье, хөгжүүлье гэж ярьдаг мөртөө яг ороод ирэхээр яг ийм эсрэгээр нь бас ингээд янз бүрийн лоозон зүүж байгаад унагааж, жадлан эсэргүүцэж ингэмээргүй байна.

Мэдээж сайжруулах, өшөө илүү тодорхой болгох, ойлгомжтой болгох зүйлүүд байлгүй яах вэ. Зүгээр янз бүрийн ийм ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд нэмж хариулья.

Б.Жавхлан: Тийм. Тэгэхээр энэ аливаа татварын бодлого бол нэг компани, хувь хүн, ААН-д чиг чиглэсэн зүйл байдаггүй. Энд хэн ч оролцож болно, хэн ч хамрагдаж болно.

Дээрээс нь тэр 90 хувь яагаад байгаа юм, яагаад 100 хувь. 100 хувь болгочихоор ингээд татварын орчноосоо ААН-үүд маань бүр ингээд төөрөөд алга болчихдог байхгүй юу. Тайлан гаргах ч шаардлага байхгүй. Ингээд ААН-үүд маань татварын эрсдэл рүү явж ордог.

Тийм учраас 90 хувь чөлөөлнө гэдэг маань 1 хувь төлнө гэсэн үг. 1 хувиа төлөөд, тайлангаа бүртгүүлдэг, ингээд байж байх хэрэгтэй. Түүнээс биш ингээд бүр ингээд чөлөөлөөд явуулаад алга болгоод ингэж болохгүй юм байгаа юм. Ийм бодлогын хүрээнд шүү. Тийм.

Тэгээд ер нь энэ татвар, энэ тэргүүлэх чиглэл, үйлдвэр боловсруулах гэж байгаа маань дандаа ирээдүй рүүгээ чиглэсэн шүү дээ. Ирээдүйд үйлдвэр бариад тэгээд зээл авсан бол 2, 3 жил дотор үйлдвэрээ бариад, үйл ажиллагаа нь тогтворжоод, эхлээд, тэр хугацааг нэг ойролцоогоор 5 жил гэж олон судалгааны үндэс дээр гаргаж байгаа юм. 1 жил, 2 жил байж болохгүй. 6, 7 гээд бас алсраад явж болохгүй. 5 жилийн ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Шадар сайд Амарсайхан нэмж хариулна.

С.Амарсайхан: Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, удирдлага зохион байгуулалтын тухай хууль анх 2003 онд батлагдсан. Сая 6 дугаар сарын 4-ний өдөр энэ жил энэ үзэл баримтлал шинэчлэн батлагдсан. Удирдлага зохион байгуулалтын хуульдаа бас тодорхой өөрчлөлтүүдийг хийх ёстой. Ер нь энэ удирдлага зохион байгуулалтын хуулиас гадна бүсчилсэн хөгжлийг бид нар орон нутгийн онцлогтой, ААН, иргэдийн оролцоон дээр тулгуурласан, цаг үеэ олсон, гэхдээ хялбар бөгөөд эдийн засгийн үр өгөөжтэй, хэрэгжүүлэх боломжтой ийм төсөл, хөтөлбөрүүдээ хэрэгжүүлэх замаар бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангая л гэж ингэж явсан.

Тийм ч учраас өнгөрсөн Их Хурлын ээлжит бус чуулганаар төсвийн тодотголоо баталсан. Үзэл баримтлалаа ч үндэслэж, хөтөлбөрөө баталж, Засгийн газрын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөртөө ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Шадар сайд Амарсайхан нэмж гүйцээж хариулъя.

С.Амарсайхан: Ингэж бүтсэн хөгжилдөө онцгой анхаарч, тэргүүлэх зорилттой болгоё л гэж, түүнтэй уялдуулж, 25 оны төсөв төлөвлөгдөж орж ирж байгаа. Тэгээд мэдээж гишүүд маань бас асууж тодруулах, анхааруулах олон зүйлүүд байгааг ойлгож байгаа. Гэхдээ бид энэ ААН-үүдээ хөл дээр нь босгож, зах зээлээ тэлж байж, ашиг орлогоо нэмэгдүүлж, айл өрхийн амьжиргааг дээшлүүлж байж, улс үндэстнээрээ урагшлах боломж нөхцөл бүрдэнэ ээ. Энэ эрхийг авахаас гадна яаж хэрэгжүүлэх вэ гэдэг дээр, ямар асуудлууд байх вэ гэдэг дээр ч гэсэн санаа зовж байгааг ойлгож байгаа.

Ер нь энэ татварын хөнгөлөлтийг бид нар гааль болон бусад татварын хөнгөлөлтийг үзүүлж байж, аж ахуй нэгжүүд үйлдвэрлэл үйлчилгээгээ явуулах, хүчин чадлаа нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтаа татах, тэгээд технологийн дэвшлийг дэмжих, өртөг бууруулах, бүтээгдэхүүний үнэд өртөг ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Тогмидын Доржханд нэмж хариулъя. Шадар сайд.

Т.Доржханд: Би энэ дээр Пүрэвдаваа гишүүн дээр яг тодорхой хэлэхэд зөв, зөв, асуудалтай нь санал нэг байгаа юм. Гэхдээ нэг ийм юм байгаа шүү. Маш олон жил бас нэг татварын чиглэлээр ажиллаад бас судалгаа хийж байсан. Сангийн яаманд бас яг 1990 оноос хойш бид нар үүнийг яаж хялбаршуулах вэ, яаж 1 хувь болгох вэ гэдэг дээр ингээд тооцоо хийгээд л явдаг байсан. Тэгээд ер нь энэ агуулга нь экспортыг дэмжих, импортыг орлох, тэгээд бүс нутагт байгаа тэр хөдөө орон нутагт байгаа энэ ААН-үүдийг хэрхэн дэмжих вэ гэдэг дээр л байгаа юм.

Тэгээд маш олон судалгаа хийдэг байхгүй юу. Хялбаршуулсан байдлаар Аргентины жишээ гээд тэгэхэд ерөөсөө татварыг нь авахдаа болохоор ашигласан цахилгаан, ашигласан талбай, дулаанаас нь хамааруулж авдаг ч байдаг юм уу. Гэтэл их олон улсуудыг харж үзэхэд ерөөсөө ингээд 1 хувь гэдэг бол хамгийн зөв бодлого юм байна, зохицуулалт юм байна гэдэг ийм юман дээр олон улс дээр ийм жишээнүүд байдаг. Өөрөөр хэлэх юм бол нэг ч татвар авахгүй байх юм бол үүнийг сахь ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Пүрэвдаваа гишүүн тодруулга авах уу. Тодруулж асууя.

Д.Пүрэвдаваа: 1 дүгээрт, өнөөдрийн чуулганы хуралдаанд тэмдэглэлд нь тусгуулмаар байна. Хувь гишүүний хувьд энэ хөнгөлөлт, чөлөөлөлтөөс болж давуу байдал үүсэх вий гэдэг дээр анхааруулж байсан гэдгийг тодруулж, тэмдэглэж тусгуулмаар байна.

Дараагийнх нь зүйл энэ юугаа хариулсангүй шүү дээ. Өнгөрсөн 8 жил хүчээ нэгтгэж байх үедээ хийж байхгүй яасан юм бэ? Санаачлахгүй яасан шалтгаан нь юу байгаа юм? Тэр ЖДҮ ид яригдаж байх үед энэ бүсчилсэн хөгжлөө яагаад энэ асуудлуудаа яригдаж байгаагүй юм? Сая Шадар сайд хариуллаа шүү дээ. 2003 онд батлагдсан бодлогын бичиг баримт гээд. Тэр шалтгаануудыг нэг үндэслэлтэй нь гаргаж тавиач.

Мөн одоо байгаа энэ төсөл, хөтөлбөр чинь хэрэгжсэнээрээ хэдэн төгрөгийн тэрбум юм уу, их наяд юм уу ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуулт асууна.

Сая үг хэлчихлээ шүү дээ.

Г.Уянгахишиг: Ерөнхийдөө гишүүдийн асуусан асуулттай, ерөнхийдөө санал нэг байгаад байна. Энэ дээр нэг өнөөдөр ер нь нөгөө хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэж байгаа учраас гол 2 зүйл асуулт байгаад байна.

1 дүгээрт, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулахаар байгаа. Энэ дээр 25 онд 40 хувь хүртэл гэдэг өөрчлөлт оруулсан байгаад байгаа юм. Тэгэхээр хэрвээ энэ өөрчлөлтийг оруулахгүй бол ер нь 65 хувь хүртэл Ирээдүйн өв сангийн данс руу мөнгө шилжиж орох ёстой шүү дээ. Тэгэхээр энэ 25 хувь нь ямар хэмжээтэй байгаа вэ, төсөвт яаж нөлөөлж байгаа вэ гэдэг 1 дүгээр асуулт байна.

2 дугаар асуулт нь яг гишүүдийн бүгдийнх нь хөндөөд байгаа асуудал буюу одоо энэ ААН-ийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль байгаад байгаа. Энэ дээр ерөнхий зарчмыг нь дэмжээд байгаа. Гол нь энэ маань өөрөө хэрэгжихдээ нэлээн олон зарчмын үл ойлголцлуудыг бий болгохоор харагдаад байна л даа. Жишээлэх юм бол энэ 22.5.22 дээр ер нь бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн импортыг орлох, экспортыг дэмжих төсөл гээд ингээд тодорхой заагаад өгчихсөн байгаа. Сая Жавхлан сайд бас хэлж байна. Үзэл баримтлал тодорхой байгаа. Ямар төслүүд явах вэ, яах вэ, ийх вэ гэдэг ерөнхийдөө баталчихсан байгаа шүү дээ гээд хэлээд байна шүү дээ. Тэгж байгаа тохиолдолд заавал тэр төслийн жагсаалтуудыг Засгийн газар батлаад байх шаардлага байгаа юм уу гэдэг нэг асуулт байгаад байна. Энэ нь өөрөө буцаад ямар асуултуудыг бий болгоод байна гэхээр Засгийн газар тэр жагсаалтаа хэзээ батлах юм. Тэр төсөл нь ААН-үүдийнх нь нэршлээр байх юм уу. Тухайн боловсруулах үйлдвэр гэдэг салбарынхаа нэршлээр байх юм уу. Яг тэр жагсаалт яаж, хэзээ, процесс явагдах гээд байна вэ гэдэг энэ өөрөө маш чухал асуудал болоод байна.

Тэгэхгүй бол буцаад бүгдэд нь адилхан тэгшхэн үйлчлэх ёстой 22.5.22 гэдэг заалт маань буцаагаад тэр нөгөө жагсаалтыг Засгийн газраас батална гэдэг заалттайгаа зөрчилдөх гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийг нэг задгай тавья, эсвэл 22.5.22-тоо тэр давхар нөхцөлөө суулгаж өгөх хэрэгтэй байна гэж хараад байна.

Дахиад нэг жижиг асуулт байгаа нь одоо энэ 3 дугаар зүйл дээр байгаа 15.1.18-ыг хасна гэж байгаа шүү дээ. Энэ нөгөө танилцуулга дээрээ ерөөсөө байхгүй байгаад байна. Танилцуулга дээр виртуал бүсэд явуулахыг л нөгөө давхцаад байгаа учраас хасаж байна гэж байгаа. Гэтэл 15.1.18 маань асаргаа халамжийн байгууллагын байранд оруулсан тусламж, дэмжлэг гэж байгаа юм. Тэгэхээр үүнийг яг яагаад хасаж байгаа талаар энэ нөгөө хуулийн төслийн танилцуулга дээр байхгүй байна. Үүнийг тодруулж асуумаар байна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Тэгье, тантай санал нийлж байна. Одоо оруулаад ирсэн хууль, тогтоолуудаа дэмжих эсэхээ шийдчхээд сайжруулах юмнуудаа өөрчлөөд л явчихъя.

Тэр төслүүд, төсөл гэдэг чинь ингэж ойлгох хэрэгтэй шүү. Ерөнхий ингээд тэргүүлэх чиглэлүүдээ ингээд тавьчихсан байгаа бүс бүсээр нь, тийм үү. Одоо тэгэхээр үүнийг чинь Засгийн газар хэрэгжүүлнэ дээ, тийм үү. Хэрэгжүүлэхийн тулд энэ чинь бүс бүр ялгаатай байгаа шүү дээ. Аялал жуулчлал, ХАА гээд тийм ээ, энэ чинь өөр өөр, МАА, газар тариалангийн бүс нутаг гээд өөр өөр байгаа.

Тэгэхээр түүнийг яг чиглэлийн яамнууд нь өөрсдөө үүнийгээ оруулж ирэх байхгүй юу, Засгийн газар дээр, жишээ нь. Тэнд юу болох вэ гэхээр. Аялал жуулчлал гэхээр Номин сайд энэ энэ бүс дээр ингээд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал гарсан учраас ийм бодлого хэрэгжинэ ээ. Энэ манай салбарын чиглэлээр энд ийм ийм, үйлдвэр, үйлчилгээнүүд ингээд явах юм гээд. Туваан сайд жишээ нь одоо юу гэдэг юм, тэр хүнд аж үйлдвэрийн бүс нь хаанаа юм, хөнгөн аж үйлдвэр нь хаанаа юм. Үүнийхээ өөрийнхөө тэр чиглэлийн дагуу, тэр стандарт тэр босгуудаа оруулж ирнэ. Ингээд салбар салбараараа яамнууд өөрсдийнхөө чиглэлээр чиглэлүүдээ оруулж ирээд Засгийн газар дээр нэгтгээд, ингээд түүнийх нь дагуу энэ дараагийн шатанд нь татвараар тэгвэл яаж дэмжих вэ, яах вэ, яаж хоорондоо кластерлах вэ гэдэг ийм зарчмаар явах байхгүй юу. Түүнээс биш нэг компанийн нэр орж ирээд л эсвэл яг нэртэй төсөл орж ирээд л тэгж явахгүй шүү дээ. Тийм, ийм маягаар явна.

Тэгээд ямар ч гэсэн хэдүүлээ хэлэлцэх эсэхээ шийдчихээд, гишүүдийн ярьж байгаа энэ асуудлуудыг ажлын хэсэг дээр ярилцаад явах нь зөв байх. Хэдүүлээ ингээд хувийн сектороо, баялаг бүтээгч нараа, татварын бодлогоороо бүсчлээд ч дэмжье. Орон даяар хэдүүлээ түүхий эд экспортолдогосоо үйлдвэрлэл рүүгээ эцсийн бүтээгдэхүүн бүтээдэг болцгооё оо.

Д.Амарбаясгалан: 2 асуултад хариулт аваагүй байна. Тэлмүүн ажлын хэсгийн 6 дугаар микрофон өгье. Тэлмүүн дарга хариулна.

Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн Уянгахишиг гишүүний асуултад хариулъя.

Энэ таны асуусан 15.1.18, 15.1.19 гэдэг энэ 2 заалт нь бол 24 оны 6 сарын 5-ны өдөр батлагдаад Төрийн мэдээлэл сэтгүүлд 7 сард хэвлэгдсэн байдаг. Эдгээр заалтууд нь Улсын Их Хурлаас 24 оны 8 сарын 30-ны өдөр батлагдсан энэ 22.9 буюу нийгмийн хариуцлагын хүрээнд үзүүлж байгаа хөрөнгө оруулалт, хандив тусламжийн энэ татварын хөнгөлөлттэй давхцаж байгаа.

Тийм учраас энэ хуулийн нийцлийг хангуулах зорилгоор 2 талдаа ийм ижил агуулгатай заалтууд байж болохгүй. Энэ хуулийг 8 сарын 30-ны өдөр батлах үеэр Төсвийн байнгын хороон дээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар томъёолол оруулах бололцоогүй байсан учраас чиглэл өгөөд Төсвийн тухай хуультай хамт эдгээр хуулиудын өөрчлөлтийг дагалдуулж оруулаад, хуулийн нийцлийг хангуул, зөрчлийг арилга гэсэн ийм чиглэл өгсний дагуу орж байгаа. Тодруулаад танд хэлэх юм бол ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Болсон, тийм ээ. Уянга хишиг гишүүн тодруулж асууя.

Г.Уянгахишиг: Тийм. Тэгэхээр үүнийг нөгөө танилцуулга дээрээ ерөнхийдөө бас оруулж өгч байгаарай. Тэгэхгүй бол яг энэ танилцуулга дээр чинь энэ заалтын тухай ерөөсөө байхгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгээд миний дахиад эхний, хамгийн эхний асуулт байгаа шүү дээ. Нөгөө Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн нөгөө дагаж мөрдөх тухай журмын тухай хуульд нэмэлт оруулах гээд

байгаа 25 онд 40 болгож бууруулж байгаа, тэрний зөрөөг, зөрөөний мэдээллийг өг өө гээд байгаа шүү дээ. Мөнгөн дүнгээр.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсэг, 4 дүгээр микрофон, Тулга дарга хариулъя.

С.Тулга: Баярлалаа. Гишүүний асуултад хариулъя. Үндэсний баялгийн сангийн тухай хууль 24 оны 4 сарын 19-ний өдөр батлагдсан. Энэ өдөр хамт Үндэсний баялгийн санг дагаж мөрдөх журмын тухай хууль бас хамт батлагдсан байгаа. Энэ хуульд Ирээдүй өв санд АМНАТ-аас хуваарилах төлбөрийн 20 хувийг гэж заасан байгаа. 25 онд бид нар энэ 20 хувийг нэмэгдүүлээд 40 хувь болгоод, 26 оноос хойш 65 хувьдаа хүрэхээр ингэж тооцож оруулж ирсэн байгаа. Яах вэ, 40 хувь, 65 хувь 2-ын зөрөө 1,2 их наяд төгрөгтэй тэнцэж байгаа. Ингэхээр тэнцвэржүүлсэн орлого 1,2 их наядар буурна гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Уянгахишиг гишүүн ээ, ер нь ийм юм. 22 онд яг ковидын үед төсөв маш хүнд байсан шүү дээ. Бид нар маш хүнд, ер нь зарлагаа дийлэхгүй маш хүнд байлаа. Тэр үед Ирээдүй өв санг ирээдүй хойч үедээ энэ зориулж байгаа энэ санг хүүхдийн мөнгөнд зориулсан, хүүхдийн мөнгөнд зориулсан. Одоо түүнээс хойш бид нар ингээд нөхөж хийж байна гэсэн үг. Шууд 65 хувиар бид төсөв дийлэхгүй. 20 хувь, 40 хувь, 65. Одоо 26 онд 65 хувь дээр хүрчихнэ. Хууль дээр 65-аараа байж байгаа шүү дээ. Дагаж мөрдөх журмын хуулиар зохицуулалт хийгдээд хүүхдийн мөнгөндөө зориулсан юм. Одоо ингэж нөхөж хийх процесс явж байна гэсэн үг. Шууд энэ чинь нэгд бас дийлэхгүй, тийм.

Тэгэхээр 25 онд 40, 26 онд 65 гээд гүйцээ. Дагаж мөрдөх журам шүү. Тийм, хууль, тэр хуульдаа.

Д.Амарбаясгалан: Мэндбаярын Мандухай гишүүн асуулт асууна.

М.Мандхай: Би Боловсролын сайд, ХХААХҮ-ийн сайдаас асуулт асуумаар байна. Энхбаяр сайд байхгүй байх шиг байна, тийм ээ. Улсын Их Хурлын 24 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар зүйлийн 3.3.4.3 дахь заалтад МАА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн хоршооны загвар төслүүдийг бэлтгэж, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэн, сургалт зохион байгуулна гэсэн зохицуулалтыг Улсын Их Хурлын ээлжит бус чуулганаар оруулж батлуулсан. Гэтэл Засгийн газраас өргөн барьж байгаа энэ төсвийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөлд Хөдөө аж ахуйн хүнсний салбарын хүний нөөцийн асуудлыг үүнтэй холбоотой ер нь зохицуулалт байхгүй байна. Гэтэл Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2018 оны 267 дугаар тогтоол, Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9 дэх заалтуудын дагуу баталгаажсан Хөдөө аж ахуйн салбарт ажиллах мэргэжлийн ажилтны нийт 8925 ажлын байранд 2023 оны статистик мэдээгээр зөвхөн 1620 ажлын байранд л мэргэжлийн шаардлага хангасан ажилтан ажиллаж байна гэсэн байна.

Тэгээд энэ хуулийн хэрэгжилт бол өөрөө 29,1 хувийн ийм хангалттай явж байгаа. Ингээд үүнийг үзэхэд Улсын Их Хурлын 36, 63, Засгийн газрын 166 дугаар тогтоолууд буюу Хүнсний хувьсгал, Цагаан алт, Шинэ хоршоо гэсэн энэ хөдөлгөөнийг хэрэгжүүлэхтэй холбоотой энэ мэргэшсэн, дээд боловсролтой,

мэргэжлийн шаардлага хангасан, энэ боловсон хүчний асуудал нэлээн хөндөгдөх болж байна.

Тэгээд энэ асуудлыг энэ төрийн захиргааны төв байгууллагууд ер нь ямар арга хэмжээ авч ажиллая гэж бодож байгаа. Энэ төлөвлөгөөнд ер нь тусгагдчихсан явж байгаа юу? Тэгээд миний зүгээс шаардлагатай бол бас энэ асуудлыг шийдвэрлэхэд хамтарч ажиллахад бас бэлэн байна. Тэгээд 2 сайдаасаа энэ асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Жадамбын Энхбаяр гишүүн хариулъя. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Мандухай гишүүн та манай салбарын хамгийн тулгамдсан асуудлыг хөндлөө. Үнэхээр салбарын хүний нөөцийн асуудал хүнд байгаа. Насжилт их өндөр, учир шалтгаан юу вэ гээд судалсан. Манай салбарын гол боловсон хүчнийг бэлддэг ХААИС маань Боловсролын яамны харьяанд ажилладаг. Цагтаа 15 мянган оюутан элсэж, суралцаж, Хөдөө аж ахуйн салбарын боловсон хүчнийг бэлдэж байсан сургууль. Одоо нэг 3 мянга хүрэхгүй оюутантай. Бас ангиудыг нь сонирхоод үзсэн. Хөдөө аж ахуйн маркетинг, Хөдөө аж ахуйн менежмент, Хөдөө аж ахуйн аялал жуулчлал гэсэн ангиуд түлхүү. Үндсэн суурь зоо техник, агрономи мэргэжлийн суурь боловсон хүчнийг бэлтгэх түвшин элсэлт туйлын тааруу. Үндсэндээ хөдөө аж ахуйн салбарын боловсон хүчнийг хангаж, бэлдэж өгөх ёстой ажил туйлын муу байгаа юм.

Нөгөө талаар манай салбарын гол энэ томоохон бодлогыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн нарийн судалгаа, дүн шинжилгээгээрээ бодлогыг хангах ёстой хүрээлэнгүүд маань бас яамнаасаа өөр. Боловсролын яамны харьяа байж байгаад сая бас дахин өөр яамны харьяанд шилжсэн. Үндсэндээ шинжлэх ухаантайгаа хүний нөөц нь, үйлдвэрлэл нь, бодлого нь ингээд салчихсан ийм байдалтай л байгаа.

Нөгөө талаас бодитойгоор бас Монголын эдийн засаг өссөнтэй холбоотойгоор олон салбарууд бий болж байна. Хүний нөөцийн дутагдал цаашдаа гарах нь тодорхой. Манай салбар гаднаас ажиллах хүч авах асуудал зайлшгүй болж байгаа. Ялангуяа ноос ноолуурын энэ оёх, ээрэх, сүлжихээс авхуулаад энэ хөдөө аж ахуйн салбар, хүлэмжийн аж ахуй энэ ногооны чиглэл дээр хүний нөөц маш дутмаг болох нь тодорхой байна.

Тэгэхээр бидэнд байгаа бололцоо буюу ХААИС-ийг нэлээн сайн чадавхжуулах энэ том зорилтыг хэрэгжүүлэхэд хүний нөөцөөр хангах бодлогоо нэлээн сайн суурьтай өөрчлөхгүй бол ийм маягаар салбар гүн гүнзгий боловсон хүчний дутагдалд орох нь ээ. Харамсалтай нь энэ асуудал үндсэн бодлогын яаманд биш Боловсролын яамны харьяанд эрхлэх ажлын хүрээнд байгаа. Тэгэхээр Боловсролын сайд бодлогоо тайлбарлах байх.

Д.Амарбаясгалан: Пүрэвсүрэнгийн Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Тэгэхээр Мандухай гишүүний асуултад хариулъя. Түрүүнд Энхбаяр гишүүн бодитой нөхцөл байдлыг ярилаа. Гэхдээ энэ ямар нэгэн яамны харьяанаас бас болоод ч байгаа юм биш л дээ. Энэ яг энэ хөдөө аж ахуйн чиглэлээр мэргэжилтнээ бэлдэх энэ асуудал чинь өөрөө цаанаасаа бас цөөрч ирсэн ийм тал байгаа.

Тийм учраас Засгийн газраас эрэлттэй тэргүүлэх мэргэжлийг тодорхойлоод хөдөө аж ахуйн салбарын нарийн мэргэжлийг Боловсролын зээлийн сангаар дамжуулж, санхүүгийн хөшүүрэг хийж байна.

Түүний зэрэгцээ Хөдөө аж ахуйн их сургууль дээр жилдээ 2 элсэлт авч, хос мэргэжлээр сургах энэ ажлуудыг хийж байна. Сүүлийн жилүүдэд нэг жоохон нэмэгдэх хандлага гарч ирж байна. Цаашдаа бас энэ хөдөө аж ахуйн чиглэлээр ялангуяа ойн чиглэлээр, газар тариалангийн, малын эмч, зоо техникийн ийм чиглэлээр сайн бэлдэх учиртай гэж ингэж харж байгаа. Ер нь Хөдөө аж ахуйн сургуулийг бас ингэж урд нь ийш тийш нь нүүлгэ ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд гүйцээж хариулъя.

П.Наранбаяр: Тэгэхээрээ Хөдөө аж ахуйн сургуулийг 93, 4 оноос эхлээд л нүүлгээд л, нэг авчраад л ингээд байсан. Энэ болгон л элсэлтэд нь өөрөө ингээд сөргөөр нөлөөлж ирсэн юм байна лээ шүү дээ. Энэ удаад ХААИС-ийн харьяа 4 хүрээлэн өөрсдөө хүсэлтээ гаргаад, тэгээд Эдийн засаг, хөгжлийн яамны харьяанд очих ийм юм яригдаж байгаа.

Тэгэхээрээ салбар салбарын яамд өөрөө их, дээд сургуулиа ингээд менежмент хийгээд явна гэдэг боломжгүй зүйл л дээ. Энэ чинь Дээд боловсролын хуультай юм байхгүй юу даа. Харин энэ мэргэжилтнүүдийг бэлдэх энэ чиглэл дээр нь бид бас ХААИС-тайгаа хамтрах, энд энэ чиглэлээр дорвитой бодлого явуулах шаардлагатайг бас хүлээн зөвшөөрнө өө. Удирдах зөвлөл нь шинэчилж байна, ХААЯ-наас бүр 3 хүн оруулж ирж байна, төрийг төлөөлдөг 8 хүний 3 нь ХААЯ-наас орж ирж байгаа.

Тэгэхээр бодлого илүү ойртоно оо л гэж та харж болно. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууна.

Б.Батбаатар: Бид нар төсөв болон төсвийг дагалдан төсвийн төсөл орж ирж байгаатай холбогдуулан дагалдах хуулиудыг хэлэлцэж байна. Тэгээд нэг 4 жил суух, 4 жил төр барих, Засгийн газраа байгуулах эрхээ олж аваад сонгуульд ордог зүйлээ мартчихаад байна.

МАН дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувиас төсвийн зарлагыг хэтрүүлэхгүй гэсэн. АН төсвийн зарлагыг 20 хувиар танана гэсэн. ХҮН нам төсвийг тэлэхгүй гэсэн. Тэгэхэд өнөөдөр байгаа төсөв маань 35 их наяд буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37 хувь болж байна. Энэ маань тэгэхээр нөгөө иргэд, сонгогчдод амласан тэр зүйлээсээ ухардаг. Энэ төсвийн хууль батлагдсанаар мөрийн хөтөлбөрөө орхидог ийм зүйл үүсэж байна гэж хараад байгаа юм. Төсөв болон төсвийг дагалдаж орж ирж байгаа хуулийн зөрөөнүүд үүсэж байна. Төрийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлснээр тэр 7,3 их наядын татварын орлого чинь хэвээрээ хадгалагдаж чадах уу? Төсөв дээр бичигдсэн байгаа.

Мөн энэ төсвөөс санхүүжихээр 25 онд зоосон 4,1 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт байгаа. Тендерт шалгарсан ААН нэг 5, 10 хувь ч байдаг юм уу бага үнийн дүн санал болгож байж, юу тендерт шалгардаг хуульд ийм. Тэгэхээр тэр тэндээс нь харахад зүгээр 10 хувийн бага үнийн дүн өгөөд шалгарлаа гэж бодоод, 414 тэрбум төгрөгийн хэмнэлт гэх юм уу, нөөц үлдэнэ. Үүнийг өөр зүйл рүү оруулах тухай тийм

төсвийн төсөөлөл дээрээ юу бичиж тавих, дараагийн эрэмбийн тухайд, дараагийн төсвийн тодотголд оруулах тухай бодсон зүйл байдаг юм уу, үгүй юм уу.

Төсвийн орлого дээр алт, зэсийн үнийг хувьсах үнээр тооцдог. Алт, зэсийн үнэ энэ хувьсах үнээрээ орж ирлээ гэхэд юу, үнийн өсөлт үүсэж байгаа тохиолдолд тэрийгээ юунд зарцуулах вэ гэдэг дээр өмнөх төсөв болон одоо энэ цаашдаа барих зүйл дээрээ бодож байх юм байна уу. Хүүхдийн мөнгө, тэр ээжүүдийн мөнгө гээд л яригдаад байна. 2010, 2011 оны үед тэр ээжүүдийн мөнгийг санаачлаад энэ тэр үед ийм нийтлэлүүд гарчихсан л байдаг. Анхны санаачлагчдынх нь нэг.

Онцгой албан татварыг бид нар, би өөрийн бланк дээрээ Төсвийн байнгын хороо Даваасүрэн даргад төсвийн энэ төсөлд 53 зарчмын зөрөөтэй санал хураалгахаар өгсөн байгаа. Үүгээр бол онцгой албан татвар дээр нэмэлт онцгой албан татварыг нэмэгдүүлье. Эндээс 600 орчим тэрбум төгрөгийн нэмэлт орлого олох юм байна. Үүнийг тэр ээжүүдийн 50 мянга, хүүхдийн мөнгө рүү шилжүүлье гэдэг ийм байдлаар оруулсан байгаа. Төсвийн ажлын хэсэг болон Төсвийн байнгын хороо энэ 53 зарчмын зөрөөтэй саналыг бас хурлаараа хэлэлцүүлж, санал хураалгаж өгөөсэй гэж хүсэж байна. Миний тэр санал дээр төсвийн зарлагыг 1 их наяд 100 тэрбум төгрөгөөр хорогдуулахаар санал орсон байгаа.

Тэгэхээр энэ зүйлүүд дээр бид нар нэг жоохон анхаарч байхгүй бол хэдхэн сарын өмнө амлаж байсан, хэд хоногийн өмнө орон нутгийн сонгуулиар ч гэсэн ялгаагүй амлаж байсан зүйлүүдээсээ энэ төсвийн хууль тогтоомж, энэ төсөв өргөн барихдаа тэр бүх амлалтаасаа ухраад байна. Иргэний Зориг ногоон нам энэ амлалтаасаа хэлсэн ярьснаасаа ухрахгүй. Цаг зуурын зүйлд дагаж явахгүй, сөрөг хүчний үүргээ гүйцэтгэнэ гэсэн ийм л байдалд байгаа. Тэр зар ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан эхэлж хариулаад. нэмээд Төсвийн байнгын хорооны дарга Цэдэнпилийн Даваасүрэн гишүүн хариулья.

Б.Жавхлан: Батбаатар гишүүний асуултад хариулья. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн тоо хэмжээ, үүргийг багасгахын тулд хувийн хэвшлээ л дэмжих хэрэгтэй. Бид нар. Хувийн хэвшлийн үүрэг, дотоодын нийт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх хүчин чадлыг нь нэмэгдүүлэх хэрэгтэй. Түүний төлөө орж ирж байгаа л энэ одоо төсвийн бодлого гэж ойлгох хэрэгтэй. Бид нар татварын бодлогоор дэмжинэ, дэд бүтцүүдийг нь барьж өгнө, замыг нь барьж өгнө, эрчим хүчний хязгаарлалтаас нь гаргаж өгнө. Тэгж байж энэ дотоодын нийт бүтээгдэхүүн доторх төсвийн хэмжээ буурна. Бидэнд өөр сонголт байхгүй.

Харин урсгал зардлыг нь бууруулах гэж байна гээд төрийн үйл ажиллагааг хязгаарлаж болохгүй. Төрийн үйл ажиллагаа, дээрээс нь энэ олон хуулиар баталгаажихсан үйл ажиллагаа, урсгал зардал шаарддаг ийм зүйлүүд маш ихтэй болчихсон, бид нар. Түүн дээрээ их болгоомжтой байх хэрэгтэй. Хууль санаачлагч нар бүгдээрээ. Бүх субъектүүд.

Алт, зэсийн үнэ дээр алтны үнийг бид төсөв дээр нэг их авдаггүй юм байгаа юм шүү. Стратегийн, стратегийн гэдэг шалгуур байгаа. Өөрөөр хэлбэл дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувиас дээш давсан орлого бүрдүүлдэг түүхий эд гэхэд манай дээр бас хоёрхон л юм байдаг юм. Нүүрс, зэс гээд. Хувьсах үнэ гэж байхгүй. Тэнцвэржүүлсэн үнэ, зах зээлийн үнэ гэдэг 2, хоёрхон л үнэ байгаа, энэ хоёрынхоо багаар нь тооцож бид нар суурь орлогоо авдаг юм байгаа юм. Хэрвээ давсан

тохиолдолд Тогтворжуулалтын сандаа хийгээд, алдагдалд орвол түүгээрээ нөхдөг ийм хуулийн дүрэмтэй.

4,3 их наяд төгрөгөөс 1,7 их наяд төгрөг нь хөрөнгө оруулалтын зардал байгаа. Энэ нь саяын, саяын асуусан тэр л яг хувийн хэвшил рүүгээ чиглэсэн замыг нь барьж өгч байна. Эрчим хүчийг нь тэлж өгч байгаа. Эх үүсвэрүүдээ нэмэх энэ рүүгээ чиглэсэн л ийм л хөрөнгө оруулалтууд байгаа. Нэмэгдэж байгаа нь ч тэр, шинээр нь ч тэр. Үргэлжилж байгаа нь энэ дээр, үргэлжилж байгаа нь мөн энэ дотроо багтчихсан ингээд явж байгаа. Хөрөнгө оруулалтын зардлуудыг төсөв батлагдсанаас хойш урсгал зардал руу ч юм уу өөр тийшээ шилжүүлэх боломж байхгүй. Одоо оруулж ирсэн төсвийн хүрээнд бид Их Хурал дээрээ л хэлэлцээд өөрчлөх зүйлүүд байвал эндээ л ярилцах нь хуулийн боломжтой зүйлүүд юм.

Д.Амарбаясгалан: Даваасүрэн дарга нэмж хариулъя.

Ц.Даваасүрэн: Тийм, гишүүдээс ирсэн байгаа саналуудыг бид нар ажлын хэсэг, Байнгын хороогоор бүгдээрээ яг дэгийнхээ дагуу хэлэлцээд ингээд явна. Тэгэхдээ шинэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр, Төсвийн тухай хуулиар, Засгийн газраас өгчихсөн байгаа зардлыг нэмэгдүүлэх боломжгүй болчихсон юм.

Тэгэхээр хэрвээ зардлын асуудал ингээд яавал, заавал өөр нэг зардлыг ачаад нөгөө зардлыг оруулдаг ийм юм болсон. Тэгэхдээ би зүгээр гишүүд, улс төрчдөдөө нэг зүйлийг уриалмаар байгаа юм. Би ингээд гадаад орны бусад орнуудад болж байгаа сонгуулийг харахаар улс төрчид нь ажлын байр амлаж байгаа юм. Иргэд нь ажлын байр нэхэж байгаа юм. Манайд халамж. Улс төрч нь халамж. Би тэр эхчүүдэд өгье гэдгийг чинь буруушаахгүй байна л даа. Олон хүүхэдтэй тул өгөх л ёстой байх. Тэр баян айлын хүүхдүүдэд, тэр боломжтой айлын хүүхдүүдэд мөнгө өгч яах гээд байгаа юм. Ялгадас үйлдвэрлэж яах гээд байгаа юм, нүүрснийхээ мөнгөөр. Өнөөдөр 15 тэр ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулах уу? Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: 15 тэрбум доллар болж байгаа 9 чинь ганцаараа нүүрс. Нүүрс зогсвол бид нар байхгүй. Тийм учраас орж ирж байгаа нүүрсний мөнгөөрөө бид нар бүтээгдэхүүн, баялаг бүтээдэг болох хэрэгтэй шүү дээ. Улс төрчид нь өөрсдөө ингээд л тэгж өгье, ингэж өгье гээд л байхаар чинь ард түмэн чинь авъя гэхээс өөр яах юм бэ. Бид чинь энэ улс орныг чиглүүлэх гэж энд сууж байгаа болохоос биш нэг суудлын төлөө суугаад байгаа улс биш шүү дээ. Яг ийм сэтгүүр байвал Монгол орон хэзээ ч хөгжихгүй. Халамж яриад л байна. Орж ирсэн мөнгөө ялгадас болгоод л байна, ялгадас болгоод л байна. Нэг үйлдвэр босгох хэрэгтэй, баялаг бүтээх хэрэгтэй. Тэгэхгүй ингээд л уралдаад л улс төрчид нь, намууд нь халамж яриад байхаар чинь энэ улс орноо шатааж байгаа байхгүй юу. Энэ гаднаас олж ирж байгаа нэг хэдэн төгрөгөө бүгдийг нь шатааж байгаа байхгүй юу. Хэдэн ТЭЦ шатааж байна, хэчнээн арьс ширний үйлдвэр идэж байна, жилдээ гэж бид нар боддог байх хэрэгтэй шүү дээ. Таалагдах гээд л нэг тийм мөнгө өгнө, ийм мөнгө өгнө гээд л ингээд л уралдчих юм. Энэ байж болохгүй зүйл шүү. Ингэж улс орноороо ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн тодруулж асууя.

Б.Батбаатар: 1 дүгээрт нь, урсгал зардлыг бууруулах тухай огт хэлээгүй. Төсвийн хөрөнгө оруулалтын зарлага тэр тал дээр ярьсан.

2-т нь, 7,3 их наядын татварын орлого маань хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлснээр хэвээрээ хадгалагдах уу гэсэн.

3 дугаарт нь, өмнөх Засгийн газрын мөрийн хөтөлбөр батлах үед байр сууриа илэрхийлж байсан. Засгийн газрын өмчид ашгийн төлөөх УҮГ байхгүй байя. Энэ хулгай иддэг төсөвтэй байж болмооргүй байна л гээд жишээ хэлээд байгаа юм.

Авлига авдаг, хулгай хийдэг, төсвийн ерөнхийлөн захирагч нар нь улс төрийн намуудын төлөөлөл нь оччихоод хулгай хийгээд байгаа хэдэн их наядаар нь, нүүрсний төлөөллүүд нь босож ирээд янз бүрийн улс төр босгож ирдэг. Ийм зүйлээс зайлсхийе л гэж байгаа юм. Түүнээс биш ажлын байрыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруул ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулт өгье.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж мэдээлэл өгье. Орлого буурахгүй ээ. Ирэх жил дээр ямар ч нөлөөлөл гарахгүй. Цаашдаа энэ чинь ирээдүйд хийгдэх боловсруулах чиглэлийн болон тэргүүлэх чиглэлийн бүтээн байгуулалтын ажлууд, төслүүд хэрэгжинэ. Тэндээс татвар төлөлтийн харин суурь нэмэгдэнэ, бас нөгөө талаараа. Ирээдүйд орлого нэмэгдэнэ. Түүнээс биш 25 оны төсөв дээр орлого бууруулах ямар нэг нөлөөлөл байхгүй, эрсдэл байхгүй гэсэн үг. Энэ татварын зохицуулалтаас үүдсэн тийм эрсдэл байхгүй.

Д.Амарбаясгалан: Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууна. Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

М.Бадамсүрэн: 1 дүгээрт, энэ Үндэсний баялгийн сан гээд Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ өргөн мэдүүлж батлуулсан. Шинэ хоршоо, уламжлалт МАА-д уур амьсгалын өөрчлөлтөд тулгарсан хуультай холбоотой Амарбаясгалан дарга батлуулсан. Тэгээд би юу гэж хэлэх гээд байна гэхээр, сайд нар нэг ийм салбартаа томоохон, тодорхой, ойлгомжтой, хэрэгжихүйц, механизм нь хөрөнгө оруулалт нь тодорхой ийм бодлогуудыг гаргамаар байна. Яг үнэндээ зарим сайд нарын хувьд тэгээд л нэг тийм нэг урсгалаараа яваад байгаа зүйл харагдаад байгаа. Үүнийг би хэлье гэж бодож байна. Жишээлбэл, энэ барилгын тухайд байна. Орон сууц нэмэгдүүлнэ л гээд яриад байгаа. Яг үнэндээ үүнийг орон сууцын хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд юунаас болж үнэ нь нэмэгдээд байгаа юм, яагаад нийлүүлэлт бага байгаа юм гэдгийг яг зөв оношилж чадаж байгаа юм уу, ер нь. Эрэлт их, нийлүүлэлт бага байгаагаас болоод ингэж байна гэж байгаа. Гэхдээ суурь шалтгаан нь энэ 1 дүгээрт, энэ барилга барих, орон сууц барих компаниудын чинь газар чинь өндөр үнэлгээтэй байна шүү дээ. Тэгээд үүнийг ер нь яаж шийдэх юм? Хуульд өөрчлөлт оруулах юм уу, өөр бодлого гаргах юм уу.

2-т, яг үнэндээ барилгын компаниудад тулгамдаж байгаа асуудал бол өндөр хүүтэй зээл авч байгаа шүү дээ. Тэгээд үүний эцсийн үр дүн нь иргэд дээрээ очдог. Метр квадратын үнэ хяналтгүйгээр маш хурдтай нэмэгдэж байгаа. Тэгэхээр жирийн иргэд, энгийн өрх айл, багш, эмч нар гээд энэ хүмүүс чинь яаж орон сууцтай болох юм. Тэгээд энэ дээр ер нь ямар бодлого гаргах юм бэ? Үүнийг барилгын сайдаас асууя.

2-т нь, энэ жижиг, дунд үйлдвэрлэл, аялал жуулчлал, эмэгтэй бизнес эрхлэгчид, энэ багш нарын сургалт эрхлэх гээд энэ зүйлүүд дээр яаж дэмжлэг

үзүүлэх гэж байгаа юм бэ? Ямар бодлогын зохицуулалт хийх юм бэ? Энэ талаар хариуцсан сайд нар ер нь ямар бодлого гаргах гэж байгаа юм бэ.

3-д нь, энэ НӨАТ-ын босгыг 50 сая төгрөг байгаа. Үүнээс чинь хойш их олон жил өнгөрлөө. Тэгээд 400 сая төгрөг болгоё гэдэг зорилтыг энэ сонгуулиар зөндөө дэвшүүлсэн шүү дээ. Тэгээд үүнийг ер нь хэзээ яаж өөрчлөх юм бэ?

Дараагийнх нь энэ ААН-ийн энэ орлогын албан татварын тухай хууль байна. Энэ бүсчилсэн Бямбацогт гишүүн эд нар энэ ингээд бүсчлээд бас тогтоож байсныг би санаж байна. Тэгээд үүнээс энэ орж ирж байгаа төсөл нь ямар ялгаатай юм бэ?

Дараагийнх нь энэ Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоолын төсөл дээр санал байна. 2 юм байна, энд нь. 1 дүгээрт нь, төрийн болон орон нутгийн өмчийн харилцааны талаар, 2 дахь нь бүсчилсэн хөгжлийг дэмжих талаар. Тэгээд бүсчилсэн хөгжлийг дэмжих хэсэг дээр санал оруулахтай холбоотойгоор энэ дээр бас асуулт байна. Өөрөөр хэлбэл ингээд бид нар чинь тийм баян орон биш шүү дээ, байгаа юмаа ингээд үр дүнтэй, хэрэгцээтэй зүйлдээ бид нар зармаар байна. Өөрөөр хэлбэл орон нутагт, энэ төрд, хуучин энэ барилгууд зөндөө гарч байгаа шүү дээ. Шинэ, шинэ гоё, гоё оффистой болоод л байгаа, яг үнэндээ, шил толь шиг л. Тэгээд энэ хуучин барилгуудаа актлагдсан байгаа зарим зүйлийг нь нөгөө засаж сэлбээд, эсвэл актлагдаагүй байгааг нь ингээд хувьчлахгүйгээр эсвэл ямар нэгэн давуу байдлаар үүнийг олгохгүйгээр үүнийг энэ жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, энэ багш нарын секц, дугуйланд өндөр төлбөртэй сургалт явуулж байгаа хүүхдүүдэд зааж сургаж байгаа энэ зүйл дээр нь ингээд зөв зохистой ашиглах энэ бодлогыг хэрэгжүүлж болохгүй юу? Бид орон нутагт үүнийг хэрэгжүүлээд их үр дүнтэй байгаад байгаа юм.

Тэгээд ийм зүйл ерөөсөө харагдахгүй байгаад байгаа юм. Тэгээд энэ дээр энэ Засгийн газрын чиглэл өгөх тогтоолын төслийг боловсруулсан субъектээс нь ийм боломж байна уу гэдгийг би бас асууя гэж бодож байгаа юм. Ер нь тэгээд дүгнэж хэлэх юм бол эцсийн дүндээ энэ төрийн бодлого гэдэг чинь яг өрх айл, эгэл жирийн иргэд яаж орлого олж, яаж амьжиргаагаа дээшлүүлж, энэ улс орондоо бага хэмжээний ч гэсэн татвар хураамж төлж, иргэн баян бол улс баян гэдэг шиг нийтээрээ явах юм бэ? Энэ яг иргэд рүү чиглэсэн хөнгөлөлттэй зээлийн бодлого төрөөс ер нь яаж үүнийг дэмжих юм бэ? Энэ Шинэ хоршоо хөдөлгөөн шиг ийм тодорхой бодлогуудыг салбар салбар дээрээ сайд нар гарга л даа. Энэ ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батлан хамгаалахын сайд Сандагийн Бямбацогт эхлээд хариулт өгнө.

С.Бямбацогт: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Энэ ААНОАТ, Бямбацогт нарын санаачилсан ААНОАТ-ын хөнгөлөлтөөс ямар ялгаатай юм бэ гэж бас асууж байна. Тэгэхээр энэ дээр юу яаж байгаа юм. 2017 онд миний бие болон бас бусад гишүүд хамтарч санаачлаад, Улаанбаатараас 500-1000 км алслагдсан аймагт үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдэд ААНОАТ-ыг 50 хувь хөнгөлөх буюу 5 хувь болгосон. 1000-аас дээш километрт үйл ажиллагаа явуулж байгаа алслагдсан аймгуудад үйл ажиллагаа явуулж байгаа, сумд үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийн орлогын албан татварыг 90 хувь хөнгөлөх буюу 1 хувь болгосон. Ийм хууль батлагдсан байгаа. Энэ хууль өнөөдөр мөрдөгдөж байгаа. Яагаад ингэж баталсан бэ гэхээр бид нар тийм үү. Улаанбаатар хотоос алслагдах тусмаа ард иргэдийн бараа бүтээгдэхүүний үнэ өртөг нэмэгддэг ээ. Бензин шатахуун өндөр

үнэтэй, гурил будаа өндөр үнэтэй, даавуу, даалимба нь өндөр үнэтэй, тог цахилгаан өндөр үнэтэй. Нөгөө талд олж байгаа орлого нь бага, орлого багатай. Хүнсний ногоо тарьдаг бол тэр нь орлого багатай байдаг. Мал махаа зардаг бол орлого багатай. Ноос, ноолуур, арьс шир нь бага, хямд үнэтэй байдаг.

Ийм учраас орлогыг нь нэмэгдүүлэх, зардлыг нь бууруулах зорилгоор, мөн бас Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, орон нутагт ААН-ийг бас үйл ажиллагаа явуулахад бололцоо, боломжийг нь дэмжих зорилгоор ийм хууль баталсан юм. Энэ хууль үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, уул уурхайгаас бусад салбарт буюу худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ бүгдэд нь үйлчилж байгаа. Засгийн газраас сая өргөн барьсан энэ хууль болохоор үндсэндээ боловсруулах үйлдвэр, үйлдвэрлэлээ илүү дэмжье, энд тэр орон зай хязгаар хамаа байхгүй, 500-1000, 1000-аас дээш гэж алслахад хамаагүй, ерөөсөө л боловсруулах үйлдвэр, импортыг орлох, экспортыг дэмжих чиглэлд боловсруулах үйлдвэрлэл эрхэлж байгаа ийм хөнгөлөлт эдлүүлье гэсэн ийм агуулгаараа ялгаатай юм. Ийм байдлаар.

Тийм болохоор үндсэндээ цааш цаашдаа үндсэндээ алслагдсан бүс нутагт үйл ажиллагаа явуулж байгаа бол худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ бүхий л салбарт 1 хувийн татвар төлнө. Улаанбаатар хоттой ойролцоо үйл ажиллагаа явуулж байгаа боловсрох үйлдвэрүүд 1 хувийн татвар төлнө. Худалдаа, үйлчилгээ бол 10 хувийн татвараа төлнө өө. Ийм бас ялгаатай юм шүү гэдгийг бас тайлбарлаад хэлчихье. Энэ бол өнгөрсөн бас 8 жилийн хугацаанд энэ Засгийн газар, Улсын Их Хурлын хийж хэрэгжүүлсэн бас нэг томоохон энэ алслагдсан бүс нутгийг болон бүсчилсэн хөгжлийг дэмжих, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, түгжрэлийг буруулахад чиглэсэн бас нэлээн томхон бодлого байж байгаа.

Цаашдаа яг үүнтэй адилхан бид нар харин иргэдийн, ААН биш хүн амын орлогын албан татварыг бас алслагдсан бүс нутагт энэ Улаанбаатараас холдох тусмаа бага татвар төлдөг болох энэ тогтолцоог бий болгохын төлөө бид бас анхаарч ажиллах ёстой. Өөрөөр хэлэх юм бол тэнд ч бас амьдарч байгаа ард иргэд чинь хүн амын орлогын албан татвар Улаанбаатарт ч адилхан, Баян-Өлгийд ч адилхан, Дорнодод ч адилхан 10 хувь төлөөд байгаа. Тэгвэл Дорнодод 1 хувь төлдөг, тэр Баян-Өлгийд 1 хувь төлдөг ийм болчих юм бол тэр алслагдсан бүс нутагт чинь ард иргэдийн орлого нэмэгдэнэ, зардал буурна.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хороон дарга, ажлын хэсгийн дарга Даваасүрэн гишүүн хариулъя.

Ц.Даваасүрэн: Тийм, сая Бямбацогт гишүүн ч хэллээ. Зүгээр энэ орж ирж байгаа энэ бүсийн хөгжлийг дэмжсэн энэ татварын асуудал чинь 8 жил юу хийсэн юм гэж түрүүн асуугаад байх шиг байна лээ. 8 жил энэ чинь бас түрүүн хэрэгжсэн гэдэг талаар Бямбацогт гишүүн хэллээ шүү дээ. Хэрэгжсэн юм. Тэгээд тодорхой үр дүн гарсан учраас бусад бүс нутгуудыг хамруулахаар ингэж оруулж ирж байгаа юм.

Тэгэхээр өмнө нь 1000 км-ээс дээш, тэгээд баруун бүсэд өөрөөр хэлэх юм бол энэ татварын хууль хэрэгжсэн гэсэн үг. Үр дүн нь гарсан учраас одоо оруулж ирж байгаа юм.

Тэр жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийн асуудал дээр Бадамсүрэн гишүүн ярьж байна. Ажлын хэсэг дээр бас өөрөө гишүүн байгаа ярьж байгаа. Тийм учраас таны тэр асуултыг зүгээр ЖДҮ гэхгүйгээр бид нар уул уурхайн бус

бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжихэд урамшуулал олгох чиглэлээр Сангийн сайд, Эдийн засгийн сайдтай ярьж байна. Ийм хөрөнгө тусгахаар.

Тийм учраас энэ асуудал тодорхой хэмжээгээр шийдэгдэнэ гэж ойлгож болно.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулт өгье.

Б.Жавхлан: Бадамсүрэн гишүүний асуултад хариулаад ирье. НӨАТ-ын босготой холбоотой хэсэг дээр нь. НӨАТ-ын босгыг нэмэгдүүлэх энэ асуудлаар мөрийн хөтөлбөрт орсон байгаа. Мөрийн хөтөлбөр маань 4 жилийн хугацаанд хэрэгжинэ гэж ойлгож байгаа. Бидэнд хугацаа байна. Энэ дээр бас их судалгаатай хандахгүй бол бас болохгүй асуудал. Энэ өөрөө 2 талтай юм байгаа юм. НӨАТ-ын босгыг нэмчихээр ийм сөрөг үр дүн гарна. Юу вэ гэхээр, том компаниуд жишээ нь бэлтгэн нийлүүлдэг бусад жижиг компаниудаасаа заавал НӨАТ шаарддаг. Ингээд компаниа жижиглээд 400-аас ч юм уу, доош оруулаад НӨАТ төлөгч биш болоод явчихаар энэ эдийн засгийнхаа интеграцчилаасаа ингээд бүр зах зээлээсээ шахагдах ийм өндөр эрсдэл байгаад байдаг юм.

Тийм учраас үүнийг бид нар маш сайн судалж байж, энэ дээр хөдөлгөөн хийх ёстой юм байгаа юм. Яах вэ, дундын хувилбар 400 саяас дээш заавал бүртгэгдэх ёстой. 50-400-ийн хооронд сайн дураараа тэнд бүртгүүлж болно ч гэдэг юм уу, тэгэхээр. Тийм учраас үүнийг ойрын хугацаанд нэг тийш нь болгоно. Гэхдээ энэ дээр маш сайн судалгаа ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж. Батсуурь сайд нэмж хариулах уу? Орон сууцжуулалтын сайд Батсуурь сайд нэмж хариулъя.

Ж.Батсуурь: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр аливаа зүйлийн үнэ бол эрэлт нийлүүлэлттэй л холбоотой. Тийм болохоор үнэ бууруулъя гэвэл нийлүүлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг 1 дүгээрт, авах ёстой. Бидний хувьд эх үүсвэрээ, ипотекийн зээлийн эх үүсвэрийг энэ жил 2 дахин илүү нэмэгдүүлж байгаа. Тийм учраас бас үнийг тогтвортой барих боломжтой.

Дээр нь түрээсийн орон сууц, түрээслэх замаар эзэмших, түрээслэх дээр нь стандартын шаардлага хангасан амины орон сууцад ипотекийн зээл олгох энэ зүйлийг эрх зүйн орчныг бүрдүүлэхээр асууд ярьж байна.

Мөн та газрын асуудал ярьж байна. Газрыг бас орон нутагт зөв менежментээр зөв олгох юм бол орон сууцын үнэд нөлөөлөхгүй байх боломжтой. ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ.

Нэр өгсөн дарааллын дагуу Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн үг хэлнэ. 1 дүгээр индэр дээрээс үг хэлнэ. Бадамсүрэн гишүүний үг дэмжсэн гэдгээр байр сууриа хэлж байгаа юм байна.

Дараачийн жагсаалт байна уу? Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн 1 дүгээр индэр дээрээс үг хэлнэ.

С.Эрдэнэбат: Энэ дагаж гарч байгаа хуулиудтай холбоотой сангууд бас шууд хамааралтай. Тийм учраас би түрүүнийхээ л зүйлийг хэлье. Төсөв, төсвийн дагаж гарч байгаа хуулиуд болон төсөв дээр бид нар суурь цалингаа нэмэх, нэмэхгүй гэдэг ийм маргаантай байна. Хуулиараа бол нэмээд шийдчихсэн байж байгаа. Энэ чинь өөрөө цаанаа Нийгмийн даатгал, ЭМД-ын сан руу бас нэмэр болж ордог. Ийм шууд хамааралтай асуудал байж байгаа.

Тийм учраас Сангийн сайд минь энэ асуудал дээр та анхаарч Засгийн газраараа бас энэ төсөл дээрээ хөдөлмөрийнхөө хөлснийхөө доод хэмжээний асуудлыг шийдэж оруулж ирээч ээ. Энэ нь дагаад нийгмийн даатгал болон ЭМД-ын санд төрөөс хариуцах иргэдийн, нэг талдаа төрийн төсөвт ачаалал үзүүлээд байгаа мэт болов чиг нөгөө талдаа эрүүл мэндийн сан чинь дутаад, хүндрэлтэй байгаа дээр нэмэр болж байгаа юм.

Өчигдөр бид нар төсвийн байнгын, төсвийн асуудал дээр Эрүүл мэндийн сан дээрээ бас нэмээд нэг хөрөнгө оруулалтуудаас татаад, Эрүүл мэндийн сан дээрээ нэмээд тавья гэсэн, дэмжигдээгүй. Тэгэхээр энэ талд нь зөвхөн нэг цалин нэмэх гэж байгаа гэдэг битгий та энэ талаас нь хараарай. Хуулиа биелүүлээд энэ тал дээр харж үзээч гэдгийг хэлмээр.

Харин энэ хөнгөлөлт үзүүлэх энэ асуудлыг дотор нь юуг нь яах вэ, ийх вэ гэдэг байдлаараа ярилцаад, би бол хэлэлцэх нь зөв өө. Алслагдсан бүс нутгийн хөгжлийнхөө хөнгөлөлтүүдийг нарийвчилж, хуульд нарийвчилж тусган шийдэх нь зөв өө гэдэг ийм байр суурийг хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн үг хэлнэ. 2 дугаар индэр дээрээс.

Б.Жаргалан: Шинэ парламент анхныхаа төсвийн тухай хуулийг хэлэлцэж байна. Түүхэн дэх анхны 126 гишүүнтэй Улсын Их Хурал өнөөдөр мөн анх удаа 35,8 их наяд төгрөгийн төсөв батлах гэж байна. Улсын Их Хурал дээр төсвийн хэлэлцүүлэг тун хөнгөн, хуумгай байдалтай явагдаж байна. Тиймээс гишүүддээ эдийн засгаа том зургаар нь хараад, ул суурьтай шийдвэр гаргаасай гэж хүсэх байна.

Төсөв дагалдуулж янз бүрийн хуулийн төсөл оруулж ирдэг практик газар авсныг өмнө нь ээлжит бус чуулганаар хэлж байсан. Өмнөх парламентын үед тухайлах юм бол 2023 оны төсвийг дагуулж 102 хуулийн төсөл оруулж ирж байжээ. Сая ээлжит бус чуулганаар удаа дараа зарчмын зөрөөтэй санал тавьсны хүчинд төсвийн тодотгол дагуулж оруулж ирсэн зарим нэг хуулийн төслүүдийг татаж авсан байдаг. Гэтэл энэ удаад бас дахиад л улсын төсвийн тухай хуулийг дагалдуулаад 5 хуулийн төсөл, 3 Улсын Их Хурлын тогтоолын төсөл оруулж иржээ.

1 дүгээрт, ингэж яаруу сандруу батлахаар оруулж ирж байгаа хууль дотор улсын татварын бодлого явж байгаа нь зохисгүй гэж үзэж байгаа тул дэмжихгүй байгаа юм.

Сүүлийн жилүүдэд нийгэм даяар яригдаж байгаа давхар стандарт Монгол Улсын татварын бодлогод орж ирж байгаа нь анхаарал татаж байна. 2025 оны

улсын төсвийг дагалдуулж ААНОАТ-ын тухай хуульд Засгийн газраас тогтоосон бүсийн хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үйл ажиллагаанаас олох орлогод ноогдуулах албан татварыг эхний 5 жилд 90 хувь хөнгөлөх тухай өөрчлөлт оруулах хуулийн төсөл орж ирсэн. Өөрөөр хэлбэл Засгийн газар буюу дарга нарын шийдвэр буюу үзэмжээр зарим ААН-үүд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх юм байна.

Харин энэхүү хөнгөлөлт, чөлөөлөлтийн эдэлж чадахгүй байгаа ААН-үүдийн өрсөлдөх чадвар суларна. Бизнесийн орчныг сайжруулна гэдэг зах зээлийн өрсөлдөөнт орчныг бий болгож, ААН-үүдэд эрх тэгш үйлчлэх татварын бодлого, хэн нэгэн тоглогчдод давуу эрх олгодоггүй байхыг хэлнэ. Хувийн хэвшлээ дэмжинэ, бизнесээ дэмжинэ гэдэг бол давхар стандартгүй, шударга өрсөлдөөнт орчныг бүрдүүлэх тухай асуудал болохоос биш хэн нэгэн ААН-д давуу эрх олгох тухай ойлголт биш юм.

Тиймээс төсвийг дагалдуулж оруулж ирж байгаа Татварын тухай хуулийн төслүүдийг дэмжихгүй байна.

2 дугаарт, энэхүү Засгийн газар гадаад зах зээлийн хувьд тун таатай нөхцөлд ажиллаж ирсэн. Бид 2024 онд 80 орчим сая тонн нүүрс экспортолно. 1 тонн нүүрсний дундаж үнэ 115 ам.доллар гэж тооцож байгаа. Зэсийн үнэ тонн тутамд 9500 ам.доллар байгаа. 1 унз алтны үнэ 2200 ам доллар давсан байна. Энэ онд зөвхөн нүүрс, зэсийн экспортоос Монгол Улс 12 тэрбум ам.долларын орлого олно оо.

Гэтэл өнгөрсөн 8 жилд Засгийн газрын өр огт буурсангүй. Харин ч нэмэгдсэн. 2024 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар Монгол Улсын Засгийн газрын өр 29 их наяд 742 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. 8 жилийн өмнө буюу 2016 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар Монгол Улсын Засгийн газрын өр 16 их наяд 612,5 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан. Гадаад зах зээлийн энэхүү таатай мөчлөгийг ашиглаж, Засгийн газрын өрийг бууруулах замаар макро эдийн засгийн үзүүлэлтүүдээ сайжруулах, улмаар гадаад, дотоодын зах зээлээс илүү таатай нөхцөлөөр хөрөнгө, мөнгө босгож, хөрөнгө оруулалт татах боломжийг эрэлхийлэх нь чухал байна. Гэвч 2025 оны төсөвт Засгийн газрын өрийг дорвитой бууруулах тооцоо төлөвлөгөө тусгагдсангүй. Харин ч 2026 оны 4 дүгээр сард эргэн төлөгдөх хуваарьтай Номад бондын төлбөр болох 578 сая ам.долларыг дахин санхүүжүүлэх буюу шинээр зээл авч эргэн төлөх буюу урд хормойгоороо хойд хормойгоо нөхөх тухай асуудлыг оруулж иржээ. Ингэхдээ Улсын Их Хурлаас Засгийн газарт үнэт цаас гаргах эрх олгох тухай тогтоолын төслийг мөн улсын төсвийг дагалдуулж оруулж ирж байна.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн 2 дугаар индэр дээрээс үг хэлнэ.

Б.Батбаатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Өнөөдөр бид нар 2025 оны төсвийн тухай хуулийг дагалдаж орж ирж байгаа хуулийн төслүүдийг хэлэлцэж байна. Бид нарын зорилго бол ерөөсөө л иргэд маань эрүүл энх, орлоготой, дундаж чинээлэг давхаргатай ийм улс орныг иргэдийн аж амьдрал сайжирсан, аз жаргалтай амьдарч болох Монгол Улсдаа туурга тусгаар улс орондоо эзэн болж чадах тэр боломжийг бүрдүүлэхийн төлөө бид нарын бүх ажилд чиглэх ёстой юм. Төсөв байна уу, хууль байна уу, бодлого байна уу, тогтоол шийдвэр байна уу. Бид нарын алхаж байгаа, хийж байгаа үг авиа болгон тийшээ л чиглэх ёстой. Бусад зүйл дараагийн асуудал юм байгаа юм.

Энэ улс орон туурга тусгаар, энэ улс орон аюулгүй энх тайван байх нь иргэдийг эх орондоо эзэн байх эхнийх нь үндсэн нөхцөл болно. Дотоодын, асуулт асуухаар ингээд хариулж байгаа зүйлтэй нь уг нь санал нийлээд байгаа юм. Дотоодын нийт бүтээгдэхүүнээ өсгөөд, тэрнийхээ 20, 25 хувиас хэтрэхгүйгээр төсвийн зарлагатай байж байвал бас болж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөөс нь давсан өсөлттэйгөөр төсвийн зарлага нэмэгдээд, өнөөдөр дотоодын нийт бүтээгдэхүүний 37 хувь дээр ирж батлагдаж байгаа нь тийм таатай үзүүлэлт биш ээ.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтүүд ярьж байна. Тэр хөнгөлөлт, чөлөөлөлтүүдээ Засгийн газрын түвшинд хийх тухай ярьж байна. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт байхыг дэмжинэ. Гэхдээ энэ татварын хөнгөлөлт, чөлөөлөлтүүд өнгөрсөн цаг хугацаан дотор томоохон цөөхөн хэдэн банк, санхүү, томоохон компаниуд дээр л очиж хуваарилагдаж байна. Тэд татвараас чөлөөлөгдөж байна. Дундаж анги, бизнес эрхлэх гэж, осгож эхэлж байгаа старт ап түвшинд ажиллаж байгаа өрх гэрээ, эргэн тойрноо босгох гэж зүтгэж байгаа тэр хэсэгт энэ татварын хөнгөлөлт, чөлөөлөлт мэдрэгдэхгүй байна. Тэндээ татвар нь татварын хөнгөлөлт, чөлөөлөөд татварын зөв бодлого нь очиж суугдахгүй байна. Том компаниудын татвар чөлөөлөлтөөр л том компаниудын монопол, олигарх байдал улам нэмэгдэж байна. Бүх төрлийн бизнес рүү томоохон компаниуд орж байна. Жижиг, дунд үйлдвэрлэгч нар тухайн салбар дээрээ ажил тогтож чадах тэр эх үүсвэр нөөц боломжгүй болоод байна.

Тийм учраас Засгийн газар бизнес эрхлэх зүйлээс гараа татах ёстой, бодлогоо татаж авах ёстой. Засгийн газар татвараа аваад, үйл ажиллагаагаа явуулаад, халамж хэрэгтэйд нь халамжаа, нийгмийн тогтвортой байдал, аюулгүй байдлыг хангах хэсэгтээ тэр татварын бодлогоор орж ирсэн хөрөнгө, санхүүгээ захиран зарцуулдаг тэр чиглэл рүүгээ ажиллах хэрэгтэй. Засгийн газрын бизнест оролцож байгаа оролцоогоор энэ жижиг, дунд үйлдвэрлэл, дундаж давхарга Монголд нэмэгдэж байна уу гэдэг дээр анхаарах ёстой. Дотоодын нийт бүтээгдэхүүн тоон үзүүлэлтээрээ өсөөд байдаг. Баян, ядуугийн ялгаа холдоод байдаг. Дундаж давхарга гэдэг зүйл маань энэ улс оронд эзлэх хувь нь багасаад байна. Үүнийг бид нар төсвийн бодлого дээрээ анхаарч, харж байхгүй бол болохгүй ээ.

Өнөөдөр Улсын Их Хурал бол болон улс төрийн намууд дээр төсөв болон бусад зүйл дээр бодлого гаргахдаа өнгөрсөн цаг хугацаанд явсныг нь анзаараад, анхаараад байхад Монголын банк, санхүүгийн байгууллагууд юм уу, томоохон компаниудын бодлого төрийн бодлого болж хувирчхаад байна гэж харагдаад байгаа юм. Үүнийг засахын тулд бид нар төсвөөсөө эхлэх хэрэгтэй.

Тийм учраас дэмжээгүй байр сууриа илэрхийлж, үг хэллээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Ганзориг гишүүн үг хэлнэ. 2 дугаар индэр дээрээс.

П.Ганзориг: Бүсчилсэн хөгжлийн бас бодлогодоо нийцүүлээд ААНОАТ болон гаалийн татварт бас хөнгөлөлт, чөлөөлөлтийн ийм бодлогын хөнгөлөлт, чөлөөлөлт оруулж ирж байгааг дэмжиж байгаа. Гэхдээ энэ хөнгөлөлт, чөлөөлөлтийг бас эдлүүлэхдээ яг ямар чиглэлийн төсөл, хөтөлбөрт, ямар чиглэлийн боловсруулах үйлдвэрт үзүүлэх юм бэ гэдгээ бас энэ хуулийнхаа төсөл дээр тодорхой заах шаардлагатай байна. Ер нь Улсын Их Хурлаас энэ бодлогоо гаргаад явах ёстой. Харин Засгийн газар энэ бодлогынх нь хүрээнд хэрэгжүүлээд хийгээд явах ёстой.

Тийм болохоор энэ яах вэ, энэ татварын ямар төслүүдийг татварын хөнгөлөлт үзүүлэх вэ гэдгийг Засгийн газар шилжүүлж байгаа асуудлуудыг бас тодотгож, тодорхой болгож энэ хуулийн төсөлд тусгах шаардлагатай.

Тэгээд ер нь улс орны хөгжил, эдийн засгийн хөгжил ярих юм бол хувийн хэвшил, баялаг бүтээгчдээ дэмжиж байж л явна. Тийм болохоор цаашдаа энэ хувийн хэвшлийн хамгийн том дарамт болж байгаа НӨАТ-ын татвар, НДШ-ийн татварын бас тодорхой хэмжээнд бууруулах энэ чиглэлд бас бодлогоо чиглүүлж ажиллах ёстой гэсэн ийм байр суурьтай байна.

2-т, энэ Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан гэж байж байгаа. Одоо энэ төсвийн хууль дагаад төсөвтэй холбоотой маш олон сангууд орж ирж байгаа. Ялангуяа хөдөө аж ахуйн салбарт 500 гаруй тэрбум төгрөгийн хөнгөлөлт, чөлөөлөлт, хүүгийн зөрөө өгөхөөр. Гэтэл Жижиг, дунд үйлдвэрлэлийн сан төсвөөс нэмэлт эх үүсвэр авч чадахгүй байна. Өөрийнхөө эргэн төлөлтөөр явж байгаа.

Тэгэхээр энэ бол яг энэ бодитой жижиг, дунд бизнесүүдийг дэмжих ийм чухал сан учраас цаашдаа бас энэ Жижиг, дунд үйлдвэрийн сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх чиглэлд бас анхаарч ажиллах ёстой гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж, үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалтыг явуулна.

Санал хураалт.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд, 3. “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай”, 4. “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, 5. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор ...

Хууль тус бүрээр үү. Тамгын газар Дондогмаа дарга тайлбар өгөх үү. Хууль тус бүрээр санал хураах уу? Тамгын газраас тайлбар өгье.

Ч.Дондогмаа: Хууль, эрх зүйн газар. Хуулийн газар. Хуулийн төслийг хэлэлцэх дэгийг чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан байгаа. 35 дугаар зүйлд зааснаар Байнгын хороон дээр хуулийн төслийг хууль бүрээр санал хураана. Чуулган дээр Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийн хүрээнд санал хураах учраас хууль тус бүрээр санал хураахгүй байгаа.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны, тийм. Энэ чинь өнөөдөр Байнгын хорооноос орж ирсэн саналаар асуудал хэлэлцэгдэж байгаа, Даваасүрэн дарга. Тэгэхээр Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэж нэг хураана. Дэмжээгүйг дэмжье гэж санал хураана.

Дондогмаа дарга нэмж тайлбар өгье. 12 дугаар микрофон. Ажлын хэсгийн 12 дугаар микрофоныг өгье.

Ч.Дондогмаа: Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт энэ хуулийн 35.8-д заасны дагуу хуралдааныг явуулсны дараа Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна гэж заасан байгаа.

Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэх санал хураалт хийхдээ 36 дугаар зүйлийн 10 дахь хэсэг хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг биш ээ, үгүй, үгүй, үгүй. 36 дугаар зүйлийн 12 дугаар зүйл үг хэлж дууссаны дараа хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна гэсэн ерөнхий заалт байгаа.

36.13 дээр нь санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн бол тухайн хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэх дээр холбогдох болон бусад Байнгын хороонд шилжүүлнэ гэсэн ийм хуулийн зохицуулалттай байгаа.

Тэгэхээр Байнгын хороон дээр хууль тус бүрээр, нэгдсэн хуралдаан дээр Байнгын хорооноос орж ирсэн саналаар санал хураалт явуулах зохицуулалттай.

Д.Амарбаясгалан: Баасандорж дарга тайлбар өгье. 12 дугаар микрофон.

Энэ хар, гишүүд, ийм байгаа шүү. Өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудал байна шүү дээ. Байнгын хорооны саналаар санал, дүгнэлттэй холбогдуулж, орж ирж асуудал хэлэлцэгдэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хууль чинь хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд чинь өөрөө Байнгын хороон дээрээ нэг бүрчлэн яригдаад, Байнгын хорооноос дэмжинэ, дэмжээгүй гэсэн 2 саналтайгаар орж ирж, чуулганы хуралдаанд орж ирж танилцуулагдаж байгаа юм.

Баасандорж дарга эхлээд нэг тайлбарлая. Тэгээд Даваасүрэн гишүүн.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Баасандорж байна. Даваасүрэн даргын асуултад хариулъя. Бид нар энэ сая ээлжит бус чуулганаар төсвийн тодотголыг бас хэлэлцсэн. Манай Их Хурлын дэгийн тухай хууль 2024 оны 7 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн. Сая ээлжит бус чуулганаараа 8 сард төсвийн тодотголыг хэлэлцэхэд энэ асуудал яг яригдсан. Энэ асуудал яригдаад бид нар яг саяын зарчмаар Байнгын хороон дээр нь дагасан хуулиудаа яг дэгийн хуулийнхаа дагуу тус тусад нь хураагаад, чуулган дээр орж ирэхэд нь дэмжсэн саналуудаа нэг хурааж байгаа. Үзэл баримтлалынх нь хүрээнд.

Харин дэмжигдээгүй санал, 3 санал байгаа. Түүнийг тус бүрд нь хураахаар байгаа. Ингэж оруулж ирсэн байгаа. Яг дэгийн хуулийнхаа дагуу явж байгаа.

Д.Амарбаясгалан: Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Энэ ингэж болохгүй. Яагаад гэвэл байна шүү дээ, одоо дэмжсэн 3 хууль байгаа. Гэтэл гурвууланг нь дэмж гэж албадаж болохгүй шүү дээ. Тэгээд гурвуулаа уначихвал гурвуулаа уначих гээд байна шүү дээ. Гурвуулаа

дэмжигдвэл гурвуулаа дэмжигдэх гээд байна. Гэтэл энэ 3 хуулиас 1-ийг нь дэмжихгүй байж болно. Энэ чинь тэгж шийдэж болохгүй шүү дээ. Батлахдаа яаж байна вэ. Хууль нэг бүрээр баталж байгаа. Тийм учраас ингэж бөөндөж болохгүй.

Д.Амарбаясгалан: Баасандорж дарга нэмж тодруулга өгье. Хууль тус бүрээр нь хураачихвал яадаг юм бэ.

Б.Баасандорж: Даваасүрэн дарга аа. Дэмжсэн саналууд нэг хураагдаад яг таны саяын хэлснээр дэмжигдээгүй 3 санал тус тусдаа хураагдахаар байгаа. Тус тусдаа хураагдана.

Д.Амарбаясгалан: Ингэе. Хууль тус бүрээр нь санал хураагаад явчихъя. Энэ дээр дэгийн зөрчил үүсэхгүй гэж ойлгож байна. Тийм ээ.

Санал хураалтыг явуулъя.

Бямбацогт сайд горимын санал гаргая.

С.Бямбацогт: Тэгээд сая Даваасүрэн гишүүний хэлж байгаа зөв л дөө. Байнгын хороонд чинь 25 гишүүн оролцоод дэмжинэ, дэмжихгүй гээд хуультайгаа танилцаад саналаа хурааж байгаа юм. Чуулганд 126 гишүүн оролцож байгаа юм. 126 гишүүн чинь тэр хуультай танилцаагүй, 25-аас 100 гишүүн нь. Тэр хүмүүс чинь бас дэмжих, дэмжихгүйгээ бид нар мэдэхгүй байгаа учраас хууль тус бүрээр нь хураах ёстой. Тийм болохоор хууль тус бүрээр нь хураая гэсэн горимын санал гаргаж байна. Хуучин ч ер нь бас тэгж явдаг байсан. Тэгэхгүй бол бөөнд нь хураачихаар чинь 100 гишүүнээ тэр Төсвийн байнгын хороонд юу ярьсныг юу ч мэдэхгүй шүү дээ. Тэр чинь сонсож байгаа тийм үү, үзэж байгаа тийм, дэмжихгүй байж магадгүй. Тийм болохоор бөөндөж болохгүй. Горимын санал.

Д.Амарбаясгалан: Бямбацогт сайдын гаргасан горимын саналыг дэмжье гэж санал хураалт явуулъя. Санал хураалт.

61,9 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт эхлүүлье.

1. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай. Хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

63,8 хувиар санал дэмжигдлээ.

Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

63,8 хувиар санал дэмжигдлээ.

3. Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

57,1 хувиар санал дэмжигдлээ.

4. Засгийн газарт чиглэл өгөх тухай төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулна. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

Одоо Байнгын хорооны саналаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн:

1. ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх шаардлагагүй гэснийг дэмжье гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулна. Санал хураалт.

18 хувиар санал дэмжигдсэнгүй.

2. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх шаардлагагүй гэснийг дэмжье гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулна.

17,1 хувиар санал дэмжигдсэнгүй.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх шаардлагагүй гэснийг дэмжье гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулна. Санал хураалт.

14,3 хувиар санал дэмжигдсэнгүй.

Ингээд хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

12.37 цаг

Дараагийн асуудал.

Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Засгийн газраас 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Төслүүдийг Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулахаар тараасан байгаа.

Одоо Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна. Санал хураалт.

61 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэлээ.

Байнгын хороонд шилжүүлнэ. Даргын зөвлөлийн хурлын шийдвэрийн дараа.

Ингээд үдээс өмнөх хуралдаан завсарлаж байна.

Үдээс хойших хуралдаан 15 цагаас үргэлжилнэ.

ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААН.

Д.Амарбаясгалан: Үдээс хойших хуралдааныг эхлүүлье.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх. Хэлэлцүүлгийн явцад явцад үлдчихсэн нэг санал байгаа. Энэ санал хураалтыг явуулахаар байна.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулна. Санал хураалт.

50,9 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

15.11 цаг

Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар мэдээлэл хийнэ.

Монгол Улсын Ерөнхий сайдыг Тэргүүн шадар сайд Лувсаннъямын Гантөмөр орлож мэдээлэл хийнэ. Индэрт урьж байна.

Л.Гантөмөр: Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газар эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, цар тахлын дараах эдийн

засгийн сөрөг нөлөөг бууруулж, төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан хөгжлийг хязгаарлаж байгаа 6 багц асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх зорилгоор эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулах, дунд хугацааны зорилтот хөтөлбөр “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг дэвшүүлсэн байдаг.

Уг 6 багц бодлогын нэг болох боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд 4 чиглэлээр ажлууд хийгдэхээр төлөвлөгдсөн бөгөөд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлж байна.

1 дүгээрт, боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон БНХАУ-ын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Замын-Үүд боомт, Гашуун сухайт боомтуудад өргөтгөл шинэчлэл, барилга угсралтын ажлыг бүрэн хийж дуусган, ашиглалтад оруулсан байна.

Замын-Үүд боомтын шинээр бүтээн байгуулагдсан зорчигч тээврийн цогцолборт импортын тээврийн хэрэгслийн 8 гарцыг 20, экспортын 4 гарцыг 24 болгон нэмэгдүүлсэн.

Мөн иж бүрэн инженерийн дэд бүтэц, шугам, нэгдсэн удирдлагын төвтэй холбогдсон орчин үеийн хяналтын систем бүхий тээврийн хэрэгслийг автоматаар бүртгэх ухаалаг гарцууд, өндөр хүчин чадлын авто рентген болон бусад хилийн хяналтын тоног төхөөрөмжүүдийг суурилуулснаар зорчигч болон тээврийн хэрэгсэл түргэн шуурхай нэвтэрч, иргэд ая тухтай орчинд үйлчлүүлэх боломж бүрдсэн.

Замын-Үүд дэх ачаа тээврийн шинэ цогцолборт импортын тээврийн хэрэгслийн 3 гарцыг 22, экспортын 2 гарцыг 5 болж нэмэгдүүлж, 28 барилга байгууламж, иж бүрэн инженерийн дэд бүтцийн шугам, 11км цахилгаан хангамжийн шугам, дэд өртөө, зам талбайн гэрэлтүүлэг, холбоо дохиолол, камержуулалт, хашаа хамгаалалтын хэрэгсэл зэрэг ажлуудыг гүйцэтгэн ашиглалтад хүлээлгэж өгсөн байна.

Гашуун сухайт боомтын барилга байгууламж, зам талбайг өргөтгөн шинэчилж, зорчигч, ачаа тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх импортын 1 гарцыг 3, экспортын 1 гарцыг 3 болгон нэмэгдүүлж, нүүрс, тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх экспортын 6 гарцтай байсныг 10 гарцтай болгож, олон улсын жишигт нийцсэн ухаалаг гарц, авто пүү, хүнд даацын авто зам, рентген, ариутгал, эрэлч нохойн байр, лаборатори, холбоо дохиолол, камержуулалт зэрэг ажлууд хийгдсэнээр боомтын нэвтрүүлэх хүчин чадал даруй 3 дахин нэмэгдэх боломж бүрдсэн байна.

Мөн Гашуун сухайт боомтын өргөтгөл, шинэчлэлийн ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Хайрхан багт хил хяналтын байгууллагуудын ажилчдын орон сууц, дэд өртөөний барилга, гадна дулаан, цэвэр, бохир ус цэвэрлэх байгууламж, уурын зуухны, барилгын ажлын 90 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байгаа.

Цагаандэл уул боомтын бүтээн байгуулалтын ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалт болон БНХАУ-ын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр ажил хийж гүйцэтгэж байна. БНХАУ-ын Өвөрмонголын ӨЗО-ны Алшаа аймгийн 114 сая юанийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хилийн Цагаандэл уулын боомтын

өргөтгөл, шинэчлэлийн ажлын ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, байгаль орчны үнэлгээ, зураг төсвийг боловсруулах ажил хийгдэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 82 хувийн гүйцэтгэлтэй байна.

Цагаан дэл уул боомтын барилга байгууламж, шугам сүлжээ, суурьшлын бүс, нүүрс, эрдэс баялаг, ачаа тээврийн 12 эгнээ бүхий хүнд даацын авто зам, аялал жуулчлал, зорчигч шалган нэвтрүүлэх хэсэгт 6 эгнээ авто зам зэрэг иж бүрэн бүтээн байгуулалтын ажлыг 2025 онд эхлүүлнэ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараах боомтуудын ТЭЗҮ, байгаль орчны үнэлгээ болон зураг төслийн ажлыг хийж байна. Үүнд: Хавирга, Ханх, Шивээ хүрэн, Цагаан нуур боомтын ТЭЗҮ, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, нарийвчилсан зураг төслийн ажил иж бүрэн хийгдэж дууссан.

Ульхан, Бургастай, Ханги боомтын ТЭЗҮ, байгаль орчны үнэлгээ, нарийвчилсан зураг төслийн ажил дуусаж, экспертизээр хянагдаж дүгнэлт нь гарсан байна.

Ханги, Сүмбэр, Баянхошуу, Булган боомтын ТЭЗҮ-ийг мөн боловсруулсан.

Ханги боомтын барилга байгууламжуудын зураг төсөв болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ баталгаажиг дууссан байна.

Булган боомтын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг боловсруулан холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлж байгаа. Боомтын барилга байгууламжийн болон шугам сүлжээний зураг төсөв экспертизээр хянагдсан байна.

Сүмбэр, Баянхошуу боомтын ТЭЗҮ, байгаль орчны үнэлгээ, нарийвчилсан зураг төслийн ажил хийгдэж дууссан.

Мөн АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн тусламжийн санхүүжилтээр Боршоо, Алтанбулаг, Сүхбаатар, Бичигт, Хавирга, Булган, Цагаан нуур боомтуудын өргөтгөл шинэчлэл, барилга угсралтын ажил хийгдэж байна.

Боршоо боомтын иж бүрэн өргөтгөл шинэчлэлийн ажил, авто зам, гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажил дуусаж, байнгын ашиглалтад хүлээн авсан байна.

Боомтын шинэчлэлээр нийт талбай 3,5 дахин, өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 4,8 дахин, ачааны автомашины тоо 3 дахин, суудлын тээврийн хэрэгслийн тоо 6,7 дахин нэмэгдэж, зорчигч тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэн, иргэд ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэж, хууль бус, чанарын шаардлага хангахгүй бараа бүтээгдэхүүн нь хилээр нэвтрэхээс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх ашгийг хамгаалахад чухал ач холбогдолтой болсон байна.

Алтанбулаг боомтод зорчигч тээврийн 19, ачаа тээврийн 18, дэд бүтцийн 5 барилга, иж бүрэн инженерийн шугам сүлжээ, 6000 м² ногоон байгууламж, тусгаарлах зурвас бүхий 4 эгнээ 1,7км урттай авто зам, 7000 м² авто зогсоол, 30000 м² боомтын доторх зам талбай зорчигч, тээврийн хэрэгслийг түргэн шуурхай нэвтрүүлэх орчин үеийн технологи бүхий гарцуудыг шинээр ашиглалтад оруулсан байна.

Энэхүү бүтээн байгуулалтын үр дүнд Алтанбулаг боомтоор өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 3 дахин, ачааны тээврийн хэрэгслийн тоо 4 дахин, суудлын тээврийн хэрэгслийн тоо мөн 4 дахин нэмэгдсэн байна.

Сүхбаатар боомтын нэг цэгийн үйлчилгээний цогцолборын иж бүрэн өргөтгөл, шинэчлэлийн ажлыг дуусган, ашиглалтад оруулсан.

Сүхбаатар хилийн боомтын нэг цэгийн үйлчилгээний цогцолборын барилгыг ашиглалтад оруулснаар хил дээр хяналт хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын үйлчилгээг хүртээмжтэй, ил тод, үр ашигтай хүргэх механизмыг бий болголоо.

Түүнчлэн зорчигчид болон гадаад худалдаа эрхлэгчдийн төмөр замын боомтоор зарцуулж байгаа цаг хугацаа зардлыг 30-аас доошгүй хувиар бууруулж, улмаар боомтоор түргэн шуурхай нэвтрэх боломжийг бүрдүүлж байна.

Бичигт боомтод зорчигч тээврийн 24 байгууламж, дэд бүтэц, ногоон байгууламж бүхий өргөтгөл, шинэчлэл, барилга угсралтын ажил явагдаж байна. Тус боомтод гаалийн шуурхай удирдлагын төвтэй холбогдсон орчин үеийн теле хяналтын систем бүхий тээврийн хэрэгслийг автоматаар бүртгэх ухаалаг гарцууд болон өндөр хүчин чадлын рентген, тоног төхөөрөмжүүд суурилагдахаар төлөвлөгдсөн байгаа.

Боомтын шинэчлэлээр нийт талбай 3 дахин, өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 4 дахин, ачааны автомашины тоо 3 дахин, суудлын тээврийн хэрэгслийн тоо 4 дахин нэмэгдэж, зорчигч, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэн иргэд ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ.

АХБ-ны 106,3 сая ам.долларын санхүүжилтээр 2024-2030 онд хэрэгжүүлэх хилийн үр ашгийг нэмэгдүүлэх, тогтвортой худалдааны төслийн хүрээнд хилийн Хавирга, Булган, Цагааннуур боомтын өргөтгөл, шинэчлэлийн ажил хийгдэх бэлтгэл ажил хангагдаад байна.

Монгол Улсын худалдааны тэнцэл таатай чиглэлд шилжиж байгаатай холбогдуулан Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны коридорын дагуух хил дамнасан худалдааг хөнгөвчлөх, Монгол Улс дахь худалдааны зардлыг бууруулахад Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх хуваарийн 10.4-д 1 цонхны эцсийн хугацааг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр гэж тодорхойлсон. Үүний дагуу Монгол Улс гадаад худалдааны нэгдсэн цахим цонхыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2023 онд шийдвэр гарган гадаад цахим нэгдсэн цахим цонх хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар дэд бүтэц, олон төрөлт тээврийн ачиж буулгах, шилжүүлэн ачих терминалууд барих бүтээн байгуулалтын чиглэлд дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

Гашуун сухайт боомтод 92 сая ам.доллар-ын өртөг бүхий 10 сая тонн ачаа тээвэрлэх хүчин чадал бүхий автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал ашиглалтад орсон. Гашуун сухайт боомт дахь чингэлэг тээврийн терминалыг нийт 30 га талбайд 40 тэрбум 350 сая төгрөгийн санхүүжилтээр байгуулсан бөгөөд 8100 чингэлэг буюу 259200 тонн нүүрсний багтаамжтай жилд 8 сая тонн хүртэл нүүрс ачиж буулган экспортлох хүчин чадалтай болсон.

Гашуун сухайт боомтын 34 га талбайд Тавантолгой Гашуун сухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт болон төмөр замаас авто тээврийн хэрэгсэлд шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалтын ажлыг нийт 1 тэрбум 282 сая ам.долларын санхүүжилтээр хийсэн байна.

Шивээ хүрэн боомтод жилд 23 сая тонн ачаа тээвэрлэх хүчин чадал бүхий ачаа шилжүүлэн ачих, буулгах чингэлэг тээврийн автомат удирдлагатай 5G тээврийн терминалыг 100 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан байна.

Шивээ хүрэн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэхэд зориулж 929 сая төгрөгийн өртөг бүхий хилийн шалган нэвтрүүлэх 8 хаалга, 2,1 тэрбум төгрөгийн өртөг бүхий гаалийн хяналтын барилга ашиглалтад орсон.

Ханги боомтод 60 орчим сая ам.долларын өртөг бүхий жилд 20 сая тонн ачаа тээвэрлэх хүчин чадалтай олон төрөлт чингэлэг тээврийн терминал, ашиглалтад орсон.

Хавирга боомтод 4,7 тэрбум төгрөгийн өртөг бүхий ачаа тээврийн терминал, 43,3 тэрбум төгрөгийн өртөг бүхий уурхайгаас хилийн боомт хүртэлх 96км авто зам, 16 тэрбум төгрөгийн өртөг бүхий хүнд даацын төмөр бетон гүүрний ажлууд хийгдэж байна.

Цаашид хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж, хувийн хэвшилтэй хамтран боомтын хөгжлийг дараагийн шатад гаргах, боомтын шинэчлэл, боомтын шинэлэг менежментийг хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн байгаа.

Ингэснээр боомтын хөгжлийн эдэлбэр газартаа эдийн засгийн үр өгөөжтэй байлгаж, боомт нь орчин үеийн дэвшилтэт технологи бүхий терминал агуулах, авто зам, төмөр зам болон агаарын тээврийн цогцолбор болон хөгжиж, олон төрлийн үйлдвэр, үйлчилгээ тэдгээрийг дагасан хот, суурин, аж үйлдвэрийн парк үүсэх, хөгжих нөхцөл боломж бүрдэх юм.

Боомтын ажиллах цагийн горим зэрэглэлийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Экспорт, импортын хэмжээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд боомтын ажиллах цагийн хуваарийг уртасгах, зэрэглэл горимыг дээшлүүлэх, боомтын үйл ажиллагааг сэргээх, нээх асуудлаар 2 орны хилийн харилцааг зохицуулах Засгийн газар хоорондын хэлэлцээрт өөрчлөлт оруулах чиглэлээр хамтарсан уулзалт, яриа хэлэлцээрүүд тогтмол хийгдэж байна.

Хилийн боомтуудын ажиллах цагийн хуваарийг уртасгах, боомтын зэрэглэл горимыг нэмэгдүүлэх талаар Монгол Хятадын хилийн боомтын менежментийн хамтын ажиллагааны комисс, Монгол Улсын хилийн боомтын захиргаа болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Боомтын захиргаа хоорондын хамтын ажиллагааны механизмын хуралдаан, Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дэд комиссын хуралдаанд санал оруулан, тодорхой шийдвэрт хүрч ажиллаж байна.

Хилийн боомтуудын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлж, ажиллах цагийн хуваарийг уртасган ажилласны үр дүнд хилийн боомтын ажиллах хугацааг сард дунджаар 430 гаруй цаг буюу 18 ажлын өдрөөр уртасгаж чадсан байна. Ингэснээр Монгол Улс 2024 оны 3 дугаар улирлын байдлаар гадаад худалдааны эргэлт 20,4 тэрбум ам.доллар болж, энэ нь өмнөх оны мөн үеэс 12,7 хувиар, ковид цар тахлын өмнөх жил буюу 2019 оны мөн үеэс 94,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хилийн боомтод үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын хэрэгцээ шаардлагыг үндэслэн авто замын боомтуудын цагийн горим, зэрэглэлийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хэлэлцээр хийж, зарим боомтын ажиллах цагийн хуваарийг уртасгасан цагаар болон амралтын өдрүүдэд туршилтын журмаар ажиллуулж байна. Үүнд:

Баянхошуу, Өвдөг, Бичигт, Зүүн хатавч боомт Бямба-Ням гарагт өглөө 8-17 цагийн хооронд, Шивээхүрэн, Сэхээ боомт Даваа-Баасан гарагт 5-20 цагийн хооронд, Бямба-Ням гарагт 8-20 цагийн хооронд, Гашуун сухайт Ганц мод боомт Даваа-Баасан гарагт 17-20 цаг, Бямба-Ням гарагт өглөөний 8 цагаас 20 цагийн хооронд, Ханги мандал боомт Даваа-Баасан гарагт 17-20 цагт, Бямба-Ням гарагт өглөө 8-аас 20 цагийн хооронд, Булган боомт Бямба-Ням гарагт, Бургастай боомт Бямба гарагт тус тус нэмэлт цагаар ажиллаж байна.

Мөн Сүмбэр, Рашаан боомтын байнгын ажиллагаатай Хавиргаар Хашаат боомтыг олон улсын зэрэглэлтэй болгох асуудлыг БНХАУ-ын талтай тохиролцоод байгаа.

Замын-Үүд-Эрээн авто замын боомтын ачаа тээврийн хэсгийг 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл 24 цагаар уртасгаж ажиллуулсан. Энэ ажлын хүрээнд дараах үр дүнгүүд гарсан байна.

Тус ачаа тээврийн цогцолбороор улсын хил нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 41347 буюу 30,6 хувиар өссөн байна. Улсын хилээр нэвтэрсэн бараа, эргэлтийн хэмжээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад импортын бүрдүүлэлт 25188 буюу 70,6 хувь, барааны статистик дүн 573 сая ам.доллар буюу 49,2 хувь, ачааны жин 318,7 мянган тонн буюу 32,4 хувь, татварын дүн 296,1 тэрбум төгрөг буюу 58,9 хувиар тус тус өссөн байна.

Экспортын бүрдүүлэлт 5062 буюу 3 дахин, барааны статистик дүн 33,2 сая ам.доллар буюу 116,9 хувь, ачааны жин 362 мянган тонн буюу 5 дахин тус тус өссөн байна.

Замын-Үүд сумд ачааны автомашины очер дараалал үүсэж, жолооч ард иргэдийг бухимдуулах болон эмх замбараагүй байдал үүсэх асуудал арилсан бөгөөд Замын-Үүд сумд том оврын ачааны автомашины очер дарааллаас үүдэлтэй орчны болон хөрсний бохирдол буурсан зэрэг үр дүнгүүд гарлаа.

Замын-Үүд боомтын ачаа тээврийн цогцолбороор 2023 оны 4-8 дугаар сард гарах урсгалд 45178, орох урсгалд 48669, нийт 93843 автомашин улсын хил нэвтэрч байсан бол 2024 оны 4-8 дугаар сард гарах урсгал 65455, орох урсгал 69825, нийт 135280 автомашин улсын хилээр нэвтэрсэн байна.

Замын-Үүд авто замын боомтод хийгдсэн энэхүү туршилтын үр дүнд үндэслэн ачаа тээврийн хэсгийг 24 цагийн горимыг үргэлжлүүлэх талаар холбогдох талтай яриа хэлэлцээрийг хийж байна.

ОХУ-ын Алтанбулаг, Цагаан нуур боомтын ажиллах цагийн горимд өөрчлөлт оруулан 24 цагийн горимд шилжүүлэх талаар БНХАУ-ын ӨМӨЗО-ны боомтын захиргаатай хил дамнасан автомат удирдлагатай тээврийн ажиллах цагийн хуваарийг 24 цаг болгох талаар хэлэлцэж тодорхой үр дүнд хүрч байгаа.

2 дугаарт, хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттай бүрэн холбон, тээвэр логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит бус болох суурь нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлж байна.

Хилийн боомтуудыг нийт 2650 км хатуу хучилттай авто зам, 4600 км төмөр зам барих, шинээр 11 боомтыг авто замаар, 4 боомтыг төмөр замаар холбох ажлыг хийж гүйцэтгэж байгаа юм. Тухайлбал, Цагаан нуур, Улаан байшин чиглэлийн 25,8 км хатуу хучилттай авто замыг байнгын ашиглалтад оруулсан.

Ульхан боомтын чиглэлд Норовлин, Баян-Уул чиглэлийн хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц 70 хувийн гүйцэтгэлтэй байна.

Баян-Уул, Ульхан боомт хүртэлх 118,3 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц 50 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хэрлэн сумаас Хавиргын боомтын чиглэлийн 124,5 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц 30 хувийн гүйцэтгэлтэй.

Тавантолгой Манлай, Ханги чиглэлийн 477,1 км тусгай зориулалттай авто замын барилгын ажлын явц 97 хувийн гүйцэтгэлтэй.

Баруун Урт, Бичигт чиглэлийн 277,3 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц 23 хувийн гүйцэтгэлтэй.

Сүхбаатар, Замын-Үүд боомт чиглэлийн төмөр замын төв коридорыг хос замтай болгох, шинэчлэх төслийн хүрээнд төмөр замын шугамыг шинэчлэн хэрэгжүүлэх ажлын ТЭЗҮ-ийг хийж байна.

Эрээн цав, Баянтүмэн чиглэлийн төмөр замын шинэчлэх төслийн хүрээнд тус чиглэлийн төмөр замыг шинэчлэх нарийвчилсан зураг, төслийг мөн гүйцэтгэж байна.

Сайншанд, Баруун-Урт, Хөт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг Сангийн яам, ЗТЯ болон БНСУ-ын газар, Дэд бүтэц, тээврийн яам хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд Солонгосын Койка Кореал зэрэг байгууллагууд хамтран боловсруулсан байна.

Зүүнбаян, Ханги чиглэлийн 229 аравны, 29км төмөр замыг байнгын ашиглалтад хүлээн авсан бөгөөд төслийн барилга угсралтын замын доод бүтэц 100 хувь, замын дээд бүтэц 85 хувь, Ханги Номгон өртөөний барилгын байгууламжийн ажил 100 хувь, дохиолол холбооны ажил 60 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Ази Европыг холбосон бүс нутгийн ложистикийн төв байгуулах дамжин өнгөрөх ачаа тээврийг нэмэгдүүлэх чиглэлээр БНСУ-ын Сангийн яам, Худалдаа хөрөнгө оруулалтын агентлагтай хамтран Алтанбулаг тээвэр ложистикийн төвийг байгуулах урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулах, техникийн туслалцааны төслийг хэрэгжүүлж байна.

3 дугаарт, Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлалыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, аялал жуулчлалын салбарыг дэмжих ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлж байна.

Боомтын сэргэлт үндэсний хорооны 2023 оны агаарын замын хилийн боомтын асуудлаар авах арга хэмжээний тухай А04 дүгээр тогтоолоор Увс аймгийн Дэглий цагаан нисэх буудалд шинэ боомт байгуулах асуудлыг Монгол Улсын Их Хурлаар шийдвэрлүүлэхээр Засгийн газрын хуралдаанд оруулж хэлэлцүүлэхээр тогтсон.

Энэхүү шийдвэрийн дагуу “Хилийн боомт байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.

Хэнтий аймгийн Өндөрхаан нисэх буудлын 3С ангиллын болгох төслийн барилгын ажлын явц 90 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байгаа.

Мөн агаарын замын байнгын ажиллагаатай олон улсын боомтын тоог нэмэгдүүлэх чиглэлээр Ховд аймгийн Ховд нисэх буудлыг 4С ангиллын болгох төсөл, Хөвсгөл аймгийн Мөрөн нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэж, олон улсын 4С ангиллын болгох төсөл, Дорнод аймгийн Чойбалсан нисэх буудлыг 4С ангиллын болгох төсөл, Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, 4D ангиллын болгох төсөл, Увс аймгийн Дэглий цагаан нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

4 дүгээрт, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан эдийн засгийн чөлөөт бүс хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах ажлыг байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлж байгаа.

НҮБ-ын Ази Номхон далайн бүс нутгийн Эдийн засаг, нийгмийн комиссын 2023 оны 9 дүгээр сард зохион байгуулагдсан ээлжит хуралдаанаар Монгол Улсад байгуулах боломжтой хуурай боомтуудын асуудлыг хэлэлцүүлж, Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хавсралтад Алтанбулаг, Сайншанд, Улаанбаатар, Замын-Үүд, Чойбалсан, Ховд хот, Хөшигийн хөндий, Бичигт гэсэн нийт 8 байршилд хуурай боомт байгуулахаар батлуулсан байна.

Монгол Улсад олон улсын чанартай хуурай боомт байгуулах ажлын хүрээнд шаардлагатай ажлуудыг үе шаттайгаар хийж байна. Үүнд:

Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт тусгагдсан хуурай боомт байгуулах боломжтой баруун бүсийн коридор Ховд, төвийн бүсийн коридор Замын-Үүд, Улаанбаатар, Алтанбулаг, Хөшигийн хөндий, Сайншанд, Зүүн

бүсийн коридор Бичигт, Чойбалсан байршлуудад нөхцөл байдлын судалгааг хийсэн.

Хуурай боомтын байршлуудад баруун, төвийн, зүүн бүсийн коридорын дагуу зах зээлийн болон байршлын хамтарсан судалгааг БНХАУ-ын холбогдох судалгааны байгууллагуудтай хамтарч гүйцэтгэж байна.

Замын-Үүд сум дахь бүс нутгийн ложистикийн төвийг түшиглэн хуурай боомт байгуулах ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан байдаг. Тус төлөвлөгөөний хүрээнд Замын-Үүдийн хуурай боомт байгуулах ТЭЗҮ боловсруулах ажлын суурь судалгаа боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, судалгааны ажлыг мэргэжлийн зөвлөх үйлчилгээний байгууллагаар гүйцэтгүүлж байна.

Хуурай боомтыг байгуулснаар өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний худалдааны өртгийг бууруулах буюу тээврийн зардал, тээвэрлэлтийн хугацааг бууруулах, Орос, Хятад хөрш орнуудын зах зээлийг цаашлаад Ази Европыг холбосон дамжин өнгөрөх тээврийн орлогыг нэмэгдүүлэх, дотоод экспорт, импортын худалдааны эргэлтийг сайжруулахад томоохон түлхэц болно гэж үзэж байна.

Монгол Улсын Засгийн газраас боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулах, боомтуудын бүс нутгийн эдийн засгийн интеграцад үзүүлэх нөлөө, орон нутгийн хөгжилд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, бусад орны боомтуудтай гадаад худалдаанд эзлэх байр сууриараа өрсөлдөхүйц олон улсын жишигт хүргэн хөгжүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байна.

Боомтоороо хөгжлөөрөө тэргүүлэгч улс орнууд боомтыг ачаа тээврийн эргэлтийг зохицуулах зорилго бүхий томоохон эдэлбэр газар бүхий хот, суурин хэмээн тодорхойлж, үйлчилгээ авагч ААН, иргэдэд чирэгдэлгүй, мэргэжлийн үйлчилгээ үзүүлж, тэрхүү үйлчилгээнийхээ орлогоор санхүүждэг хэлбэрээр хөгжүүлж байна.

Боомтыг зөвхөн хил нэвтрүүлэх, шалгах, гаалийн татвар хураамж хураах цэг төдийхнөөр ойлгож байсан хуучны хандлагыг өөрчилж, орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулдаг, эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаатай, эдэлбэр газартай, ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг хэлбэрээр хөгжүүлэх шаардлагатай байгаа юм.

Иймд Монгол Улсын Засгийн газрын зүгээс боомтын сэргэлтийн асуудалд онцгойлон анхаарч, эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор Боомтын тухай хуулийн төслийг боловсруулж байна. Анхаарал тавьсанд баярлалаа, та бүхэнд.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь цөөнхийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл, Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргал, Агваансамдангийн Ундраа, Батын Батбаатар нар үг хэлнэ. Дарааллын дагуу үг хэлнэ. Энэ индэрт орж байна.

Одонгийн Цогтгэрэл гишүүн. 1 гишүүн 6 минут 15 секунд үг хэлнэ.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Өнөөдөр энэ ээлжит чуулганы анхны Ерөнхий сайдын мэдээлэл хийгдэх ёстой өдөр. Ерөнхий сайдын мэдээлэл гэдэг өөрөө онцлогтой. Улсын Их Хуралд байгаа зөвхөн цөөнх асуулт асууж тодруулга авдаг.

2 дугаарт нь, Ерөнхий сайд мэдээлэл хийж байгаа учраас энэ өөрөө салбар хоорондын асуудлууд байдаг. Өнөөдрийн хийгдэх ёстой боомтын сэргэлтийн асуудал гэдэг боомт дээр Шадар сайдын харьяаны бус хил хамгаалах газар байдаг. Боомт дотор гаалийн газар байдаг. Сангийн сайдын ярианы. Ийм учраас Ерөнхий сайд, Ерөнхий сайдын энэ анхныхаа мэдээлэлд орж ирж бас тодорхой хэмжээний хариултаа өгөх ёстой.

Дахиад өнөөдөр энэ сэдэв тусгагдсанаар боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар гэж байгаа юм. Өнгөрсөн цаг хугацааны. Тэгэхээр бас энэ цөөнхийн гишүүдийг хүндэтгээд Ерөнхий сайдын энэ анхны Ерөнхий сайдын мэдээлэлд заавал орж ирж оролцох ёстой, асуултад хариулах ёстой гэдэг байр суурийг АН-ын бүлгийн гишүүд илэрхийлж байгааг бас үгийн эхэнд дамжуулъя

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрийг 21 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хурлаар батлуулсан. Бусад хөтөлбөр, төслүүдийн адилаар их хүлээлт дагуулсан, том төсөвтэй, энтертайнмент арга барилтай, сүртэй хурал, сүржин танилцуулга нь хэтийдсэн агуулгаасаа илүүтэй хэлбэр Пи Артаа анхаарсан уг хөтөлбөрийг бидэнд танилцуулж, Улсын Их Хурлаар батлуулснаас хойш даруй 3 жил өнгөрсөн ч үзүүлэх ахиц, хийсэн ажил байхгүй байгаа нь бас харамсалтай байна.

Энэхүү хөтөлбөрт боомтын хүчин чадлыг 19 онд экспортолж байсан 50 сая тонн ачаа 3 дахин нэмэгдүүлж, 150 сая тонн хүргэх зорилт тавьсан. Улмаар шинээр бүрдсэн парламентаар үүнийгээ Монгол Улсын Засгийн газрын 24-28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 100 гаруй сая тонн болгохоор, Монгол Улсын хөгжлийн 25 оны хөтөлбөрт 80 сая тонн байхаар тус тус тодотгосон. Гэвч бодит байдал дээр өнгөрсөн 3 жилийн хугацаанд боомтын хоногийн ажиллах хугацааг уртасгах, нэмж гарц байгуулах зэргээр хөтөлбөртэй хөтөлбөргүй хийчих байсан ажлын хүрээнд л хүчин чадлыг механик хэлбэрээр нэмэгдүүлснээс өөрөөр бодит шинэчлэлийн ажлууд бас хийгдсэнгүй.

Дэлхийн эдийн засгийн форумас гаргасан өрсөлдөх чадварын индексээр Монгол Улсын хувьд 141 орноос 119 дүгээр байранд орсон. Дэлхийн банкны ложистикийн гүйцэтгэлийн индексээр Монгол Улс дэд бүтэц, гаалийн үйл ажиллагаа, ложистикийн үйлчилгээ зэрэг доогуур үнэлгээтэйгээр 130 дугаар байранд эрэмбэлэгдсэн байна. Эдгээр тоо баримт, статистикууд биднийг тээвэр ложистик, боомтын чиглэлдээ анхаарах ёстойг сануулж байгаа. Тэгээд үүн рүү онилж хөтөлбөр боловсруулж, ажиллуулж буйд нь Засгийн газарт бас та талархалтай хандаж болох асуудлууд бас байдаг. Гэхдээ энд эдгээр нь зөвхөн хатуу дэд бүтэц, хөрөнгө оруулалт руу аваачиж байгаа болохоос биш өөр тийм зөөлөн дэд бүтэц гэдэг хууль, эрх зүйн шинэчлэл, олон зүйл рүү асуудлууд хандахгүй байна.

Эдгээрийн үр дүнд өнгөрсөн 7 хоногийн байдлаар гэхэд БНХАУ-ын Тяньжин боомтоос чингэлэг татах хугацаа 95-150 хоног болж сунаж, Монгол Улсад ирэх 4400

чингэлэг хилийн цаана бөөгнөрч, иргэн, ААН 3 дахь орноос татан авч буй ачаа 180 хоногоор саатаж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний импортын үнэ нэмэгдэхэд нөлөөлж, бизнесийн байгууллагуудын үйл ажиллагаа ашигт ажил олон олон зүйлд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй, иргэдийн худалдан авах чадварт дам байдлаар дарамт үүсгэж байна.

Дэлхийн банкнаас гаргасан 2023 оны ложистикийн гүйцэтгэлийн индексээр Монгол Улс хилийн боомт дээрх хүлээлгийн хугацаа, дэд бүтцийн дутагдалтай байдал, бараа, бүтээгдэхүүнд тавих хяналт ложистикийн чадавх зэрэг хүчин зүйлсээр ижил төстэй улс орнуудаас хэт хол хоцрогдолтой байгааг дахин дурджээ.

Мөн түүнд зөвхөн дэд бүтцийн хөрөнгө оруулалтаас гадна зөөлөн дэд бүтэц болох худалдааг хөнгөвчлөх, хил гаалийн үйлчилгээг хялбарчлах чиглэлээр ажил хийхгүй, Засгийн газрын зүгээс санаачилгүй ажиллаж байгааг онцлон дурджээ.

Асуудлыг шийдэх гэж ажиллах биш асуудалд өөрөө сайд нар төсвөө нэмүүлэх, зарцуулах, хөрөнгө оруулалт ахиулах шалтгаан төдийгөөр ашиглагдсаар буйг эрс буруутгаж байгааг бас АН-ын зүгээс, бүлгийн зүгээс илэрхийлж байна.

Амласан ажил ажил хэрэг болохуйц олон асуудал эзэнгүй шийдэлгүй байгаагаас ганц нэгийг онцгойлон дурдъя. Гашуун сухайт Ганц мод, Ханги мандал, Шивээ хүрэн, Сэхээ чиглэлд мухар төмөр замууд тавигдаж, төмөр замын тээврийн хил холболтын асуудлууд өнөөдрийг хүртэл тодорхой шийдэлгүй байсаар байна.

2025 онд эдгээр төслүүдийн хил холболт хийгдэхгүйд тохиолдолд боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэхээр Монгол Улсын хөгжлийн 25 оны төлөвлөгөөнд тусгасан зорилт хэрэгжихээргүй ийм байдалтай байна.

Төмөр замаар холбох хил холболтын төслүүд БНХАУ-ын талын шийдлийг хүлээн зогссон. Төмөр замын сүлжээг шинэчлэн сайжруулах хүрээнд зарим голд төмөр замыг хос болгох чиглэлд бодит ажил хийгдэж эхлээгүй. Шинээр төмөр замын сүлжээ байгуулах хүрээнд Зүүнбаян, Ханги чиглэлээс бусад төслүүд эхлээгүй. Транзит хурдны авто зам болон хилийн боомтуудын хатуу хучилттай авто замаар холбох төслүүдийн хэрэгжилт тун хангалтгүй, ихэнх нь эхлээгүй. Хилийн боомтуудын нэвтрүүлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх ачаа тээврийн терминалуудыг байгуулах ажлуудын хүрээнд импортын ачаа бараа тээвэрлэх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх хүрээнд тодорхой ажлууд хийгдээгүй. Чингис хаан ОУНБ-аас өргөтгөж, олон улсын агаарын тээврийн транзит төв болох зэрэг асуудал тодорхойгүй байгаагаас харахад боомтын сэргэлтийн зорилтот хөтөлбөрүүд төлөвлөсөн хугацаандаа хугацааных нь дийлэнх өнгөрчихсөн байхад ахиц гараагүй байгааг бас онцгойлон сануулж хэлэх ёстой.

Боомтын сэргэлтийн хүрээнд батлагдах ёстой хуулиудын жагсаалтад байгаа Тээврийн нэгдсэн хуулийн төсөл, Боомтын тухай хуулийн төсөл зэрэг тэргүүтэй хуулиудыг Засгийн газраас одоог хүртэл өргөн бариагүй байгаа нь боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх, энэ хүрээнд хийгдэх бүтээн байгуулалтын ажилд хувийн хэвшлийг татан оролцуулах, салбар хоорондын уялдаа, давхардал, хийдлийг арилгах зэрэг эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэх Замын-Үүд Алтанбулаг чиглэлийн олон улсын транзит хурдны зам барих ажил олон жил яригдаж байсан ч цаашид хэрхэх нь тодорхойгүй байдалтай байна. Энэ мэт

аминд тулсан яаралтай шийдэх төслүүдийг хөдөлгөлгүй орхиод асуудлыг мартуулах бол .../ минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цаг дууслаа. Тэр дэлгэц дээр минут гараад байгаа юм. Дуусах болоогүй байна уу. Тэгэхээр нөгөө бусдын минутаас хоцрох юм.

Цогтгэрэл гишүүнд 1 минут нэмж өгье.

О.Цогтгэрэл: Өмнө эхлүүлсэн хөтөлбөрийнхөө үр дүнг гаргаад, дараа дараагийн ажил хөтөлбөрүүд рүү ордог бол ядаж өчүүхэн ч төдий үр дүн гарахад ард, иргэдэд мэдрэгддэг бол ажил, хөтөлбөр, төсөл бүхнийг тань 2 гараа өргөөд дэмжихэд бэлэн байгаагаа АН-ын бүлгийн зүгээс илэрхийлж байна.

Өнөөдрийн байдлаар манай улсын эдийн засаг, улсын төсвийн орлого, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлогоос хэт хамааралтай болсон бөгөөд үүнийг дагасан төсвийн зарлагын хэт тэлэлт бий болсон. Төмөр замын хил холболт төлөвлөсөн хугацаанд биелэхгүй тохиолдолд ирээдүйд тооцсон орлого тасалдаж, эдийн засаг төсөвт эрсдэл үүсэхээр байгааг Монгол Улсын 2025 оны төсвийг батлахаар хэлэлцэж буй энэ цаг үед бас та бүхэнд анхааруулъя. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргал Төв индэр дээрээс.

Ж.Золжаргал: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улс боомтын сэргэлтийн бодлого гэсэн нэртэйгээр өнгөрсөн жилүүдэд харагдахаар бас үнэхээр үр дүнтэй ажил хийсэн гэдгийг энэ салбар дээр, хил гааль дээр, тээвэр дээр, уул уурхай дээр ажиллаж байгаа хүмүүс тодорхой хэмжээнд хүлээн зөвшөөрч байгаа гэдгийг бас хэлмээр байна.

Боомтын хөдөлгөөнийг хянах тооны зөрөө, хил гаалийн мэдээлэл дээр будилаан гардаг. Түүнээс болоод нүүрсний хулгай гэдэг асуудал босож байсан. Ард нь янз бүрийн маргаан гардаг. Энэ тал дээр хил гаалийн цахимжилтын түвшин шинэ шатад гарсан гэдгийг бас та бүхэндээ хуваалцмаар байна.

Инновац цахим бодлогын байнгын хорооноос холбогдох байгууллагуудаар бол ажилласан. Цахимжилтын түвшин бол нэлээн сайн болсон байгаа. Одоо хилийн болоод хилийн байгууллага болоод гаалийн хоорондох мэдээллийг нэгтгэх, солилцдог ийм шийдэл нь туршилтын шатдаа яваад байгаа. Энэ нэлээн удаж байна. Үүнийг бол шахаж шаардах, бас яаравчлах хэрэгтэй гэдгийг зориуд цохож хэлмээр байна.

Тэгээд суурь дэд бүтцийн асуудал, хил гаалийн бүтээн байгуулалт, цахимжилт энэ бүгд нь Монголын бараа бүтээгдэхүүнийг хөдөлгөөнийг нь хянах, элдэв янзын хулгай, янз бүрийн бүртгэлгүй зүйлс гарахаас урьдчилан сэргийлэх, тэгээд түүхий эдээ тээвэр нь ойлгомжтой, нээлттэй, биржээр борлуулдаг болох, орлогоо нэмэгдүүлэх иймэрхүү зорилготой гэж бодож байгаа.

Тийм учраас Монгол Улс эрх зүйн орчиндоо өөрчлөлтүүд оруулаад, биржээр жишээ нь нүүрсээ зараад эхэлсэн. Хэрвээ энэ бүхний үр дүнд тээвэрлэлт нь нэмэгдэхгүй, хилээр нэвтэрч байгаа бараа нэмэгдэхгүй, нүүрсээ биржээр зарж

чадахгүй байх юм бол үр дүнгүй ажил болно. Тийм болохоор энэ их хөрөнгө оруулсан ажлаа ажил хэрэг болгож бодитоор ашиглахад нь анхаарах, үүн дээр Засгийн газар онцгой анхаарч ажиллах шаардлага үүсээд байна.

Юуны түрүүнд дурдахад Гашуун сухайт, Ганц модын боомт, хил холболтын төмөр замын асуудал. Хэрвээ үүнийг холбохгүй бол бусад боомтууд холбогдохгүй. Тэгэхээр нүүрс гаргахгүй, нүүрс гаргахгүй болохоор орлого байхгүй, орлого байхгүй болохоор тэлчихсэн төсөв өөрийгөө тэжээж чадахгүй. Ингээд Монгол Улс хүнд байдалд орно. Мега төслүүд хэрэгжихгүй ээ. Ийм яриа нэлээн их явж байгаа.

Тэгэхдээ энд бодох зүйлс их байна.

1 дүгээрт, нэгэнт барьчихсан дэд бүтэц, төмөр замаа ашигламаар байна. Тавантолгойн ордоос Гашуун сухайт хүртэл хүчин чадлын 4 хувийг 9 дүгээр сарын байдлаар ашиглаж байна. Нийт 30 сая тонн тээвэрлэх чадалтай, ойролцоогоор ерөөсөө 4 хувийг нь л 1,3 сая тонныг л одоогоор тээвэрлэсэн байна. Төмөр замын холболт хийгдсэн эсэхээс үл хамаараад төмөр замын толгой дээр нүүрс ачих байгууламж нүсэр технологит орчин үеийн байгууламж ашиглалтад орчихсон. Төмөр замын төгсгөл дээр төмөр замаас аваад, машин дээр ачаад цааш нь гаргах түрүүн бас мэдээлэл дээр олгогдсон терминалууд нь байгуулагдчихсан, ажиллаж байгаа. Өөрөөр хэлбэл ачаад, хил дээр аваачаад, цааш нь гаргах боломж нь байгаа. Яагаад 1,3-хан сая одоогоор явж байна вэ? Тарифын асуудал байна уу. Явуулахгүй сонирхол байна уу? Энэ дээр бүтээсэн ажил, хөрөнгө оруулалтаа ашиглаад Монгол Улсынхаа экспортыг гаргах, тээврийн зардлыг бууруулах, орлогоо нэмэгдүүлэх энэ ажлыг явуулмаар байна.

2 дугаарт нь, Хил холболтын төмөр замын техник, эдийн засгийн зураг төслийн ажлыг БНХАУ-ын тэр зураг төслийн 3 дугаар хүрээлэн хийгээд дуусчихсан. Гүйцэтгэгч нь Монгол Улсын 23 оны 7 сарын 7-нд Улсын Их Хурлаас гарсан тогтоолоор Хятад талдаа суурь дэд бүтэц эзэмшдэг компани байна. Тэр нь бол ганц л компани байгаа. Чайна инержи гүйцэтгэнэ. Тэгээд ингээд 20 сая тонны хөрөнгө оруулалт юу худалдан авалт, нүүрсний гэрээ байгуулна гээд. Иймэрхүү одоо тийм нөхцөл бол тавьчихсан байдаг.

Үүн дээрээс нэмээд одоо ирж байгаа мэдээллээр бол олборлолт дээр Хятадын тал оролцоно. Барилга угсралтаа хийнэ. Тээвэр дээр нь оролцоно. Олборлолт оролцоно. Өөрөөр хэлбэл ААН болон Монгол Улсын төр Бүгд найрамдах Хятад ард улсын төр, өөр өөр түвшний, өөр өөр чиглэлийн байгууллагууд. Монгол Улсын болон БНХАУ-ын төрийн дээд түвшинд тээврийн асуудлууд, төмөр замын асуудлуудыг ярьж тохирсон гэсэн мэдээлэл байгаа. Өнөөдөр бас гишүүдэд мэдээлэл түгээгдсэн байна. Төрийн асуудлын нэг тусдаа, аж ахуй нэг тусдаа байх ёстой. Тийм болохоор Хятадын талаас гүйцэтгэгчийгээ эцэслэж тохироод, хийх ажлыг нь Эрдэнэс тавантолгой, Чайна Энержи байна уу тэр ААН-үүд тусдаа хиймээр байна. Үнэхээр тэр бүтээн байгуулалт, барилга угсралтыг хийх юм бол тэр ажлыг нь шахаж шаардмаар байна. Явахгүй байгаа бол 2 улсын төрийн харилцааны хүрээнд гадаад харилцаагаараа асуудлыг тавимаар байна.

Хэрвээ энэ төсөл удаад, нөхцөл нь манай хувьд хүлээж авахын аргагүй байх юм бол энэ нь цаанаа нүүрсний үнэ дээр асуудал үүсгэнэ. Нүүрсний олборлолтыг Монголчууд 100 хувь хийж чадна. Нөхцөл нь тохирохгүй бол заавал холбох гээд байх шаардлага ч бас байхгүй байж болно. Цэвэр эдийн засгийн үр ашгийн болоод бодлогын шийдвэр хэрэгтэй гэж үзэж байна.

Эцэст нь нэг зүйл нэмээд хэлэхэд өчигдөрхөн байгаль орчны хүмүүс ирээд Говь-Алтай аймгийн Нарансэвстэй боомтын талаар асуудал тавьсан. Тэр бол эдийн засаг болоод байгаль орчноо дэнсэлж байж шийдвэр гаргахдаа гэж үзэж байгаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

Агваанлуvsангийн Ундраа гишүүн үг хэлнэ. Индэрт урьж байна.

А.Ундраа: Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Мөн Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байгаа залуучуудад бас мэнд хүргэе.

Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд боомтын сэргэлтийн бодлогын талаарх танилцуулгыг сонслоо. Өнөөдрийн боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаарх мэдээллийг Ерөнхий сайд өгөх ёстой байсан. Үүн дээр би АН-ын байр суурьтай бас адилхан байна. Ерөнхий сайд өөрийн биеэр мэдээлэл хийх нь бол зүйтэй гэж үзэж байна. Тэгээд Шадар сайдын уншсаныг сонслоо.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын энэ хүрээнд мэдээж боомтын сэргэлт маш чухал үүрэгтэй. Энэ хүрээнд энэ 4 чиглэлээр танилцуулга хийгдлээ.

1 дүгээрт, боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийн талаар. Энэ нь бол боомтын ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг хэрхэн дээшлүүлж байгаа талаар,

2 дугаарт, хилийн боомтуудын төмөр зам болон авто замын хатуу хучилттай авто замын үйл ажиллагаа. Тэр нь улсын төсвөөр болон гадаадын зээл тусламжийн хүрээнд хийгдэж байгаа ажлын талаар,

3-д нь, Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт агаарын зам ашиглалтын талаар,

4-д нь, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан чөлөөт бүс хуурай боомтын байгуулалтын талаар мэдээлэл хийлээ.

Энэ өнөөдөр хийсэн мэдээллүүдийн хүрээнд харахад бол энэ нь нэлээд хөрөнгө оруулалт талаасаа тоочсон шинжтэй, үйл ажиллагааны явцыг мэдээлэх маягтай байна.

Гэтэл боомтын сэргэлтийн асуудлын хамгийн чухал зүйл болох хүний нөөц, боомтууд дээр ажиллаж байгаа ажиллагсад, гаалийн байгууллага, хилийн шалган нэвтрүүлэх болон бусад төрийн байгууллагууд, мөн хувийн хэвшлийн энэ ажиллаж байгаа хүмүүсийн амьдрах, ажиллах орчны талаар нэг ч үг, үсэг, өгүүлбэр алга. Ажиглагсдын нөхцөл байдлын талаар мөн хамгийн олон уул уурхайн хамгийн их хэмжээний бараа бүтээгдэхүүний эргэлттэй Гашуун сухайтын боомтын тухайд ярихад маш олон жолооч нар тэнд олон цагаар ажилладаг, түгжирдэг. Тэнд нийгмийн жолооч нарын ажиллах орчны болон нийгмийн мөн байгаль орчны нөлөөллийн олон асуудлууд хуримтлагдсан байдаг. Эдгээрийг хэрхэн шийдэж байгаа талаар энэ мэдээлэл дотор дурдагдсангүй.

Энэ нь юуг харуулж байна вэ гэхээр Засгийн газраас өргөн барьсан төслийг харж байхад ч гэсэн дандаа бүтээн байгуулалт, барилга байгууламж, хөрөнгө оруулалтын чиглэлийг дурддагаас биш хүн рүүгээ чиглэсэн ажил шат шатдаа дутагдаж байгааг өнөөдрийн мэдээлэл ч гэсэн бас дахин харуулж байна.

Тэгээд хүн рүүгээ чиглэсэн бодлого дутагдсан. Мөн түүнчлэн салбар хоорондын бодлогын уялдаа алдагдсаны улмаас ямар ямар үр дагавар гарч байгаа талаар зөвхөн заримаас нь дурдахад боомт дээр ажиллаж байгаа саяхан Замын-Үүдийн боомт дээр би ажиллаад ажил байдалтай танилцаад ирлээ. Тэгэхэд гаалийн байгууллага бол жишээлэхэд нийт орон тооныхоо 85 орчим хувийг ажилтнуудаар бүрдүүлсэн. Орон тоо дутуу, тэнд ажиллах сонирхолтой, боломжтой боловсон хүчин бол тэр болгон олдохгүй ийм нөхцөлд ажиллаж байна.

Мөн хил дээр ажиллаж байгаа ажиллагсдын хувьд бол ажиллах орон байрны асуудал, мөн хилийн орчмын тэдгээр суурин газруудын бусад нийгмийн асуудал, жишээлэхэд, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хүртээмжийг анхаарахгүй байгаа нь бол харагдаж байна. Эдгээрээс болоод хэдийгээр боомтуудын нэвтрэлтийг сайжрууллаа гэвч энэ нь зөвхөн цаасан дээрх онолын түвшинд үлдээд байгаа болов чиг яг түүнийг авч хэрэгжүүлдэг, тэр ажлыг хийж гүйцэтгэдэг хүний нөөцийн асуудлаа бол орхигдуулсан байгаа нь харагдаж байна.

2 дугаарт, амьдрах, ажиллах орчны талаас гадна ажлаа хийх нөхцөл бололцоог бүрдүүлэх асуудал бол туйлын дутагдалтай байна. Жишээлэхэд Замын-Үүдийн боомтын асуудал дээрээс харахад бол хилээр нэвтэрч байгаа ачаа шалгалт хийгдэхэд лабораторийн тоног төхөөрөмжийг ажиллуулах боловсон хүчин, нарийн мэргэжлийн нөөц бололцоо дутуу байна.

2 дугаарт, лабораторийн тоног төхөөрөмжөө ашиглуулъя гэхэд тэнд хэрэгцээтэй шаардлагатай байгаа урвалж бодисууд цаанаасаа нийлүүлэгддэггүй гэдэг шалтгаануудаас болоод яг хил дээр Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа бараа бүтээгдэхүүн хүн ардад аюулгүй байх эсэхийг баталгаажуулах, тэдгээр лабораторийн тоног төхөөрөмжүүдийг ашиглах бололцоо байхгүй. Өөрөөр хэлбэл бид нарт ямар нэгэн баталгаа алга гэдэг нь харагдаж байна.

Цаашлаад харах юм бол Монгол Улсын агаарын зай, зохион байгуулалт, агаарын замын ашиглалтын талаар мэдээлэлд дурдсан байгаа хэдий энэ дотор аялал жуулчлалын салбартай уялдуулан авч хэрэгжүүлж байгаа бодлогоо дурдаж байгаа нь зүйтэй болов чиг цаашлаад манай Монгол Улсын хувьд далайд гарцгүй орны хувьд агаарын тээвэр онцгой чухал үүрэгтэй. Энэ тохиолдолд гуравдагч хөршүүд рүү шууд нислэгтэй болох чиглэлийг нэмэгдүүлэх талаар, энэ нь хэрхэн аялал жуулчлалын бодлоготойгоо уялдаж байгаа талаар, энэ талаар ямар нэгэн зүйл энэ боомтын асуудал дээр дурдагдсангүй.

Тэгэхээр дараа, дараагийн мэдээлэл гаргахдаа зөвхөн хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, зам, харилцаа гээд энэ хатуу дэд бүтэц, зөөлөн дэд бүтэц гэж байгаа гэрээ хэлэлцээр эрх зүйн орчныг ярихаасаа гадна хамгийн чухал баялаг болох хүний асуудлыг хөндөж ярьж, энэ тал дээр бодлогоо танилцуулна уу гэж анхааруулахыг хүсэж байна. Та бүхэнд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Мэдээлэлтэй холбогдуулан Ерөнхий сайдаас болон Тэргүүн Шадар сайд, асуудал хариуцсан сайд нар ажлын хэсгийн гишүүд хариулт өгөхөөр ирсэн байгаа.

Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Лувсаннъямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Буяагийн Тулга Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, Шаравын Мөнхцэрэн ЗГХЭГ-ын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга, Оргодлын Нарандэлгэр Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны ажлын албаны дарга, Доржгочоогийн Одгэрэл Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын зөвлөх, Сандагдоржийн Батболд ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Баасанжавын Болор-Эрдэнэ ЗТЯ-ны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, Хүчитбаатарын Итгэл ЗТЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлогын зохицуулалтын газрын дарга, Чадраабалын Сугармаа ЗТЯ-ны Авто замын бодлого, зохицуулалтын газрын дарга, Бямбауугийн Артур ЗТЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Батдэлгэрийн Батхишиг Хилийн боомтын захиргааны дарга, Дарамбазарын Балдорж Боомтын үйл ажиллагааны хэлтсийн дарга, Дэмбэрэлийн Зориггоо ГЕГ-ын Боомтын хэлтсийн дарга, Хүүгийн Мөнхжаргал Эрдэнэс тавантолгой ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч, Пүрэвийн Оюун-Эрдэнэ Боомтын хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч, Цэдэнбалын Цэвээндарь ГЕГ-ын Хяналт бүрдүүлэлтийн газрын гаалийн ахлах байцаагч.

Уучлаарай. Батын Батбаатар гишүүн үг хэлэх ёстой, орхисон байна. Батын Батбаатар гишүүнийг урьж байна. Индэрт.

Б.Батбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар сөрөг хүчний хувьд Иргэний Зориг Ногоон Намаа төлөөлөн байр сууриа илэрхийлье.

Монгол Улс бүс нутаг, Ази номхон далай, дэлхийд санхүү, хөрөнгө оруулалт, бирж чиглэлээр ажиллаж, бид нар санхүүгийн хувьд боомт улс орон болох тухай энэхүү санаачилгыг бас гаргаж байна. Энэ чиглэлд илүү сэтгэж илүү ажиллахыг Засгийн газраас бас уриалж байна.

Монгол Улс БНХАУ-тай 4709 км, ОХУ-тай 3543 км-ээр хиллэдэг, далайд гарцгүй орон. Гэвч манай улсын эдийн засгийн урсгал харилцаа ердөө 4 боомт дээр төвлөрдөг. Энэ нь бараа бүтээгдэхүүний хомсдол үүсгэх, үнийн өсөлт, бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгааг та бид мэднэ. Үүнийг сайжруулах, гарц урсгалыг нэмэгдүүлэх үүднээс боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн, ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлэх ажлыг хийх ёстой. Гэсэн хэдий ч зөвхөн томоохон корпорацууд болон гадаадын хөрөнгө оруулагчид эрх мэдэл дагасан компани, хэсэг бүлгийн ашиг хүртдэг тогтолцоог бий болгох гарц болох магадлал өндөр байгааг Иргэний Зориг Ногоон Нам сэрэмжлүүлж байна.

Тухайлбал, Засгийн газраас гааль, боомтын удирдлагын тогтолцоонд зориулж 106 тэрбум төгрөг төсөвлөжээ. Засгийн газрын арга барил нь зөвхөн дэд бүтцийн шинэчлэлээр хязгаарлагдах ёсгүй. Манай боомтуудын удирдлагад тулгардаг хүнд суртлын саад бэрхшээлийг арилгах шаардлагатай байна. Бүх

бизнесийн хувьд цаг хугацаа хэмнэх зардлыг бууруулах нь нэн чухал бөгөөд үүний тулд захиргааны үйл ажиллагааг оновчтой болгох нь чухал юм.

2-т нь, экспортын ачаа 3 боомтоор буюу Гашуун сухайт, Шивээ хүрэн, Замын-Үүдийн боомтуудаар 90 хувь нь гадагшилдаг. Импортын ачаа 2 боомт дээр буюу Алтанбулаг, Замын-Үүд боомтуудаар 90 хувь нь Монгол Улсад нэвтэрч орж ирдэг. Боомтуудыг холбосон авто зам, дэд бүтэц, төмөр замын дэд бүтэц хангалтгүйгээс шалтгаалан бараа, бүтээгдэхүүний эвдрэл, гэмтэл, чанарын шаардлага алдагдах, тээвэрлэлтийн зардал өсөх гэх мэт асуудлууд үүсдэг. Үүний улмаас хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар холбон, тээвэр логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, ачаа тээврийн урсгалыг сайжруулах нь зүйтэй байна. Гэсэн хэдий ч томоохон дэд бүтцийн төслүүд, байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаар Иргэний Зориг Ногоон нам санаа зовниж байна. Тухайлбал, Алтанбулагийн хуурай боомтын бүтээн байгуулалтад 15 тэрбум төгрөг төсөвлөгдсөн бөгөөд хил дамнасан худалдааг сайжруулах боломжийг онцолж байна. Гэхдээ Засгийн газар эдгээр төслүүдийн байгаль орчны үнэлгээг сайтар хийсэн эсэх, экологийн хохирлыг багасгах төлөвлөгөө байгаа эсэхийг бид анхаарах ёстой.

Тэгээд ч энэ төслүүдийг Монгол Улсын тусгаар тогтнолыг алдагдуулж, өр зээлээр буюу гаднын санхүүжилтээр санхүүжүүлэхгүй байх ёстой гэж Иргэний Зориг ногоон намынхан анхааруулж байна.

Засгийн газар гадаадын хөрөнгө оруулалтад найдаж байгаа нь урт хугацааны ерийн үүрэг болон үндэсний нөөцөд тавих хяналтаа алдаж болзошгүй гэсэн болгоомжлолыг төрүүлж байна. Өнөөдөр Монгол Улсын гадаад өр 3 жилийн дотоодын нийт бүтээгдэхүүнтэй тэнцэх хэмжээнд хүрээд байгааг бид мартаж болохгүй. Өрийг өрөөр, бондыг бондоор хаасаар байгаад баялаг бүтээдэг бус орлого олдоггүй зүйлд өр тавьж хөрөнгө оруулалт хийсээр байгаад даруй 35 тэрбум долларын өртэй болсон байдаг. Ирээдүй хойч үедээ санхүүгийн хүнд дарамт учруулахгүйн тулд эдгээр төслүүдийг сайтар нягтлах ёстойг Иргэний Зориг Ногоон намынхан бид дахин анхааруулж байна.

3-д нь, Монгол Улсын агаарын орон зайн зохион байгуулалтыг боловсронгуй болгох, агаарын тээврийг үе шаттайгаар либералчлах, Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь Монгол Улсыг ачаа тээврийн төв болгох аялал жуулчлалын салбарыг дэмжих зорилготой гэж ойлгож байна. Энэхүү санаачилга нь эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх боломжтой хэдий ч болгоомжтой байхыг Иргэний Зориг Ногоон Нам анхааруулж байна.

Агаарын тээврийг оновчтой зохицуулалтгүйгээр хурдацтай либералчлах нь манай үндэсний агаарын тээврийн компаниудыг хохироож, гадаадын тээвэрлэгчдийг монополчлоход хүргэж болзошгүй юм. Тухайлбал, Засгийн газраас ТЭЗҮ болон агаарын замыг өргөтгөхөд 20,5 тэрбум төгрөг төсөвлөжээ. Энэ нь дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлэхэд тусална. Гэсэн хэдий ч дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлэхийн тулд агаарын хөдөлгөөнийг удирдах аюулгүй байдлын дэд бүтцэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай. Хэрэв бид либералчлахын хажуугаар эдгээр дэд бүтцийг хөгжүүлж чадахгүй бол системийн хэт ачаалалд орж аюулгүй байдлаа алдагдуулж болзошгүй.

Түүнчлэн аялал жуулчлалын хөгжлийг тогтвортой үйл ажиллагаатай уялдуулах, ялангуяа байгалийн үзэсгэлэнт тогтоц, өв соёл нь Монгол Улсын үнэт

зүйлс тул аялал жуулчлалыг богино хугацаанд ашиг олох салбар болгохоос урьдчилан сэргийлэх ёстойг Иргэний Зориг Ногоон нам сануулж байна.

Бид ногоон аялал жуулчлалыг хөгжүүлэхийг дэмжинэ.

4-д нь, 2023 онд 60 сая тонн нүүрсийг доод үнээр нь зөөж төсвөө өсгөсөн. Өнөөдөр багадаа 80 гаруй сая тонн нүүрсийг дахин доод үнээр зөөх төлөвтэй болоод байна. Энэ мэтчилэн багтаамж, гарцын хэрээр хэн нэгний бэлдэц бааз импортын эрэлт хэрэгцээний ханган нийлүүлэгч, арыг даагч болохоос Иргэний зориг ногоон нам сэрэмжлүүлж байна.

Тиймээс Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан эдийн засгийн чөлөөт бүс хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхдээ болзошгүй нөхцөлөөс сэргийлсэн төрийн бодлого юу юунаас ч чухал байна.

Сэлэнгэ аймаг дахь хуурай боомтын бүтээн байгуулалтад ихээхэн хэмжээний төсөв төсөөлсөн нь дэд бүтцийг хөгжүүлэх замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхэд төрөөс анхаарч байгааг онцолж байна. Гэсэн хэдий ч чөлөөт бүс ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Б.Батбаатар: Тэнцүү байдлыг харгалзаж үзсэнд баярлалаа. Гэсэн хэдий ч чөлөөт бүс бүсээс орж ирэх татварын орлогын алдагдлыг худалдааны өсөлтөөр нөхөх үү гэдэгт бид эргэлзэж байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого” нь эдийн засгийг сэргээх, өсгөх алсын харааг илэрхийлж байгаа ч үр өгөөжөө шударга, тогтвортой хуваарилахад шаардлагатай хамгаалалт дутмаг байна гэж Иргэний Зориг Намынхан үзэж байна.

Боомт, төмөр зам, агаарын тээвэр, хуурай боомт гээд дэд бүтцийн бүтээн байгуулалтыг ил тод, хүртээмжтэй байгаль орчинд ээлтэй байдлаар хийх ёстой.

Нөгөөтээгүүр эдгээр төслүүдэд орон нутгийн оролцоо маш чухал юм. Эдгээр бүс нутагт амьдардаг ард иргэдийн хэрэгцээ, тэргүүлэх чиглэлтэй нийцүүлэхийн тулд иргэдийг бүтээн байгуулалтын шийдвэр гаргах үйл явцад оролцуулах ёстойг анхаарахыг та бүхэнд зөвлөж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Горимын санал аа. Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Энэ сөрөг хүчин гээд байх юм. Энэ АН, ХҮН нам 2 чинь Засгийн газрыг бүрдүүлж байгаа гишүүд мөн биз дээ. Эсвэл Гантөмөр гуай өөр нам болчихсон юм уу. Яагаад өөрөөсөө асуугаад байгаа юм? Би ч гэсэн асуумаар байна шүү дээ. Тэгвэл, бүгд асууж байгаа юм бол. Батбаатар, Ундраа 2 л асууна биз дээ, энэ чинь. Нөгөө 2 нь Засгийн газрын гишүүд шүү дээ, өөрсдөө. Тэгээд яагаад ийм тэгш бус байгаа юм бэ? Энэ дэгээ эс үгүй бол өөрчилдөг юм уу. Шадар сайд нь сая илтгэл тавилаа. АН-ын дарга нь. Тэгээд АН асуулаа. Энэ юу болоод байгаа юм. Жинхэнэ жонхуу болж байна шүү дээ. Ичмээр юм. Бид ч гэсэн асуух хэрэгтэй шүү дээ, тэгвэл. Энэ дэгээ өөрчлөх хэрэгтэй.

Д.Амарбаясгалан: Юм л бол Улсын Их Хурлын гишүүд өөрсдийнхөө хүсэл сонирхолд нийцүүлж дэг өөрчилье гэж ярьдгаа өөрсдөө хязгаарлах хэрэгтэй шүү. Байгаа дүрэм, журам, дэгт зохицож ажиллаж амьдарч сурах ёстой. Тэгэхгүйгээр өөрийнхөө хүсэл бодолд тааруулж дэг өөрчилье гэж ярьдгаа ер нь таслан зогсоо. Тийм хэмжээний ёс суртахууныг Улсын Их Хурлын гишүүд өөрсдөөсөө гаргах ёстой шүү. Яг л нөхцөлдөө тааруулаад л өөрчилнө, өөрчилнө гэдэг асуудал байнга ярьдаг боллоо. Энэ тийм муу дэг биш шүү. Энэ олон улсын түвшинд ардчилал хөгжчихсэн, парламентын засаглал хөгжсөн улс орнуудын жишигт нийцсэн дэг байгаа гэдгийг бас та бүхэн минь их сайн ойлгож ярьж байгаарай.

Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Үгээ хэлье. Өнөөдөр Улсын Их Хурлын эрхэм гишүүд, Засгийн газрын гишүүд бүгдээрээ Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийг зөрчөөд энд сууж байгаа. Дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйл Ерөнхий сайд нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх тухай зохицуулсан байна. 112.4 дүгээр хэсэгт Ерөнхий сайд мэдээллийг нэгдсэн хуралдаанд өөрөө хийнэ гэсэн байгаа юм. Шаардлагатай бол Засгийн газрын бусад гишүүдийг байлцуулна. Гэтэл энд ямар хуулийн зохицуулалтаар өнөөдөр Тэргүүн Шадар сайд мэдээлэл хийгээд, бид нар энд ингээд сууж байгаа юм. Дэгийн тухай хуулиа зөрчсөн Ерөнхий сайд Улсын Их Хурлын гишүүн. Ерөнхий сайдад ямар арга хэмжээ авах юм. Засгийн газар яагаад дандаа өөрсдөдөө таалагдсан хуулийн заалтыг барьж орж ирж байдаг юм. Хэрвээ Засгийн газрын тухай хууль, Улсын Их Хурлын дэгийн тухай хуультай зөрчилдөж байгаа бол нарийвчилсан хуулиа мөрдөнө. Тэгвэл энэ дэгийн тухай хууль байгаад яах юм. Сая Улсын Их Хурлын дарга та хэлж байна шүү дээ, дэгээ барина. Энэ сайн хууль гэж.

Тэгвэл өнөөдөр дэгээ зөрччихөөд бид нар энд жүжиг тоглолт сууж яах юм. Улсын Их Хурал Засгийн газрын харьяаны байгууллага биш. Улсын Их Хурал Засгийн газрын хуулийн тасаг ч биш. Тэгж давармааргүй байна. Ерөнхий сайд энэ чуулганд өөрөө үгээ хэлээд, өөрөө бид нарт тайлбараа өгөх ёстой.

Хэрвээ үүнийг мөрдөхгүй юм бол дэгийн тухай хууль гэж байж яах юм. Тэгэхээр Ерөнхий сайдыг дуудаж оруулж ирмээр байна. Засгийн газрын гишүүд энд суугаад тайлбар хийх ямар ч шаардлага байхгүй шүү дээ. Та нар.

Тэгэхээр АН-ынхныг энэ хурлыг хаяж гарахыг уриалж байна. Ингэж бид нар байж яах юм. Бид нар өнөөдөр хууль тогтоодог байгууллага. Өөрсдөө бид нар хуулиа барьж ард түмэнд үлгэр дуурайлаа харуулах ёстой. Тэгчхээд л нэг Засгийн газрын давхар дээлтэй хэдэн нөхдийн үгэнд ороод л энд ингээд сууж байгаад л бөөнөөрөө жүжиг тоглож байдгаа болих хэрэгтэй шүү дээ. Өөрсдөө хуулиа зөрччихөөд, ямар нүүрээрээ бид нар эндээс хууль батлах юм. Зуу зуугаар нь хуулийн өөрчлөлт хийдэг, тийм үү. Ямар ч мөрддөггүй. Ичих хэрэгтэй.

Их Хурлын дарга аа, Ерөнхий сайдыг дуудаж оруулж ирье. Дэгийн тухай хуулиа баримталъя. Би Дэгийн хуулийг өөрчилье гээгүй, баримталъя гэж байна.

Д.Амарбаясгалан: Их Хурлын Тамгын газрын дарга Баасандорж дарга хуулийн хэрэгжилттэй холбоотой тайлбар өгье. Ажлын хэсгийн 12 дугаар микрофон.

Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Баасандорж саяын Мөнхбаясгалан гишүүний асуусантай холбоотой хариулья.

Өнөөдрийн Ерөнхий сайдын нэгдсэн хуралдаанд хийж байгаа мэдээлэл маань яг сая Мөнхбаясгалан гишүүний хэлсний дагуу 112 дугаар зүйлд заасан журмын дагуу явагдаж байна. 2024 оны 10 сарын 25-ны өдөр Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга Учрал сайдаас албан бичиг ирсэн. Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийн талаар Монгол Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар мэдээлэл хийхээр товлогдсон боловч энэ хугацаанд Ерөнхий сайд түр эзгүй байгаа тул Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдын мэдээллийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд хийнэ ээ гэсэн албан бичгийг ирүүлсэн байгаа.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг нь Ерөнхий сайдын түр эзгүйд түүний үүргийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд гүйцэтгэнэ. Түр эзгүйд орлоно оо гэсэн үг байгаа.

Тэгэхээр ингээд Монгол Улсын Ерөнхий сайдын оронд Тэргүүн Шадар сайд мэдээлэл хийж байна гэж ойлгож байна. Энд.

Д.Амарбаясгалан: ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал сайд нэмж тайлбар хийе. Тайлбар хийж байгаа асуултад хариулаагүй.

Н.Учрал: Мөнхбаясгалан гишүүний асуулгад энэ тухайн өдөр Ерөнхий сайд түр эзгүй байгаа учраас энэ цагийг хойшлуулж өгнө үү гэдэг хүсэлтийг бид би бол эхлээд гаргасан юм. Албан бичгээр. Ингээд энэ хугацаандаа хийгдэх шаардлагатай гэдэг ийм тайлбар байсан учраас бид Засгийн газрын хуулийнхаа 17.2-ыг баримтлаад Ерөнхий сайдын түр эзгүйд түүний үүргийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд гүйцэтгэнэ ээ гэдэг энэ заалтын дагуу яг өнөөдрийн энэ цаг хугацаанд Ерөнхий сайдын түр эзгүйд гэдэг үндэслэлээр Тэргүүн Шадар сайд өнөөдрийн мэдээллийг хийж байгаа.

Өнөөдөр Ерөнхий сайд түр эзгүй байгаа учраас энэ мэдээллийг хойшлуулж өгнө үү гэдэг хүсэлтийг эхлээд гаргасан боловч яг энэ цаг хугацаандаа хийх шаардлагатай гэдэг ийм тайлбар байсан. Тэгээд энэ хүрээндээ Засгийн газрын хуулийн 17.2-ыг бариад өнөөдөр Тэргүүн шадар сайд та бүхэнд мэдээллийг хийж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Энэ дээр бас Засгийн газрын зүгээс сар болгоны 4 дэх 7 хоногийн Баасан гарагийн үдээс хойших хуралдаан дээр мэдээлэл хийнэ ээ гээд хувариа өөрсдөө гаргаж ирүүлсэн байгаа. Ямар ямар асуудлуудаар мэдээлэл хийх вэ гэдэг.

Тэгэхээр энэ ажлын төлөвлөлт дээрээ анхаараад, хэрвээ яг энэ цаг үе дээр Ерөнхий сайд байхаар, байх боломжгүй болсон тохиолдолд 7-гоос дээш хоногийн өмнө урьдчилж мэдэгдэх зайлшгүй шаардлагатай юм билээ. Яагаад гэхээр дэгийн тухай хуулиараа Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбоотой материалыг Засгийн газраас Улсын Их Хуралд ирүүлээд, тухайн материалыг парламент мн сайтад байршуулах, Ди парламентаар санал авах, улс төрийн Улсын Их Хурал дахь суудалтай намуудын бүлэг болон Улсын Их Хурлын гишүүдэд мэдээллийг тарааж өгөх энэ ажил нэгэнт процесс эхэлсэн учраас үүнийг хойшлуулах боломж байхгүй болдог ийм талтай байгаа.

Тэгээд Засгийн газрын тухай хуулиар уг асуудал зохицуулагдаад явж байгаа гэдгийг бас Мөнхбаясгалан гишүүнд тайлбар хэлье.

Ингээд мэдээлэлтэй холбогдуулан Ерөнхий сайд болон ажлын хэсгийн гишүүдээс Тэргүүн Шадар сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Монгол Улсын сайд Буяагийн Тулга болон бусад ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, үг хэлэх цөөнхийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Нийт хэлэлцэх хугацаа. Асуулт асууж хариулт авахад цаг 30 минут. 1 цаг 30 минут орно. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүдийн асуулт асуух хугацаа 3 минут, хариулт өгөх ажлын хэсгийн гишүүн 5 минутад багтаж хариултаа өгнө. 1 цаг 30 минутдаа багтахгүй тохиолдолд тэр багтсан гишүүнээр үг хэлэх гишүүд тасална гэдгийг бас урьдчилж анхааруулж хэлье.

Ингээд нэр өгсөн дарааллаар Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна 3 минут.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр та нар бүх хүн бүгдээрээ энэ боомтын хүндрэл ямар байдгийг бүгдээрээ мэдэж байгаа. Яг ковидын үеэр нүүрсний хулгайн ид үеэр 1 машин нүүрс чинь 120 сая төгрөгөөр, 21-хэн километр газар л зөөж байсан шүү дээ. Тэгээд боомтын хүндрэл ямар байдгийг эндээс бүгдээрээ харж байгаа.

Тэгээд өнөөдөр гэхэд л Замын-Үүд дээр бас гоё л байна гээд. Гэтэл сая 11 сарын 1-нээс нөгөө 10 сарын 1-нээс 10 сарын 7-ны хооронд Хятадын баяр болсон. Хятадын баяр буу дуусангуут нөгөө 24 цаг чинь байхгүй болчихсон шүү. 24 цаг байхгүй. Тэгээд машинууд маш их очертой байна. Өнөөдрийн байдлаар Монголын талаас 1650 машин хил дээр оччихсон, очерлочихсон байж байна. Өдөрт гурван зуухан машин гарч байна. Аль аль талаасаа 300-г оруулж гаргаж байна. Тэгээд үүнээсээ болоод нөгөө үнэ нь өсчхөж байгаа юм. Урьд нь бол 9000 юаниар Эрээнээс Улаанбаатар хүрч байсан бол одоо 13000 юань хүрчихлээ шүү дээ. 2 сая төгрөгөөр нэмэгдчихлээ. Хоёрхон өдрийн дотор. Дахиад энэ очер нэмэгдэх юм бол улам их нэмэгдэнэ. Яагаад гэвэл Монголын тэр их хэрэгцээ, ийм их хэрэгцээ, ийм жоохон, тэр Замын-Үүд гэдэг тэр ийм жоохон газраар гарч байгаатай л холбоотой байхгүй юу даа.

Тийм учраас энэ боомтыг олон болгох, боомтын нэвтрэлтийг сайжруулах, олон олон жилд 50-хан машин гаргадаг жишээ нь бай манай Байтагийн боомт байна. Тэрэг байнгын болгох. Тэгээд одоо юу байдаг юм олон олон боомтуудыг нэвтрэлтийг нь сайжруулах тэр ажлыг л хамгийн гол нь хийх ёстой.

Тэгэхээр Тулга сайдаас 1 зүйлийг асууя. Энэ Боомтын тухай хуулиа хурдан оруулж ирээч ээ. Энэ хавар ажлууд эхэлнэ. Түүнээс өмнө боомтын эрх зүйн байдлаа тодорхой болгооч. Энэ хууль дээр чинь АН-ын бүлгээс бас хүмүүс оруулаад, энэ дээр ажиллаад, хурдан шуурхай батлуулах талаар ажиллаж өгье. Энэ олон олон дэлхийн олон улсуудад хувийн хэвшлийн менежменттэй маш их боомтууд маш үр ашигтай ажиллаж байгаа. Яагаад гэвэл төр засаг ажилласан газар тэнд залхуураад, төрийнхөн залхуураад, аль болох бага машин гаргадаг. Гэтэл хувийн хэвшлийн менежменттэй тэр боомтоор бол яавал олон машин гаргаж тэр хураамжаа илүү авах вэ гэдэг л ийм л бодлого явагддаг. Тэр яаж, жишээ нь нүүрс энэ уул уурхайн бүтээгдэхүүнийг чинь бүгдийг нь рентген аппарат болон бусад аппаратаар хүн шаардахгүйгээр шалгадаг ийм боомтуудыг чинь яг тэр хувийн хэвшлийнхэн оруулаад бүгдээрээ хийж байгаа шүү дээ. Тэгээд энэ зүйлүүд дээр хурдан

ажиллахгүй бол ингээд юу байдаг юм, энд тэнд сайжрууллаа гээд л, тэр төмөр замын холболтыг хийлээ гээд л, юу байдаг юм Замын-Үүдийн нэвтрэлтийг сайжрууллаа гээд тэр Монголын ачааллыг чинь барахгүй байхгүй юу даа.

Тийм учраас яг тэр бүс бүс нутгийнх нь ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Буяагийн Тулга хариулт өгнө.

Б.Тулга: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг эрье. Тэгээд саяын илтгэл тавьсан намын бүлгүүдийн төлөөлөлд бас талархал илэрхийлье. Ямар ч гэсэн боомт дээр болж байгаа асуудлууд дээр болохгүй байгааг нь шүүмжлээд, болж байгааг нь бас дэмжсэн агуулгаар үгнүүд хэллээ. Тэгээд бид нар бас маш сайн тэмдэглэж авч энэ тал дээр бас илүү анхаарал хандуулж ажиллана гэдгээ юуны өмнө хэлье.

Тэгээд Пүрэвдорж гишүүний асуусан асуултад хариулъя. Өнгөрсөн энэ хугацаанд энэ Замын-Үүдийн боомтын шалган нэвтрүүлэх цогцолборыг зорчигч тээвэр болон ачаа тээврийн цогцолборыг өнгөрсөн хугацаанд сайжруулж шинээр бүтээн байгуулж дууссан. Ингэж дууссантай холбоотойгоор 2023 оны 6 сард Монгол Улсын Ерөнхий сайд БНХАУ-д хийсэн ажлын айлчлалын үеэр Хятадын боомтын удирдлагуудтай ярьж, энэ Замын-Үүдийн хүчин чадлыг өшөө илүү нэмэгдүүлэх тал дээр ямар шийдвэр гаргаж болох вэ гэдэг дээр хэлэлцээр хийсэн. Үүний үр дүнд 92 оноос хойш бас Замын-Үүдийг 24 цагаар ажиллуулах хүсэлтийг Монголын талаас тавьж байсан Хятадын талаас үүнийг зөвшөөрдөггүй байсан. Тэгээд анх удаа даа бас туршилтыг хийж болох юм гэдэг ийм яриа хэлэлцээрт хүрээд Замын-Үүдийн ачаа тээврийн цогцолборыг 2022 оны 12 сарын 15-наас 30 хүртэл 14 хоногийн хугацаанд буюу ачаалал багатай үеэр 14 хоногийн туршилтыг хийж эхлүүлсэн. Энэ туршилт амжилттай болоод 2 дахь шатын туршилтыг 2023 оны 4 сарын 1-нээс 9 сарын 30 буюу 6 сарын хугацаанд ид ачааллын үеэр бас хийж үзье гэдэг энэ туршилтыг бас явуулсан байгаа. Туршилтын үр дүн сайн гарсан.

Ингээд дараачийнхаа Хятадын талын Хятадын үндэсний боомтын захиргаатай хийх уулзалт дээр энэ Замын-Үүд боомтын ачаалал эдийн засгийн хувьд 24 цагаар ажиллуулах нь сайн байгаа учраас улирлын чанартай 24 цаг байх уу, бүтэн жилийн турш байнгын 24 цаг байх уу гэдэг дээр тодорхой шийдвэрийг гаргаж ажиллахаар бид нар ажиллаж байна.

Ер нь БНХАУ-ын хувьд бол манайх шиг ийм хуурай боомт 180 орчим боомт байдаг. Нийтдээ 14 улстай хиллэдэг. Энэ 180 боомт дотор 24 цагаар ажилладаг ганцхан боомт өнөөдөр байгаа. Манжуурын боомт. Манай Замын-Үүд хэрвээ 24 цагаар ажилладаг болох юм бол Хятадынхаа хувьд 2 дахь 24 цагийн ажиллагаатай боомт болох юм.

Монгол Улсын зүгээс Улсын Их Хурлаас дэмжиж Засгийн газрын боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд Замын-Үүдэд байгаа албан хаагчдыг тэнд ажиллах нөхцөлийг сайжруулж, тоог нэмж, орон тоог нэмж, цалин цавыг нь тус тусгаж өгсөн. Харамсалтай нь зүгээр Хятадын талд бас шийдвэр гаргахдаа манайхыг бодвол бас арай удаан процесстой юм байна лээ. Тэр утгаараа хил гаалийн ажилчдын орон тоо нэмэгдээгүй. Эндээс болоод хил гаалийнх нь Хятадын талын ажилчдын бас жоохон гомдол байгаад байгаа.

Тэгэхээр үүнийг засахаар бид нар ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Тийм. одоо ингээд Замын-Үүд боомт дээр ганцхан ачаалал их байна гэдэгтэй 100 хувь санал нэг байгаа. Ийм учраас энэ бүсчилсэн хөгжлийн бодлоготойгоо уялдуулаад зүүн бүс, баруун бүс гэдэг 2 бүстэй Замын-Үүдтэй дүйцэхүйц хүчин чадалтай ийм боомтуудыг байгуулахаар бид ажиллаж байгаа. Таны хэлсэн Боомтын тухай хуулийн үзэл баримтлал, анхны төслүүдийг бид нар яаман дээрээ боловсруулж гаргасан байгаа. Улсын Их Хурлын дарга дээр ярьж байгаад энэ Боомтын хуулийг богино хугацаанд энэ намрын чуулгандаа багтааж гаргахаар хүсэлтийг тавьсан байгаа. Энэ дээр бас та дэмжиж ажиллана гэж байгаа тул талархал илэрхийлье. Бид тун удахгүй төслийг та бүхэнд төслийн баримт бичгийг бас танд хүргүүлье. Ингэж цаашаа явахаар байгаа гэдгээ хэлье.

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Б.Пүрэвдорж: Төр, засгийн удирдлагууд 2 орны хөршийн удирдлагын яриад байдаг юм, яриад байдаг юм. Тэр доогуур чинь байна шүү дээ, тэр нэг Өвөр Монголчуудаар толгойлуулсан тэр Эрээний мафийнхан байдаг юм. Тэр Баяннуурын мафийнхан. Тэд нар чинь бүгдээрээ Монголчуудын ачаан дээр шимэгчилж амьдардаг нэг хэсэг нөхөд доогуур нь будилуулдаг байхгүй юу. Тийшээ баруун тийшээ болох дээр баруун аймаг руу болох дээр тэр хяналт шалгалт нь чангараад явчихдаг юм. Яагаад гэвэл Шинжань Уйгур луу гарч байгаа учраас.

Тийм учраас та нар энэ боомтынхоо энэ юман дээр хамгийн гол нь тэр боомтыг нэвтрэлтийг нь чөлөөтэй, олон газраар, илүү сайн явуулдаг болж байж тэр янз янзын өрсөлдөх чадварыг бий болгож байж л энэ боомтын чинь нэвтрэлт боомтын бараа бүтээгдэхүүний тэр үнэ, энэ тэр чинь бүгдээрээ буух байхгүй юу даа. Хүнд суртал нь багасах байхгүй юу даа. Энэ ажил дээр голлож та нар онцгойлж ажиллаарай. Тэгээд энэ дээр бас Зам тээврийн сайд Дэлгэрсайхан сайд ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: Манай орон дэлхийн зах зээлээс, далай тэнгисээс хол, газраар, төмөр замаар асар их тийм худалдааны хувьд таатай биш нөхцөлтэй. Энэ нь өөрөө манай улсыг тэр худалдааг хөнгөвчлөх, хурдавчлах энэ дээр үнэхээр бас өөр бодлого баримтлахыг л бид нараас нөхцөл байдал шаарддаг. Өнгөрсөн цаг хугацаанд бас боомт дээр тодорхой хэмжээний ач холбогдол өгч байгааг бас үгүйсгэх боломжгүй.

Мэдээж яг ажлын үр дүн гарахын тулд, ажлын үр дүн гарахын тулд тийм хатуу дэд бүтцийн ажил, цемент арматурын ажлаас гадна бид нарын зөөлөн дэд бүтцийн гэдэг технологи, менежментийн бодлого шийдвэрийн олон ажлуудын хамт дундын үр дүнгээс ажлын үр дүн гардгийг бүгдээрээ л мэдэж байгаа.

Тэгээд өнгөрсөн цаг хугацаанд ингээд ажиглаад байхад төр, засгаас явж байгаа бодлого дээр дандаа л нэг мөнгө төгрөг, хүн хүч нэмчихнэ. Тэгээд үүний ард тэгээд баахан цемент, арматур цутгачихаар болчихдог юм шиг ажилд ханддаг, тэр менежмент технологи гэдэг зүйлд анхаарал хандуулдаггүй учраас өнгөрсөн хугацаанд тэр хэрэгжүүлж байгаа бодит төслүүд нь ямар үр дүнтэй яадгийг бид нар бас өнгөрсөн хугацаанд харж л байна. Нэг 200 км замыг бараг 10 жил барьж байна.

Нэг л цемент, арматур байчихаар л ажил болчихдог гэдэг тэр сэтгэхүй дээрээс ажил эхлэхээр нэг нөхцөл байдал ийм л байдаг.

Ер нь хүн төрөлхтний бас тэр шинжлэх ухааны онол номд нь хөдөлмөр, капитал, технологи гэдэг 3 зүйл хөгжил дэвшлийг авчирдаг юм гэнэ лээ. Бид нар болохоор түүнийг орчуулахдаа, орчуулахдаа хүний тоо нэмээд, мөнгө нэмээд байхаар болчихдог гэж, үндсэндээ энэ сайд нарын багцын төсвийг нэмээд байхаар болчихдог гэдэг нэг ийм л хандлагатай.

Тэгэхээр Тулга сайдаас 1 асуух гээд байгаа зүйл нь яг үүнтэй холбоотой. Яг энэ боомтын сэргэлт гэдэгт тэр бодит ажил цемент, арматураасаа гадна хууль, эрх зүйн хувьд ямар шинэчлэлийг өнгөрсөн хугацаанд хийгдсэн бэ? Хууль, эрх зүйн юм бараг орж ирээгүйг би мэдэж л байна л даа. Тэр худалдааг хөнгөвчлөх чиглэлээр юу хийгдсэн юм. Гадаад худалдааны тэр бодлого шийдвэр, хууль, дүрэм журам маань хаачихсан юм. Боомтын сэргэлтийн хүрээнд 2, 3 хуулийн нэр явж байна лээ. Тээврийн нэгдсэн хууль, Боомтын тухай хуулиудыг өргөн барина гээд бараг 3 жилийн өмнө ярьж байсан байна лээ. Тэр хуулиуд нь хаачихсан юм буюу энэ бодлогын шийдвэр, технологи, менежментийг агуулсан энэ бодлогын шийдвэрүүд энэ зөөлөн гэдэг софт гэдэг энэ шийдлүүд маань хаачсан юм бол оо?

Тэгээд л нэг баахан мөнгө төгрөг, хүн хүч ярьсан нэг ийм л технологитой, нэг ийм л арга барил болчихлоо. Тэгээд очоод цаг хугацаа, тэгээд эдгээрийгээ гоё гоё мега төсөл гэж нэрлэхээд, эдгээр нь тэгээд цаг хугацааны хувьд нөгөө төсөвт өртгүүд нь даблдаж, даблдаж нэмэгдчихсэн, сунжирсан нэг ийм л байдалтай болчихлоо шүү дээ.

Тэгэхээр саяын зүйлүүд дээр тэр зөөлөн дэд бүтэц, технологи, менежмент, бодлогын хувьд ер нь ямар ажил өнгөрсөн хугацаанд хийгдээд, одоо ер нь юунд төлөвлөж байгаа юм, ямар үр дүн хүлээж байгаа юм, ямар үр дүн хүлээж байгаа юм энэ тухайгаа нэг мэдээлэл өгөөч?

Д.Амарбаясгалан: Буяагийн Тулга сайд хариулъя.

Б.Тулга: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Хатуу дэд бүтцийг зайлшгүй ярихгүй бол бас болохгүй байгаа юм. Манайх бас энэ сүүлийн 30 жилийн хугацаанд яг энэ боомтууд руу ер нь Замын-Үүд, Сүхбаатар, Алтанбулаг боомтоос бусад боомтууд нэлээн хоцрогдсон. Сүүлийн үед Гашуун сухайт боомт бол сүүлийн нэг 10-аад жил нэлээн ачаалалтай болж эхэлж байгаа.

Тийм учраас энэ боомтуудын хамгийн анхан шатны байдлаар шалган нэвтрүүлэх цогцолборуудыг хүнийг ажиллах нөхцөлийг нь хангах, олон улсын жишиг рүү дөхүүлж ойртуулах энэ ажил зайлшгүй хийгдэх шаардлагатай байгаа.

Мөн боомтуудыг холбосон авто зам болон төмөр замын бүтээн байгуулалтыг зайлшгүй хийх шаардлагатай. Тийм учраас боомтууд руу бол эхний удаагийн хөрөнгө оруулалт буюу энэ хатуу дэд бүтцээ бий болгох тал дээр ажиллахаас өөр бид нарт арга байхгүй байна.

Таны хэлж байгаа менежментийн хувьд буюу зөөлөн дэд бүтцийн хувьд бас хийгдсэн ажлууд гэж асууж байна. Тэгэхээр би тантай бас 100 хувь санал нэг байна. Тэнд сүүлийн 30 жилийн хугацаанд боомтын хяналт шалгалтын цэг, хяналт шалгалтын шалгалтын үйл ажиллагаа явуулдаг газар гэдэг ийм ойлголт нэлээн

байгаад байгаа. Тэгэхээр үүнийг засах ийм сэтгэлгээний хувьд бас өөрчлөлт оруулах шаардлага байна. Бид бас нэлээн судалгаа янз янзын зүйлүүдийг хийж үзсэн. Ингээд үзэхэд дэлхий дээр бас амжилттай явж байгаа боомтуудын загварыг аваад үзэх юм бол төр, хувийн хэвшил хамтарсан, нэг бол цэвэр хувийн хэвшлийн менежменттэй ийм боомтуудын загвар нь илүү амжилттай, богино хугацаанд төлөвлөлт, хөрөнгө оруулалт, үйл ажиллагаагаа явуулдаг ийм загварууд байна.

Тийм учраас таны дурдаж байгаа Боомтын тухай хуулийг шинэчилж оруулж ирэх үндсэн нэг агуулга зорилт нь бол одоо манай байгаа боомтуудын удирдлагыг корпорац хэлбэрээр, энэ корпорац нь төрийн хяналттай, хувийн хэвшлийн төлөөлөл удирдаж явдаг ийм хэлбэр лүү шилжүүлэх бодлогын хуулийн төслийг Их Хурал руу оруулахаар бэлдэж байна. Энэ хуулийн энэ загвар нь бас Монгол Улсад байгаа манай шинэ нисэх буудал бас Монгол Улсын агаарын хамгийн том буюу ганц ажиллаж байгаа боомт нь байгаа. Энэ боомтын өдөр тутмын үйл ажиллагаа, боомтын өргөтгөл шинэчлэлтийн ажил, төлөвлөлтийн ажлыг Японы компани хариуцаад явж байгаа.

Тэгэхээр энэ агаарын боомт дээр хэрэгжсэн сайн туршлагыг бусад боомтууд дээр хэрэгжүүлэхээр бид бас ажиллаж байна. Үүнээс гадна боомтуудаар нэвтэрч байгаа худалдааг дэмжиж, хурдан шуурхай болох үүднээс технологийн дэвшлүүдийг нэлээн нэвтрүүлж байна. Одоогийн байдлаар бид нар Гашуун сухайт боомт, Шивээ хүрэн боомт дээр жолоочгүй авто тээврийн буюу Эй жи ви-ийн терминалыг бүрэн ашиглалтад оруулж ашиглалтад өгсөн байгаа. Одоогийн байдлаар энэ жилийн хувьд нийт тээвэрлэж байгаа нүүрсний нүүрснээс 3 сая тонныг дангаараа Эй Жи Ви-ээр тээвэрлэж байгаа.

Тэгэхээр үүнийг 24 цагийн ажиллагаатай болгох тал дээр мөн Хятадын талтай хэлэлцээрт орж ажиллаж байгаа гэдгийг та бүхэнд хэлье. Мөн худалдааг дэмжих үүднээс боомтуудыг рентген аппаратаар бүрэн тоноглох энэ чиглэлээр бас ажиллаж байгаа. Ачаалал ихтэй байгаа боомтууд дээр рентген аппаратыг суурилуулж, хяналт шалгалтын хугацааг богиносгох ийм арга хэмжээнүүдийг бас авч байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Цогтгэрэл гишүүнд нэмж 1 минут.

О.Цогтгэрэл: Тэгээд боомттой холбоотой зүйл дээр бас заавал хэлмээр нэг зүйл. Ер нь яг энэ Засгийн газрын 14 мега төслийн хамгийн эхэнд нь Гашуун сухайт Ганц модын хил холболтын цэгийг холбоно. Энэ өөрөө Монгол Улсын 14 мега төслийн хамгийн том нь юм гэж байгаа юм. Магадгүй эдийн засгийн тоо дүн тийм байж бас магадгүй. Гэтэл яг энэ төсөл чинь өөрөө 15 жилийн өмнө хувийн хэвшлийн компани энэ төслийг бариад, бүх асуудлыг нь замаа тавиад холболтоо хийчихнэ гэж байсан төсөл 15 жилийн дараа өнөөдөр зөвхөн түүнийг холбох хэсэг нь Монгол Улсын мега төсөл.

Тэгэхээр Монгол Улс урагшлаад байгаа юм уу, ухраад байгаа юм уу гэдэг. Тэгээд үүнийгээ тайлбарлахдаа энэ мега учраас, энэ том учраас үүнийг төр л хийхгүй бол өөр хэн ч хийж чадахгүй гэдэг суртал ухуулгатай. Гэтэл үүнийг чинь 15 жилийн өмнө зураг төсөл, санхүүжилт олон зүйл нь шийдэгдээд явж байсныг бид нар төрд булааж аваад л өнөөдөр 15 жилийн дараа мега төсөл номер нэг мега төсөл төр хийх ёстой гэдэг нэг ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууна. Асуулт асууж үг хэлнэ.

Ж.Баярмаа: Мэдээж, эдийн засагт бол олон улсын худалдаа маш чухал. Дэд бүтэц маш чухал. Мэдээж олон улсын худалдааг хөгжүүлэх, ялангуяа хил орчмын худалдааг хөгжүүлэхэд бол боомтын асуудал бол маш чухал. Тэгэхээр энэ бол бодитоор манай эдийн засагт маш том чухал хүчин зүйлс болдог.

Тэгээд энэ дээр яах вэ, “Шинэ сэргэлтийн бодлого” гээд 6 зорилт тавьсны 1 нь энэ боомтын сэргэлт юм байна лээ. Тэгэхээрээ бас мэдээж энэ зорилтдоо зөв зүйтэй зүйл бол тусгасан байна. Гэхдээ мэдээж сая ч зөндөө ярьж байна. Нөгөө боомтын сэргэлт маань яг юу болж байна аа? Сэргэж байна уу, үгүй юү гэдэг асуудал байнга тавигдаж байгаа. Ялангуяа энэ чинь нөгөө иргэдийн аж амьдралтай холбоотой. Тэр Тяньжин боомт дээр хэдэн мянгаараа чингэлэг гацаж байгаа энэ нөхцөлд бол энэ чинь эргээд нөгөө нийлүүлэлтээс үүдэх инфляцад нөлөөлж байгаа гээд ингээд аягүй олон үр дагаврууд байгаа учир энэ боомтын нэвтрүүлэх чадал энэ тэр дээрээ маш онцгой анхаарал хандуулж ажиллах нь бол чухал юм. Тэгэнгүүт жишээлбэл Хятадаас гэхэд чинь 2 чингэлгээр бараа нэвтрүүлдэг байсан бол 1 болгосон энэ тэр гээд нэг багасгаад байгаа энэ тэр тийм мэдээллүүд бол байдаг.

Тэгэхээр нэг 2 асуулт асуух гэсэн юм. Тэгэхээр мэдээж манайх чинь газар зүйн байршлын хувьд хоёрхон оронтой бол хиллэж байгаа. Тэгэхдээ тэр бол бас ашиглаж болохуйц ийм бас хүчин зүйлс мөн. Тэгэхээр бодлогын хувьд энэ 2 хөрштэйгөө энэ боомтоо хөгжүүлэх тал дээр ямар ажил хийж байгаа юм бол оо, яаж хөгжүүлэх вэ гэдэг дээр арга хэрэгслээ тохирсон юм болов уу? Яагаад гэвэл тэд нараас бас бүрэн хамаараад байна шүү дээ. Зөвхөн бид энд хийчхээд хэдэн тэрбум төгрөгийн төсөв тавиад, 2 хөршөөс хамаарч байгаа учир энэ их чухал фактор. Тэгэхээр энэ 2 хөрштэйгөө энэ бодлого дээрээ тэд нарын бодлоготой уялдуулсан ч юм уу, нийцүүлсэн, тэгээд хамтарч энэ арга хэрэгслээ тодорхойлсон зүйл байна уу? Байгаа бол энэ нь ямар олон улсын гэрээ хэлэлцээрээр баталгаажсан юм бол оо, тийм юм байна уу?

2-т, мэдээж энэ чинь боомт бүрээр гарах тэр эдийн засгийн үр ашгийн тооцоолол гэж байгаа. Тэгэхээр гарах зардал, хөрөнгө оруулалт, үр ашгийн тооцоолол гэж байгаа юу? Яагаад гэхээр энэ чинь бүх юманд үр ашиг байх ёстой, эдийн засгийн тооцоолол. Тэгэхээр энэ тооцоолол нь хийгдсэн эсэх, тэгээд хэрхэн үр ашгийг нь тооцоолсон юм бол оо гэсэн ийм 2 асуулт байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Буяагийн Тулга сайд хариулъя. Дараа нь Борхүүгийн Дэлгэрсайхан сайд нэмж хариулна.

Б.Тулга: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр боомтын асуудал бол олон улсын худалдааны асуудал гэдэгтэй 100 хувь санал нэг байна. Тэгээд олон улсын худалдааны асуудал учраас 2 талаас харилцан тохиролцож, зэрэг төлөвлөж, стратегиа тааруулж байж, хэн юу худалдаж авах вэ гэдгээ бас шийдэж байж энэ боомтын хөгжлийг цааш нь ярих ёстой гээд, тэгээд 100 хувь санал нэг байна.

Тяньжин боомт дээр гарч байгаа ачаалал энэ жилийн хувьд бас нэлээн ачаалал болсон. Тэгэхдээ энэ дээр хэд хэдэн шалтгаан байгаа юм. Яг Монгол Улсын боомт дээр байгаа ачаалал буюу Замын-Үүд дээр татаж байгаа чингэлэг, түүн дээр нэвтрүүлж байгаа хүчин чадлын хувьд харьцангуй ачаалал энэ жилийн хувьд бол

гайгүй байсан. Ер нь та бүхэн анзаарсан энд, зун Замын-Үүд дээр үүсдэг байсан ачаалал ер нь байхгүй болсон гэж хэлж болно.

Харин 10 сарын 30-наас хойш энэ ачаалал бага зэрэг нэмэгдсэн байгаа. Энэ бол нөгөө 24 цаг ажиллагаа түр зогссонтой холбоотой ийм ачаалал байгаа юм шүү. Тяньжин дээрх чингэлгийн тоо энэ жил эрс өссөн. Энэ юунаас холбоотой вэ гэвэл Бүгд найрамдах Япон улсад ханшийн уналт болж, бараа бүтээгдэхүүн хямдарсантай холбоотойгоор бас Монголын иргэд, худалдаачид ихээхэн хэмжээний автомашиныг бас бусад урьд жилүүдээс илүүтэй татсан, өсөлт нэлээн ажиглагдсан. Эргээд Монгол руу орж ирээд Монгол талдаа буюу Улаанбаатарт, Сайншандад бусад суурин газрууд, төвүүд дээр нөгөө галт тэргээр орж ирсэн чингэлэг тээврийг процесс буюу шингээж авч, тэд нарыг боловсруулаад, яаралтай чингэлгээ суллаад, вагоноор буцаах энэ үйл ажиллагаа дутагдалтай байсан. Монгол Улс Улаанбаатарыг аваад үзэх юм бол нэг галт тэрэг бүтэн оруулж ирээд боловсруулалт хийгээд, буцааж өдөрт нь буцаах ийм чадалтай логистикийн төвүүд байхгүй байгаад байгаа.

Тийм ч учраас тэр түрүүний эдийн засгийн олон улсын эдийн засгийн хамтын байгууллага дээр хуурай боомтоор зөвхөн Сайншанд Замын-Үүдийг бүртгүүлэхээс гадна Улаанбаатарт дор хаяж 2-3 ийм тийм логистикийн төвүүд, хуурай боомтуудыг байгуулж байж, энэ чингэлгийн ачаалал хурдан хугацаанд буурах ийм бололцоо үүснэ. Энэ жилийн хувьд дундаж, та нөгөө 2 чингэлэг гэж яриад байх шиг байна. 2 галт тэрэг өдөрт татдаг байсан энэ тоо харин энэ 4 сараас хойш нэлээн бууж, одоогийн байдлаар 2 луугаа дөхөж байгаа. 1 сард 2,4 цуваа буюу 2,4 галт тэрэг татдаг байсан. Энэ маань 4 сараас эхлээд 1,6 руу унасан. 6 сард 1,1 болж унасан, одоо өсөөд 9 сарын байдлаар 1,6, 10 сард 1,6 галт тэрэг буюу 50 вагон татаж байна гэсэн үг. 1 галт тэрэг нь. Тэгэхээр энэ чингэлгийн ачаалал буураад явна. Яг одоогийн байдлаар 4000 орчим, 4090 чингэлэг 10 сарын 18-ны байдлаар 4000 орчим чингэлэг байна. Энэ нь хэвийн хэмжээнд байж байдаг, 2-3 мянгаас мянга орчим чингэлгээр илүү байгаа юм.

Тэгэхээр энэ цаашаа буураад явна гэдэгт эргэлзэхгүй байна.

2 хөршийн боомтын захиргаатай Боомтын сайдын ажлыг аваад энэ Монгол Улсаас Боомтын Үндэсний хороог сайдтай болгосны дараа бол дараагаас нэлээн идэвхтэй хамтын ажиллагааг өрнүүлж байгаа. Жил болгон энэ 2 улсын боомтын менежментийн комиссын хурал болдог. 23 оны хурал 23 онд 9 сард БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод Хятадын боомтын үндэсний захиргааны удирдлагуудтай миний бие очиж комиссын хуралдаанаа хийсэн. 40 асуултыг бол 40 асуудлыг шийдвэрлэхээр харилцан тохиролцож, протоколоор тохирсон. Одоогийн байдлаар энэ 40 асуудлаас 36 асуудал нь үр дүн гарсан, хэрэгжилт бүрэн байгаа.

24 оны хурал Хятадын талаас товоо өгөөгүй байгаад байна. Хятадын талын бас боомтын удирдлагад өөрчлөлт орж байгаа гэдэг мэдээлэл бидэнд байгаа. Тэгээд энэ удирдлага нь шинэчлэгдэхээр энэ ондоо багтаад хийх төлөвлөгөөтэй ажиллаж байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

Зөвхөн Бээжинтэй ингэж харьцахаас гадна бид ӨМӨЗО-той, Шинжаан Уйгарын ӨЗО-той, энэ өөртөө засах орнуудтай бас шууд харилцах энэ механизмыг бий болгож өгсөн. Сая өнгөрсөн 8 сард ӨМӨЗО-ны боомтын зөвлөлтэй манай хилийн боомтын захиргаа хамтарсан хурлыг Өвөр Монголын Хянган аймагт очиж бас хуралдаад тодорхой асуудлуудыг тохирч ирсэн.

Саяын Шадар сайд, Ерөнхий сайдын мэдэгдэлд гарч байгаа цагийн хуваарийн өөрчлөлтүүд, боомтын 2 талаас уулзах төмөр замын цэгүүд, мөн боомтоор нэвтрэх ачаа бараа, тээвэр логистикийн төвүүдийг уялдуулах тал дээр энэ механизмуудаараа дамжиж хэрэгжүүлдэг байгаа. Энд манай Гадаад яам, Эдийн засгийн яам, Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Зам, тээврийн яам гээд бүтэн төлөөлөл энэ комисст бас орж ажилладаг гэдгийг та бүхэнд дуулгая.

Ер нь цаашлаад бид нар бол зөвхөн боомтын цогцолборын барилгыг барьж байгуулж дуусаж байгаа. Цаашлаад энэ нутгийн иргэдэд өгөөжтэй, хүртээмжтэй байх, тухайн боомт хот, боомт, сумыг бас энэ төлөвлөлтөд оруулах ерөнхий мастер төлөвлөлтүүдийг хийж байгаа. Одоогийн байдлаар Гашуун сухайт, Шивээ хүрэн боомтын мастер төлөвлөгөө хийх тендерийг зарлаад, компаниуд нь шалгараад явж байгаа. Энэ төлөвлө ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд нэмж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Баярмаа гишүүний асуултад нэмж хариулъя. Энэ ЗТЯ-наас холбогдуул, энэ чингэлэг хуримтлагдаж байгаатай холбогдуулаад Хятадын тээврийн сайдтай өнгөрсөн сард уулзалт хийсэн. Тэгээд ямар ч байсан үүнийг сайжруулаад үндсэндээ бол одоогийн байдлаар Тяньжин боомт дээр 316 чингэлэг байна. Өмнөх 8 сард бол 5000 гаруй чингэлэг байсныг 1,7 галт тэрэг болгосноороо ингээд 2000 гаруй чингэлгийг татсан. Энэ чингэлэг нийт чингэлгийн 70 хувьд нь бол дандаа автомашин байгаа. Бид автомашины энэ чингэлгийг хурдан буцаахын тулд автомашины гаалийг болон энэ чингэлгийг хот руу оруулж ирэхгүйгээр, Замын-Үүд дээр шууд буулгах, тэнд нь гаалийн бүрдүүлэлт хийх ийм шийдвэр гаргаад, тэгээд машинуудыг Замын-Үүд дээр ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Эзэнд нь хүлээлгэж өгөх ажлыг зохион байгуулснаар чингэлгийг хурдан буцаах ийм боломжтой болж байгаа. Нэн тэргүүнд бол урд хөрштэйгөө ярьж байгаа юм бол үлдсэн 30 хувь нь бол дандаа хүнсний бүтээгдэхүүн болон бусад ачаа бараа байгаа учраас энэ ачаа барааг хурдан түргэн оруулж ирэх дээр бас бид хоорондоо ярилцаж байгаа.

2 дахь далайн боомтын асуудлаар ЗТЯ-ны Далайн боомтын захиргааны удирдлагуудыг явуулж, Леонон мужийн Жинжүү боомтыг нэмэлтээр ашиглахаар ярилцаад, ингээд эхний хэлэлцээр хийгээд ингээд явж байгаа гэдгийг нэмэлтээр хэлье. Баярлалаа, та бүхэнд.

Д.Амарбаясгалан: Ринчиндоржийн Батболд гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Р.Батболд: Өдрийн мэнд. Та бүхэнд. Энэ боомт нэвтрүүлэлтийн талаар ярьж байгаа учраас нэг ганц зүйл асуучихмаар санагдаад байна. Энэ бид нар чинь нөгөө нүүрсээ төмөр замаар тээвэрлээд, тэрийгээ холбож чадахгүй хил дээр очиж зогсчихоод байдаг. Тэгэхээр энэ Эрдэнэс тавантолгой нүүрсээ ачих, тэгээд түүнийг төмөр замаар тээвэрлэх, цааш нь нэвтрүүлэх энэ асуудлыг Эрдэнэс тавантолгой, ЗТЯ, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны яг хэн нь хариуцаж ажиллаад байдаг юм бэ гэдэг 1 асуулт байгаа юм. Энэ та нар нэг хоорондоо учраа олохгүй яваад байдаг юм уу? Энэ Эрдэнэс тавантолгойгоос ачигдаж очсон вагонтой нүүрс хил дээр очоод 40 хоносон гэж байгаа юм. Тэгээд ингээд яагаад тэгдэг юм гэхээр энэ зөвшөөрлөө авч чаддаггүй, 1 дүгээрт.

2 дугаарт гэх юм бол нөгөө ачигдаад 4 цаг яваад очиж байгаа нүүрс чинь автомашинд ингээд сэлгэн ачигдаад, тэгээд цаашаа гарах гэхээр нөгөө Тавантолгойгоос шууд очиж байгаа автомашинуудынхаа араас нь очерлоод гар аа гэдэг ийм асуудал үүсчихдэг. Энэ тэгэхээр, энэ хэн нь хариуцаад байгаа юм, хариуцаж байгаа хүн нь энэ шинэ терминал үүсгээд, энэ вагоноор очиж байгаа ачаагаа шууд гардаг шинэ терминал үүсгэж болдоггүй юм уу. Үүнийгээ нэг шийдээч ээ гэдэг асуудал байгаа юм.

2 дугаарт гэвэл энэ тэр вагоноор очсон ачааг чинь цааш нь гаргаж байгаа энэ тээврийн үнэ тарифын асуудал ёстой замбараагүй үнэтэй юм байна лээ шүү дээ. Нэг цуваа вагоныг цааш нь гаргаад, гаргасан тэр компани нь 195 сая төгрөгийн нэхэмжлэх өгч байна гэж яриад байгаа юм. Энэ арай дэндэж байгаа юм биш үү? Энэ цаашаагаа энэ нэг уул нь нэг арваадхан километр газар юм шиг байна лээ шүү дээ. Бараг ирж очихын 10 байдаг юм уу, үгүй юү.

Тэгэхээр энэ асуудлыг ер нь яаж шийдэх юм. Яг хэн нь мэдээд байгаа юм. Энэ дээр нэг хариулт өгөөч. Ерөөсөө 3 бие рүүгээ шидээд энэ зөвшөөрөл нь байхгүй 40 хоночихдог энэ асуудлыг яаж шийдэх юм.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Батболд гишүүний асуултад хариулъя. Ер нь бол Тавантолгой, Эрдэнэс тавантолгойн хувьд бол нүүрсээ экспортлох нь гол үүрэг. Дээрээс нь Тавантолгой төмөр зам барьсан, түүнийг ачиж буулгах терминал барьсантай холбогдуулан бид нар бас энэ төмөр замаа үр ашигтай явуулах үүднээс төмөр замаар тээвэрлэлт хийж байгаа. Харамсалтай нь төмөр замаар хийж байгаа тээвэрлэлт маань шууд холболт хийгдээгүй учраас ахиад машинаар дамжиж цаашаа хил гарч байгаа гэдгийг 1 дүгээрт хэлье.

2 дугаарт бол таны саяын хэлсэн шиг 195 сая төгрөг болж байгаа ийм юм бол байхгүй. Ер нь бол яах вэ, зүгээр ковидын үед бол ийм үнэ хүрч байсан гэж яригддаг. Одоо бол ямар нэгэн байдлаар бол машины үнэ, тээвэр нэмэгдсэн юм байхгүй. Харин С зөвшөөрөлтэй холбоотойгоор ковидын үед энэ С зөвшөөрөл Эрдэнэс тавантолгойд шилжсэнтэй холбогдуулан ийм хүндрэл бол эргээд гарч байгаа учраас 1 дүгээрт, Хятадын тал бол С зөвшөөрлийг Монгол Улсын төрийн төв захиргааны хариуцсан төв байгууллагатай гэрээ хэлэлцээр хийсэн учраас цаашид бол хэрвээ ингээд компани энэ С зөвшөөрлөө ингээд цаашдаа олгоод явбал бид нар 25 онд дахиж гэрээ хийхгүй гэж мэдэгдэл ирүүлсэнтэй холбогдуулаад, ирэх 7 хоногийн Засгийн газрын хуралдаанаар энэ асуудлыг шийдвэрлэхээр бэлдэж байгаа гэдгийг албан ёсоор хэлье.

Тэгээд цаашдаа бол бид аль болохоор төмөр замаа хурдан түргэн холбох, энэ чиглэлээр сая Монгол Улсын Ерөнхий сайд болон миний бие Хятадын талын төмөр замын холболтыг хариуцаж байгаа Чайна Энержи компанитай уулзаж, энэ асуудал нэлээн урагшилсан. Ямар ч байсан бид бол бас энэ эрчээрээ явмаар, энэ улиралдаа бол гэрээ хэлэлцээр эцэслэж, 2 талаасаа ажлын хэсэг бас энэ тохирсон ёсоороо ирэх хавар бүтээн байгуулалтын ажил эхэлнэ ээ гэдгийг энэ ташрамд хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Буяагийн Тулга сайд нэмж хариулъя.

Б.Тулга: Батболд гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Тавантолгой төмөр замын шилжүүлэн ачих терминал 24 оны 8 сард ашиглалтад орсон. Ингээд ашиглалтад орсон. Тэгэхдээ цаашаагаа Хятадын талтайгаа энэ холбогдоогүй төмөр зам байгаа учраас энэ төмөр зам дээр дахин шилжүүлж ачаад, цаашаа гарахад зардлын хувьд яалт ч үгүй өндөр байгаад байгаа.

Тийм учраас энэ проблем бол шинээр гарч ирж байгаа юм. Тэгэхээр бид нар энэ мөрдөгдөж байгаа түр журмыг цаашдаа шинэчилнэ. Ингэж шинэчлэхдээ энэ төмөр замын бас нэгэнт баригдсан байгаа төмөр замыг дэмжих чиглэлийн бас бодлогыг оруулж тооцож бас явна гэдгээ энэ ташрамд хэлчихье. Энэ бол шинэ асуудал 24 оны 8 сард төмөр зам ашиглалтад орсонтой холбоотойгоор тэр төмөр замаар тээвэрлэж байгаа ААН, компаниудаас гарч байгаа ийм хүсэлтүүд байгаа. Үүнийг шийдэх ёстой. Эцсийн дүндээ энэ асуудал бүрэн хэзээ шийдэгдэх вэ гэхээр энэ яригдаж байгаа төмөр замын холболт бүрэн хийгдчих юм бол заавал ч үгүй энэ дахиж шилжүүлэн ачилгүйгээр, цаашаа явах ийм бололцоо бүрдэх юм байгаа юм.

Д.Амарбаясгалан: Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Г.Ганбаатар: Яах вэ, тэгээд 1 нь мэдээлэл хийсэн болж нөгөө нь сонссон болоод энэ мэдээлэл ч нэг тийм хариуцлагагүй л юм.

Улсын Их Хурлын дарга цаашдаа энэ тал дээрээ анхаарах хэрэгтэй. Засгийн газар ч гэсэн ажлаа төлөвлөөд Улсын Их Хуралдаа хүндэтгэлтэй хандах хэрэгтэй. Уг нь миний асуулт бол яг Монгол Улсын Ерөнхий сайдаас өөрөөс нь асуух асуулт байсан юм. Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ 2022 оны 5 сарын 27-ны өдөр Өмнөговь аймгийн ард иргэдтэй уулзахдаа Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутагт тэр Цагаандэл уулын боомтоор шинэ боомт нээх үйл ажиллагааг түдгэлзүүлсэн гэж олны өмнө хэлсэн байдаг юм. Тэр бичлэг, зураг бүх юу нь байгаа юм. Гэтэл одоо тэр боомтын үйл ажиллагаа нь явагдсаар бараг дуусаж байгаа бололтой. Энэ талаар би энэ сарын эхэнд, 10 сарын 1-нд Ерөнхий сайдад нэг асуулт тавиад хариултаа авсан юм.

Тэгээд уг нь өнөөдрийн энэ мэдээллийнх нь цаг дээр өөрөөс нь асууя гэсэн, байхгүй байна. Ямар Гантөмөр даргаас асуулттай биш аль 22 оны юмыг. Хамгийн гол нь яах вэ, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын тэргүүн хүн нэг тийм заалны уур амьсгал харчхаад, худлаа яриад байж болохгүй л дээ. Өмнөговь аймгийн иргэдэд худлаа ярьсан. Одоо тэгээд боомт нь бараг ашиглалтад орж байна. Тийм юм бол үнэхээрийн боломжгүй байгаа бол тэр уучлалаа хүсээд энэ боомтын талаар ямар үйл ажиллагаа, ямар бодлого явуулж байгаагаа олон нийтэд нь хэлэх хэрэгтэй шүү дээ. Тэгээд яах вэ, энэ үүнтэй холбоотойгоор ер нь өнгөрсөн жилийн Засгийн газар энэ боомттой холбоотойгоор Засгийн газраас нэг 2 ажил хийж чадаагүй. Дутуу юм билээ. Нэг нь тэр Гашуун сухайтын төмөр замыг холбох, нөгөө нэг энэ сая Цагаандэл уулын боомтыг ашиглалтад оруулах асуудал. Үүнтэй холбоотой тэр Тулга сайд нь байна уу, энэ улсууд нь энэ Өмнөговь аймгийн ард иргэдэд тэр Ерөнхий сайдын түдгэлзүүлсэн нь худлаа шүү, боомт бараг дуусаж байгаа. Үүнийгээ бодитой мэдээлэл өгөх хэрэгтэй. Энэ мэдээллийнх нь цаг дээр. Уг нь яах вэ өөрийг нь байвал бас нэг асуух асуулт байсан юм.

Тэгээд нэгэнт боомт нь ашиглалтад ороод дуусаж байгаа бол үүнийгээ тэгээд түргэн төр ажил төрлөө бодсон нь дээр шүү дээ. Тэгээд Тулга сайд энэ талаараа мэдээллээ одоо үүнийг энэ мэдээллийнх нь цаг дээр өгчихсэн нь зөв байх.

Д.Амарбаясгалан: Буяагийн Тулга сайд хариулт өгье.

Б.Тулга: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутагт байх Цагаандэл уул боомтын асуудал шинэ хэрэгжсэн асуудал биш юм билээ. Энэ 14 оны 2 сарын 21-ний өдрийн Засгийн газрын тогтоолоор энэ боомтыг бас нээх шийдвэр гарч. Монгол Улсын өндөр дээд түвшний БНХАУ-тай хийсэн уулзалтууд дээр бас ярьж баталгаажуулж 2 талаас тохирсон асуудал юм байна лээ. Энэ боомт маань бас л ялгаагүй. Нөгөө Гашуун сухайт дээр тохирсноосоо Монголын тал ямар нэгэн байдлаар буцах ийм нөхцөл байдлыг бас үүсгэж болохгүй байгаад байгаа.

Тийм учраас Монголын Засгийн газар хэн нэгэн даргын гэдэг юм уу үед л байдаг Засгийн газар биш байнга үйл ажиллагаагаа тасралтгүй хувилж байх ёстой. Тэр үүднээсээ 14 онд, 18 онд, 19 онд, 24 онд гээд маш олон Засгийн газрын тогтоол шийдвэрүүд гарсан байдаг. Үүний хүрээнд энэ Цагаандэл уул боомтыг үйл ажиллагаанд оруулахад байгаль орчинд бас ээлтэй байх, Гашуун сухайт дээр гарсан алдааг давтахгүйн тулд авто замыг нь түрүүлж барьсны дараа энэ боомтыг ажиллуулах ийм шийдвэрүүдийг гаргасан байдаг. Энэ утгаараа бас энэ авто замыг барих концессыг 19 онд зарлаад, ААН нь шалгараад, үйл ажиллагаагаа эхлүүлэхэд бас бэлэн болчихсон байгаа. Энэ дээр Ерөнхий сайд очоод 22 онд хийсэн уулзалт дээр байгаль орчинд нөлөөлөх ийм нөлөөлөл байгаа учраас энэ дээр бас анхаарч үзээч гэсэн ийм хүсэлтийг нутгийн иргэдээс тавьсан байдаг. Тэр үед түдгэлзүүлээд, энэ чиглэлээр нутгийн иргэдтэй уулзах, байгаль орчинд нөлөөлөх байдлыг хамгийн багаар байлгах энэ шаардлагуудыг тэр боомт руу зам тавьж байгаа ААН-д бас үүрэг болгож өгсөн байдаг. Надад энэ асуудлыг бас бүх говиос сонгогдсон гишүүд, говийн сумдын төлөөллийг оруулаад энэ асуудлыг хэлэлцэх ийм үүрэг чиглэл өгсөн байгаа.

Тэгээд нарийвчилсан үнэлгээ гээд бусад нөгөө зураг төсөл эцэслэн гарахыг нь бол бид нар хүлээж байгаа. Тэгээд удахгүй бас энэ өмнийн говийн зөвлөлийг хуралдуулж, энэ асуудлыг бас эцэслэн шийдвэрлэнэ. Ер нь бол Монгол Улс түрүүн бас Баярмаа гишүүний үгэнд гарлаа. Хөрштэйгөө, түнштэйгээ ярьсан яриа хэлэлцээрээ бас хэрэгжүүлэх тал дээрээ байхгүй бол “за” гэж нэг өдөр тохирчхоод хэсэг хугацааны дараа энэ бол боломжгүй юм гэж явах юм бол нөгөө Гашуун сухайтын алдаа бас давтагдана гэдгийг та бүхэнд хэлье.

Боомтын бүтээн байгуулалт бас мэдээлэл өгөхөд, боомтын бүтээн байгуулалт эхлээгүй, зураг төсөл батлагдаад, байгаль орчны үнэлгээ хийгдээд дууссан байгаа. Боомтын бүтээн байгуулалтыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах энэ зүйлүүд бол явагдаж байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

Тэгээд энэ Цагаандэл уул боомтын барилгын ажлыг эхлүүлэх энэ шийдвэрийг Өмнийн говийн зөвлөлөөс гаргаад, цааш нь явуулах нь зүйтэй байх гэдэг ийм зүйлийг хэлье. Ер нь бид нар Монгол Улс бас энэ Эрдэнэс тавантолгойг уурхайд түшиглэсэн эндээс гарч байгаа уул уурхайн бүтээгдэхүүнээ үнэ цэнтэй байлгах тал дээр бас бодолцох ёстой. Одоогийн байдлаар бид нар Эрдэнэс тавантолгойн нүүрсийг зөвхөн Өвөр Монголын Баяннуур аймгаар дамжуулж БНХАУ-ын зах зээлд бусад мужууд руу хүргэж байгаа.

Тэгэхээр энэ Цагаандэл уулын боомт нь Рашаан аймагтай хиллэдэг ийм боомт байгаа. Тэгэхээр бид нар бас өөрийнхөө үйлдвэрлэж чадаж байгаа бараа бүтээгдэхүүн уул уурхайн бүтээгдэхүүнийг илүү үнэ цэнтэй болгох, нөгөө биржээр арилжаалахад бас 2 өөр аймгаас өөр ААН-үүд орж ирж, манай бүтээгдэхүүнийг

худалдаж авч өрсөлдөх чадвартай болох гэдэг үүднээсээ энэ Цагаандэл уулын боомт нь бас их онцгой ач холбогдолтой ийм байгаа. Өөрөөр хэлбэл аль нэг цөөн нэг аймгийн нэг худалдан авагчаас хамааралтай байдаг энэ хамаарлыг байхгүй болгоход маш чухал үүрэгтэй боомт бол Цагаандэл уул боомт, Ханги боомт байгаа гэдгийг энэ ташрамд бас хэлмээр байна.

Тэгээд асуулгын хариултыг бол танд өгсөн. Шаардлагатай бол бид нар бусад мэдээллийг бас танд детальчилж өгөхөд бас бэлэн байгаа гэдгийг хэлье. Баярлалаа танд.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Батбаатар: Боомтын нэвтрэлт бол мэдээж тээвэрлэлт болон зорчигч тээвэр гээд 2 зүйл байж байна. Энэ томоохон корпорацууд болон гаднын хөрөнгө оруулагчдын хажуугаар жижиг, дунд үйлдвэр, мөн арилжаа наймааны шугамаар явж байгаа хүмүүс, эд нарын энэ нэвтрэх боломжийг нэг ёсондоо иргэдийнхээ амьдрахын төлөө тэмцэж яваа тэр зүйлд нь боомтын нэвтрэх боломж дээр их хүнд харагддаг юм байна лээ. Бөөн уур бухимдал. Тэр чиглэл рүүгээ манай боомтууд хэр ажиллаж байгаа юм. Гол гол боомтууд. Ачаа тээвэр бол мэдээж төмөр зам болон машин авто хэрэгслээр ингээд явж байна. Иргэдийгээ чөлөөтэй, хурдтай, тогтвортой, их хөнгөн шуурхай нэвтрэх тал дээр юу хийгээд байна аа? Үүнийг бол иргэд илүү их сонирхож асуух байх. Маш олон өрх гэр, айл үр хүүхдийн амьдрал үүний ард явж байгаа. 1 дэх асуулт.

2-т нь, Засгийн газар боомтыг сайжруулах ажлын үр нөлөөгөө цаг хугацааны явцад хэрхэн хянаж байгаа юм. Тэгээд энэ боомтын сэргэлт, сэргээн босгох ажил нь Худалдаа эдийн засгийнхаа хөгжлийн зорилтод нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахдаа ямар хэмжүүрийг ашиглаж, ийм хэмжүүрээр эд нар нь нийцэж байна, нийцэхгүй байна гэдэг тухай ярьж байгаа юм бэ гэдэг зүйлийг бас асуумаар байна.

3-д нь, Засгийн газар боомтуудынхаа сэргээн засварлах энэ төслүүд, санхүүжилтүүдээ ямар чиглэлээр хийж байгаа юм. Ялангуяа нөгөө чөлөөт бүсүүд гэж байж байгаа. Чөлөөт бүсүүдийн идэвхтэй бөгөөд зөв үйл ажиллагаа бол их олон нэвтрэх, их олон энэ боомтын асуудлуудыг шийддэг, иргэдэд бас ээлтэй тусах боломжууд, иргэдийн амьдралд сайнаар тусгах боломжууд байж байгаа. Сүүлийн 10 гаран жил, 10 хэдэн жил үндсэндээ чөлөөт бүсийн асуудал яригдсан. Манайд энэ Алтанбулагийн, Замын-Үүдийн чөлөөт бүсүүдийн асуудлууд бол олигтой үр дүнд хүрээгүй шүү дээ.

4 дэх асуудал нь, энэ дэд бүтцийн дагуу буюу төмөр зам дагууд, авто зам дагууд, хил гаалийн шалган нэвтрүүлэхүүдийг нь ингээд өгчих юм бол зөвхөн Замын-Үүдэд ачаа чингэлэг задардаг, үгүй бол Улаанбаатарт задардаг биш, зам дагуу байгаа өртөө, суурин газрууд аль нэг дээр нь хэд хэдэн ийм терминалуудыг хийчих юм бол бас ачаа тээвэрт болон хурд нь, нэвтрэлтийн чадвар нь өөрчлөгдөнө. Энэ тухай ямар нэг санаачилга байна уу?

Тяньжин д байгаа түрээсэлж авсан газар 10 гаран жил гацлаа. Тэр яагаад ашиглагдахгүй байгаа юм? Тэр ашиглагдвал бас Тяньжин дээр тэр олон ачаа тээвэр гацахгүйгээр Хятадад авто замаар болон бусад замаар хурдан шуурхай тээвэрлэх бол ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Буяагийн Тулга сайд.

Б.Тулга: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр ачаа тээврийн терминалаас гадна бас жирийн иргэдийн зорчих хөдөлгөөн дээр анхаарал хандуулж байгаа юу гэж асууж байна тийм ээ? Тэгэхээр Замын-Үүд боомт ашиглалтад орсноор зорчигч тээврийн хүч хүчин чадал 6-4 дахин нэмэгдсэн. Одоо та бүхэн анзаарах юм бол манай бас гол зорчигч тээвэр явдаг Замын-Үүд боомт бол зорчигч тээврийн терминал нь тусдаа, ачаа тээврийн терминал нь тусдаа байгаа. Очоод үзэх юм бол яг өнөөдөр газар дээрээ Монголын тал буюу Замын-Үүд талдаа зорчигч тээвэр дээр ямар нэгэн хүндрэл байхгүй байгаа.

Эрээний тал дээрээ бол бас хүндрэлүүд гарч байгаа. Яагаад гэвэл Эрээний боомтын хүчин чадлаас хамаараад зарим тохиолдолд Эрээний боомт руу орох хилийн дундын зурвас дээр ачаалал үүсдэг. Ийм бол байгаа.

Дээр нь зорчигч тээврүүд жирийн иргэдэд ялангуяа хамгийн ач холбогдолтой байдаг 8-аас доош суудалтай автомашин нэвтрэх асуудал ковидын дараа нэлээн хаалттай байсан. Үүнийг бас манай ЗТЯ, Гадаад хэргийн яам, Боомтын сэргэлтийн Үндэсний хороо нэлээн ажилласны үр дүнд ихэнх боомтуудаар 8-аас доош суудалтай, ялангуяа Өвөр Монголтой хиллэдэг бүх боомтуудаар 8-аас доош суудалтай автомашин хэвийн зорчиж байгаа. Энэ нь жирийн Замын-Үүдэд амьдардаг гэдэг юм уу, боомт дээр амьдардаг иргэдийн хувьд бас их тусдаа ийм бас шийдвэр болсон гэдгийг хэлмээр байна.

Таны хэлж байгаа бас энэ 2 дахь асуулт болох дээр дэд бүтэц хөгжсөн газрууд дээр энэ чөлөөт бүсийг байгуулах, тээвэр логистикийн төвүүд байгуулах гэдэг дээр бид бас тодорхой бодлогуудыг гаргаж байгаа. Саяын бас энэ тайланд дурдсанаар хуучин зөвхөн Замын-Үүд, Алтанбулаг дээр чөлөөт бүсүүдийг байгуулах шийдвэр олон улсдаа зөвшөөрүүлсэн байсан бол хуурай боомтыг байгуулах шийдвэрүүдийг дахиж нэмж 6 газар буюу нийтдээ 8 газар дээр бас энэ хуурай боомтуудыг бий болгох ийм шийдвэрийг оруулж өгсөн байгаа.

Тэгээд энэ чөлөөт бүс, хуурай боомт байгуулагдах нэг үндсэн нөхцөл нь нөгөө л бид нарын ярьдаг эрчим хүч, инженерийн байгууламж, ус татуургын байгууламж, дэд бүтэц байдаг. Энэ байгууламжид байхгүй чөлөөт бүсүүдийг төлөвлөөд зөвхөн хоосон хашаа татсан учраас сүүлийн бас энэ арваад жил Цагаан нуур дээр Баян-Өлгийн Цагаан нуур, Алтанбулаг, Замын-Үүд дээр байгаа чөлөөт бүсүүд маань үйл ажиллагаа нь идэвхжиж чадаагүй, үр дүн нь гараагүй ийм зүйл байгаа юм.

Тэгэхээр үүнийг дахиж давтахгүйн тулд бид нар хамгийн түрүүнд дулаантай болгох, эрчим хүчтэй болгох, устай болгох. Үүнийхээ хүрээнд энэ дотоод дэд бүтцийг шийдсэний хүрээн дээр хувийн хэвшлээ оруулж ажиллуулах ийм төлөвлөлтийг хийж ажиллах нь чухал юм байна лээ.

Замын-Үүдийн чөлөөт бүс дээр бас нэг алдаа гарсан нь Эрээний чөлөөт бүстэйгээ уялдуулж төлөвлөлтөө хийх ёстой байсан бол харамсалтай нь үүнийг бас хийж чадаагүй. Энэ бас ковидын үе таарсан учраас бас төрийн байгууллагууд хоорондоо уулзах бололцоо гараагүй гэдэг бас ийм тайлбар байдаг. Одоо үүнийг бол засаад харин Замын-Үүдийн чөлөөт бүсийг Эрээний чөлөөт бүстэй уялдуулаад хооронд нь яв цав үйл ажиллагааг нь зохицуулж чадсан ийм төлөвлөлтийг бол хийгээд эцэслэн гаргасан байгаа гэдгийг энэ ташрамд хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.9-д заасны дагуу намын бүлэг тус бүрээс 1 гишүүн төлөөлж Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулсан Ерөнхий сайдын мэдээллийн сэдэвтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн асуултыг Ерөнхий сайд, ажлын хэсгээс асууна.

Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийг төлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан асуулт асууна. Алга байна.

Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийг төлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга ажлын хэсгээс асуулт асууна. Уянга гишүүн.

Б.Уянга: Энэ өдрийн мэндийг хүргэе. Ди парламент. мн цахим системд ирүүлсэн иргэдийн асуултыг асууя. Тэгэхээр нийт 3 иргэнээс 5 асуулт ирсэн байна. Тэгэхээр үүнээс өмнө бас нэг зүйлийг тодруулаад, энэ асуултуудыг уншиж байхдаа төрсөн мэдрэмжээ хуваалцвал ер нь бол боомт, боомтууд сэргэж байж Монгол Улсад худалдааны эргэлт өснө. Дотоодод бий болох ажлын байр нэмэгдэнэ. Аялал жуулчлал дагаад өснө. Ер нь олон салбар цэцэглэнэ.

Тэгээд бид нар ер нь уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өндөр байгаа, зах зээл сайн байгаа үед боломжийнхоо хэрээр экспортлох юм бол бидэнд л ашигтай, хэрэгтэй гэдгийг бол ер нь бол тал талдаа ойлгож байгаа ийм дүр зурагтай байна.

Тэгээд асуултуудаа танилцуулахад Сарантуяагаас бол ийм асуултууд байна. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар, Хөшөөт, Бургастай, Шинэжинст, Шивээ хүрэн, Хотгор шанага, Даянгийн боомт зэрэг чиглэлд зам тавих төлөвлөгөө байгаа юу?

2 дугаар асуулт нь, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг ирэх 4 жилийн дотор 100 сая тоннд хүргэхээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан байна. Гэвч гол гол экспортын гарцууд ачаалалтай байгаа. Гол шийдэх бодлого нь төмөр замын хил холболтуудад найдаж байгаа хэдий ч өнөөдөр БНХАУ-ын талаас хил холболтын асуудалд нааштай хариу өгөөгүй байна. Тэгвэл авто замын бүтээн байгуулалтын ажлуудыг хэрхэн нэмэгдүүлэх вэ гэсэн байна.

3 дугаар асуулт, Тавантолгой, Цагаандэл уул чиглэлийн хүнд даацын авто замын бүтээн байгуулалтын асуудал яах вэ. Авто зам барих ажил иргэдийн эсэргүүцэлтэй тулгарч саатсан байгаа.

Иргэн Оюунтуяагаас Гашуун сухайт Ганц модны боомтыг төмөр замаар холбох асуудал 10 гаруй жил гацлаа. Энэ талаар хариулт өгнө үү гэсэн байна.

Мөнхжаргал, танд ажлын амжилт хүсье. “Шинэ сэргэлтийн бодлого”-оор яг юу юу шийдэж хэлэлцэх вэ гэсэн агуулга бүхий 5 асуулт байна. Энд холбогдох ажлын хэсгийн гишүүд хариулж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Буяагийн Тулга сайдын микрофоныг.

Асуулт, хариултын үргэлжлэх хугацаа 20 минут.

Б.Тулга: Иргэн Сарантуяагийн асуултад хариулъя. Тэгэхээр Хөшөөт, Бургастай, Шивээ хүрэн, Хотгор шанага, Даянгийн боомт гэсэн 3 боомт руу авто зам тавигдах уу гэж байх шиг байна.

Тэгэхээр авто зам тавигдах ТЭЗҮ-ийг, үндэслэлүүдийг бид нар бас боловсруулаад байгаа. Ер нь аливаа боомт руу авто зам тавих асуудлыг 2 талын худалдаа, аялал жуулчлал хэрхэн яаж хөгжих бололцоотой байна гэсэн энэ судалгааг үндэслэж бол хийж байгаа. Үүнийг хийхээс гадна энэ аливаа боомт руу хөрөнгө оруулалт хийж, дэд бүтцийг барихын тулд ТЭЗҮ, зураг дуусах ёстой. Тэгэхээр бид нар Шивээ хүрэн, Хөшөөт, Бургастай, Хөшөөтөөс Байтаг боомт руу хувийн хэвшлийн түншлэлтэй хамтраад, ТЭЗҮ, зургийг бол хийж байгаа гэдгийг хэлмээр байна. Даянгийн боомт руу мөн ялгаагүй зураг, төслийг хийгээд дууссан. Одоо Даянгийн боомтыг холбох энэ ажлыг хийж байгаа. Гэхдээ энэ Хотгор шанагатай холбоотойгоор Даянгийн боомт руу уул уурхайн бүтээгдэхүүн бас явуулахгүй. Яагаад гэвэл Даянгийн боомтын байрлал маань өөрөө Монгол Улсын хамгийн үзэсгэлэнтэй Алтай таван богдын тусгай хамгаалалттай газарт байдаг. Яг энэ дунд байгаа ийм боомт.

Тийм учраас энэ цаад талдаа ч гэсэн Шинжаан Уйгарын ӨЗО-ны Алтай аймагтаа илүү аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлэх ийм зорилготой боомт байгаа гэдгийг энэ ташрамд хэлье.

Тавантолгой, Цагаандэл уулын авто замын ажил явах уу гэж байна. Авто замын ажил явна. Түрүүн дурдсан авто замын ажил явахдаа байгаль орчинд хамгийн бага нөлөөлөлтэй, нөлөөлөл үүсгэхгүйгээр энэ авто замын бүтээн байгуулалтыг хийх ёстой. Ингэж чадах юм бол таны хэлж эхэлж асуусан 2 дахь асуултад гарч байгаа тэр манай уул уурхайн бүтээгдэхүүн 4 жилийн дотор 100 сая тонн хүрч, худалдаа хийж чадах уу гэдэг энэ асуултад бас хариулт болох учиртай. Өөрөөр хэлбэл Цагаандэл уулын боомт, Цагаандэл уулын зам орсноор бид нар БНХАУ дотор зөвхөн Баяннуур гэдэг нэг худалдан авагчаас дараачийн Рашаан аймгаар дамжиж, худалдаа хийх ийм худалдааны гарц нээгдэх ёстой юм байгаа юм. Ингэж чадах юм бол бид нар Эрдэнэс тавантолгойн үндсэн бүтээгдэхүүн болох нүүрс, эрчим хүчний коксын нүүрсийг 2 өөр худалдан авагчид бас үнэ хүргэн өрсөлдүүлэх ийм бололцоонууд бий болох юм гэдгийг энэ ташрамд хэлье.

100 сая тонн болохтой холбоотой өнөөдрийн байдлаар бид нар 2019 онд ер нь Монгол Улс түүхэндээ анх удаа 35 сая тонн нүүрс, нүүрсний чиглэлийн бүтээгдэхүүнийг БНХАУ-д боловсруулж, борлуулж чадаж байсан. Ингээд ковидын дараа үеэр бол энэ унасан. Ингээд 22 онд, 23 онд энэ дүнг 60 сая тоннд хүргэсэн. Энэ оны хувьд бид нар бас 80 сая тоннд, 69 сая тоннд хүргэсэн. Энэ онд бас 11-ээр нэмэгдүүлээд 80 сая тоннд хүргэхээр ажиллаж байгаа. Бид бас Хятадын талынхаа худалдан авагч талыг нэлээн сайн судалж үзсэн. БНХАУ ер нь нийт нэг жилийн хугацаанд ойролцоогоор 1 тэрбум тонн орчим нүүрсийг нийтдээ 8 улсаас импортолж авч хэрэглэдэг байгаа. Тэгэхээр бид энэ Монгол Улсаас нийлүүлж байгаа нүүрсний хэмжээг 120-140 сая тонн хүргэхэд Хятадын талаас ямар нэгэн квот гэдэг юм уу, хязгаарлалт тавихгүйгээр худалдан авах бололцоотой юм байна лээ. Гагцхүү бид нар энэ боомтууд руу тавигдах дэд бүтцээ сайн болгох, уул уурхайнхаа үйл ажиллагааг нэмэгдүүлэх, ингэхдээ мэдээж нутгийн иргэдэд байгаль орчинд нөлөөлөлгүй байхаар хийж чадах юм бол бидний энэ нүүрс худалдах, бүтээгдэхүүн худалдах энэ боломж боломжтой байгаа гэдгийг энэ ташрамд хэлье.

Хил холболтын төмөр замын асуудал дээр Дэлгэрсайхан сайд хариулах байх.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд асуултад хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Энэ Уянга гишүүний асуултад хариулъя. Их хэрэгтэй асуулт асуулаа. Ер нь бол Гашуун сухайт Ганц модны боомтын төмөр замыг холбох асуудал бол их 3 жил гаран бид ярьж байгаа. Тэгээд сүүлийн 3 удаагийн уулзалтаар ялангуяа сая өнгөрдөг 7 хоногт Ерөнхий сайд Шанхайн хамтын ажиллагааны орнуудын Ерөнхий сайд нарын уулзалтад явахдаа Бээжингээр дамжиж явахдаа энэ Чайна Энержи гэдэг компани дээр бид очиж уулзсан. Энэ компани жилдээ 960 саяас 1 тэрбум тонн нүүрс хэрэглэдэг ийм том компани юм байна. Тэгэхээр энэ компани бол энэ манай Гашуунсухайт Ганц модны Хятад талын холболтыг хариуцаж байгаа ганц компани.

Тийм учраас цаашдаа бид нар энэ компанийн асуудлаар Засгийн газраас энэ Засгийн газар дээрээ энэ асуудлаа шийдээд Их Хурал дээр оруулж ирнэ. Тэгэхээр энэ замыг холбоход бас манай Их Хурлын гишүүд бас дэмжлэг үзүүлнэ байх гэж бодож байна. Тэгж байж сая Уянга гишүүний ярьдгаар бид нарын нүүрс экспорт 100 сая тоннд хүрэх боломжтой. Бид нар аль болох стратегийн одоо ирээдүйн хамтрагч, олон жилийн хугацаандаа их хэмжээний нүүрс авах ийм ач холбогдолтой. Ийм төмөр замын холболт болоод авах компаниудтай холбогдож ажиллаж байгаа. Үүнийхээ үр дүнг удахгүй үзнэ ээ гэдэгт итгэлтэй байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цагаан дэл уул чиглэлийн авто зам, хүнд даацын авто замын талаар асуулт ирсэн байгаа.

Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Цагаандэл уулын авто замын талаар бол өнгөрсөн 7 хоногт Засгийн газрын тэргүүнээс үүрэг өгсний дагуу Эрдэс баялгийн яам болон ЗТЯ-наас ажлын хэсэг гараад, Цагаандэл уулын боомт руу ажлын хэсэг гараад өнөөдрийн байдлаар ажиллаж байна. Тэгээд энэ яваад ажлын хэсэг дүгнэлтээ гаргасны дараа сая Боомтын сайд Тулга сайдын ярьснаар бол авто зам болоод ийшээ төмөр зам тавих асуудал яригдаж байгаа. Үүнийг хэрвээ эхлээд дэд бүтцээ хийчихвэл дараа нь нээнэ ээ гэдэг асуудал дээр энэ асуудал яригдаж байгаа гэдэг энэ ташрамд хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо.

17.05 цаг.

Дараагийн асуудалд оръё.

8 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит бус чуулганы хуралдаан дээр эцсийн найруулга сонсох байсан тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

“Төрийн өмчийг нийслэлийн өмчлөлд шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёслохыг зөвшөөрнө гэж заасны дагуу Төсвийн байнгын хороо Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуультай хамт баталсан “Төрийн өмчийг нийслэлийн өмчлөлд шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг бэлтгэж, Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулахаар тараасан байгаа.

Тэгээд уг асуудалтай холбогдуулан Хууль зүйн сайд Алтангэрэл, Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар нар Засгийн газрыг бас ТУЗ-ийн тодорхой шийдвэрийг гаргаж, эргүүлж оруулж ирсний үндсэн дээр эцсийн найруулгыг сонссонд тооцох ёстой гэсэн санал гаргасан.

Ингээд ЗГХЭГ-аас бичиг ирсэн учраас уг асуудлыг сонссонд тооцохоор байгаа.

Тэгээд “Төрийн өмчийг нийслэлийн өмчлөлд шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

17.07 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ